



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2022 ОНЫ 11 ДҮГЭЭР САРЫН 25-НЫ ӨДӨР, БААСАН ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
НЭГДСЭН ХУРАЛДААН



ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

*Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах
QR кодыг уншуулан танилцах боломжтой.*

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл:

1-6

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:

7-99

1.Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

2.Кадасртын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

3.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

4.Нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

**Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын
ээлжит чуулганы 11 дүгээр сарын 25-ны өдөр
/Баасан гараг/-ийн нэгдсэн хуралдааны
товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 76 гишүүнээс 39 гишүүн хүрэлцэн ирж, 51.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 41 минутад Төрийн ордны “Их хуралдай” танхимд эхлэв.

Томилолттой: А.Адъяасүрэн, Т.Аубакир, Э.Бат-Амгалан, Ж.Батсуурь, Б.Баттөмөр, Ж.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, С.Бямбацогт, Д.Ганбат, Х.Ганхуяг, Г.Дамдинням, Б.Дэлгэрсайхан, Ц.Идэрбат, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Х.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Б.Пүрэвдорж, Ц.Сандаг-Очир, Д.Сарангэрэл, Ц.Туваан, Г.Тэмүүлэн, Ч.Хүрэлбаатар, Д.Цогтбаатар, Ц.Цэрэнпунцаг, Б.Энхбаяр, Н.Энхболд, Т.Энхтүвшин;

Чөлөөтэй: Д.Батлут;

Эмнэлгийн чөлөөтэй: С.Амарсайхан, Д.Өнөрболор;

Хоцорсон: С.Батболд- 13 минут, Ж.Мөнхбат- 14 минут.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасны дагуу Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатараас 2022.11.24-ний өдөр ирүүлсэн албан бичгийг танилцуулж, Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар үг хэлэв.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Дархан арьс ширний цогцолборын үйл ажиллагааны талаар” тавьсан асуулгын хариуг сонсох асуудлыг хойшлуулах тухай албан бичиг ирүүлснийг танилцуулж, хэлэлцэх асуудлын дарааллаас хасав./11:49/

Нэг.Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, мөн газрын ахлах шинжээч Г.Болормаа, шинжээч Б.Гоёсайхан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газрын дарга

Р.Ганхуяг, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа, Хяналт шалгалт, үнэлгээний газрын дарга Ц.Батбаатар нар байлцав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Ж.Батжаргал, М.Оюунчимэг, Н.Ганибал, Т.Доржханд, С.Ганбаатар нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 13 цаг 01 минутаас хуралдааныг даргалав.

Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар завсарлага өгөв./13:11/

Үдээс өмнөх хуралдаан 1 цаг 30 минут үргэлжилж, 13 цаг 11 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 09 минутад эхлэв.

Хоёр.Кадастрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн,

мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, мөн газрын ахлах шинжээч Г.Болормаа, шинжээч Б.Гоёсайхан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, С.Ганбаатар, Э.Батшугар, Г.Ганболд, Ж.Батжаргал, Ш.Адъяаа, Н.Ганибал нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн С.Ганбаатар, Ж.Батжаргал, Л.Мөнхбаатар нар үг хэлэв.

Кадастрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 4 өдрийн завсарлага өгөв./15:41/

Уг асуудлыг 15 цаг 42 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, мөн газрын ахлах шинжээч Г.Болормаа, шинжээч Б.Гоёсайхан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Ганибал нар танилцуулав.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 16 цаг 02 минутаас хуралдааныг даргалав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Баделхан, Х.Болорчулуун, С.Ганбаатар, Н.Наранбаатар, Ж.Батжаргал, Н.Ганибал, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай нар хариулж, тайлбар хийв.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь

Монгол Ардын намын бүлгийн дарга Д.Тогтохсүрэн ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 4 өдрийн завсарлага өгөв./16:49/

Уг асуудлыг 16 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Дөрөв.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Улсын Их Хурлын гишүүн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж, Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Ц.Баярбат, мөн газрын ахлах шинжээч Г.Болормаа, шинжээч Б.Гоёсайхан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, мөн газрын Захиргаа, удирдлага хамтын ажиллагааны газрын дарга Р.Ганхуяг, мөн газрын ахлах мэргэжилтэн Д.Энхтуяа, Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Ц.Ихбаяр, Кадастрын хэлтсийн дарга П.Баянтүмэн, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, мөн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Э.Цолмонжаргал, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Н.Бямбадорж, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Ашигт малтмал, газрын тосны газрын Хуулийн хэлтсийн дарга Р.Энхтайван, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Г.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Баярсайхан, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, референт Г.Хоролмаа нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн, Г.Ганболд, С.Ганбаатар, О.Цогтгэрэл нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга А.Энхманлай, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн дарга Б.Нямдорж нар хариулж, тайлбар хийв.

Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн тухай асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгийн дарга О.Цогтгэрэл ажлын 5 өдрийн завсарлага авах тухай мэдэгдэж, уг асуудлаар ажлын 4 өдрийн завсарлага өгөв./17:35/

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа Засгийн газраас 2022.11.22-ны өдөр өргөн мэдүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, мөн Засгийн газраас 2022.11.12-ны өдөр өргөн мэдүүлсэн Зөвшөөрлийн тухай хуулийн төслийг шинэчилсэн найруулгад нийцүүлэх, хуулийн давхардал, нийцэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийг Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсныг танилцуулав./17:37/

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 4 асуудал хэлэлцэв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Н.Наранцогт, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, Ш.Мөнхцоож нар хариуцан ажиллав.

Хуралдаан 4 цаг 59 минут үргэлжилж, 76 гишүүнээс 44 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр 17 цаг 38 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Их хуралдай” танхим
11 цаг 41 минут.

НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Г.Занданшатар: Гишүүдийн өдрийн амгаланг айлтгая.

Гишүүдийн ирцийг танилцуулъя. Ирвэл зохих 40 гишүүнээс 38 гишүүн ирж ирц бүрдсэн байна.

Гадаад, дотоодод томилолт, гадаад томилолттой 19 гишүүн, 20 гишүүн, орон нутагт томилолттой 15 гишүүн, өвчтэй, чөлөөтэй 3 гишүүн байна.

Ингээд ирц бүрдсэн учраас УИХ-ын 2022 оны намрын ээлжит чуулганы 11 дүгээр сарын 25-ны өдрийн нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Газрын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг 2022 оны 6 дугаар сард өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ. Өнгөрсөн хуралдаан дээр хууль санаачлагч, сайдыг иртэл гээд түр

хойшлуулсан учраас эхний ээлжид хэлэлцэнэ гэж шийдвэрлээд даргын тэр зөвлөлөөс хойшлуулсан юм байна, одоо эхний ээлжид хэлэлцэнэ.

Энэ хуультай холбоотой хамт өргөн мэдүүлсэн Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

Гуравдугаарт, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

Дөрөвдүгээрт, Нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

Газрын төлбөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд,

Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,

Долоодугаарт, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд, эцсийн хэлэлцүүлэг,

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл,

Есдүгээрт, Хот, суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл,

Аравдугаарт, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд.

Үдээс хойших нэгдсэн хуралдаанаар Монгол УИХ-ын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Монгол Улсын Ерөнхий сайдад хандаж “Дарханы арьс ширний цогцолборын үйл ажиллагааны талаар” тавьсан асуулгын хариуг сонсоно.

УИХ-ын гишүүн УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлын тов, дарааллыг өөрчлөх, асуудал нэмэх, горимын санал гаргах бол чуулганы нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнөх өдрийн 17 цагаас өмнө УИХ-ын даргад үндэслэл бүхий саналаа бичгээр ирүүлнэ гэж заасны дагуу Монгол УИХ-ын гишүүн Сайнхүүгийн Ганбаатараас албан бичиг ирүүлсэн байна, өчигдөр.

УИХ-ын дарга Гомбожавын Занданшатар танаа. Миний бие 2022 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан асуудал хасах үндэслэл бүхий санал, үг хэлэх хүсэлтэй байгаа тул зохих журмын дагуу зөвшөөрөл олгоно уу. Хүндэтгэсэн УИХ-ын гишүүн Сайнхүүгийн Ганбаатар гэсэн байна.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлнэ.

С.Ганбаатар: *УИХ-ын дарга аа, Газрын ерөнхий хууль ид хэлэлцэж байна, хэлэлцэх эсэхийг нь шийдэхээр бид ярилцаж байна. Энэ бол Үндсэн хуулийн дараа ордог хамгийн чухал хуулийн нэг. Энэ бол Тусгаар тогтнолын тухай хууль. Газрын тухай хууль гэдэг бол маш чухал хууль. Өнгөрсөн 30 жил бид үндсэндээ газар яаж зардаг вэ, яаж дампуурч болдог вэ гэдгийг л харуулсан гурван 10 жил болсон. Улаанбаатар хотын газрыг хар, доороо газрын баялагтай газруудаа бас лиценз хэлбэрээр зарсан, үүнийгээ засаж өөрчлөх боломж гэж харж байна. Бүх улс орон даяараа, бүх гишүүд энэ дээр онцгой анхаарч, Газрын тухай хууль дээрээ ач холбогдол өгч оролцъё. Үүний тулд нөгөө гуя дагаж хүзүү гэдэг шиг зарим хуулийн төслийг энэ хэлэлцэх хэсгээс хасаад өгөөч. Урьд нь би хэлсэн, Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг энэ хэлэлцэх асуудлаас хасаж өгөөч. Яагаад гэвэл удаа дараа би хэлж байгаа юм, надад ямар ч өөр ашиг сонирхлын зөрчил байхгүй.*

Эх орны эрх ашгийн төлөө энэ 7.2 заалт бол яг ҮАБЗ-тэй холбоотой зөвлөлөөр ярилцах ёстой асуудал. Бид жижиглэнгийн худалдаандаа нефть, энэ газрын тосны материалууд дээр жижиглэнгийн худалдааг хөрш орнуудынхаа төрийн оролцоог оруулж болохгүй ээ гэдэг ийм байр суурийг 7.2 үндэсний аюулгүй байдлын заалт орчихсон байгаа. Энэ заалтыг хэлэлцэх үедээ ҮАБЗ-өөр хэлэлцүүлээд өгөөч ээ л гэдгийг би дахин дахин хэлж байгаа юм. Түүнийг хүртэл энэ асуудлыг энэ хэлэлцэх дарааллаас хасаад өгөөч.

Хоёрдугаарт, дэлхий дээр Украин, Оросын дайны гал ид дүрэлзэж байна. Түүгээр явсан гайг үүгээр дуудав гэдэг шиг энэ асуудлыг заавал өнөөдөр хэлэлцэх гээд чичрээд байгаагийн учир юу вэ. Хэлэлцэх асуудлаас нь хасаад тухтай ярилцаад ҮАБЗ-өөр ярилцаад, шинжээч холбогдох экспертүүдтэй нь зөвлөлдөж байж оруулж ирэх ёстой.

Дөрөвдүгээрт, миний хэлэх гол асуудал бол ер нь аливаа асуудлыг аливаа хуулийг оруулж ирэхдээ энэ хуулиас болж үндэсний бизнес эрхлэгчдийн эрх ашиг зөрчигдөх үү, үгүй юу гэдгийг ярилцдаг хууль, эрх зүйн орчин бидэнд байгаа шүү дээ. Олон мянган ажлын байрыг тэд нар бас аваад нуруун дээрээ үүрээд явж байгаа.

Ингээд үндэсний бизнес эрхлэгч нартайгаа яг энэ Газрын тосны бүтээгдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиа хэлэлцсэн үү, ярьсан уу. Миний ойлголтоор бол тэдэнтэй зөвлөлдөж, ярилцаж, ойлголцоогүй гэж бодож байна.

Энэ 4 шалтгаанаар энэ хуулийн төслийг хэлэлцэх асуудлаас хасаж өгнө үү гэдэг ийм байр суурь саналтай байна, дэмжиж өгнө үү.

Г.Занданшатар: *Ганбаатар гишүүн үг хэллээ. Газрын тухай хуулийг бол эхний багц хуульд ингээд даргын дэргэдэх зөвлөлийн гишүүдийн саналаар орсон байгаа. Угаасаа хуулиараа энэ чинь үргэлжлүүлэн хэлэлцэх ёстой.*

Газрын тосны тухай хуулийн асуудлыг, горимын саналыг тухайн үед нь хэлэлцье.

Өнөөдөр бол бас олон чухал асуудалтай учраас өнөөдөр хэлэлцэх бол тухайн үед нь хэлэлцье.

Ингээд хэлэлцэх асуудалд орно.

Хэлэлцэх асуудалд орохын өмнө нэг асуудал хасах шиг хэрэгтэй байгаа. УИХ-ын гишүүн Баттөмөрийн Ерөнхий сайдад хандаж тавьсан асуулгын хариуг үдээс хойших нэгдсэн хуралдаанаар сонсохоор төлөвлөсөн боловч УИХ-ын гишүүн Баагаагийн Баттөмөр гишүүнээс албан бичиг ирүүлсэн байна.

УИХ-ын дарга Гомбожавын Занданшатар танаа. УИХ-ын гишүүн миний бие 22 оны 7 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Ерөнхий сайдад хандан Дарханы арьс ширний цогцолборын үйл ажиллагааны талаар асуулга тавьж, хариуг авсан. Уг хариуг УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсож өгөх тухай хүсэлтийг танд тавьсны дагуу энэ 7 хоногийн хуваарьт орсон байна. Гэвч миний бие Бүгд Найрамдах Албан Улсын парламент дахь Албани-Монголын парламентын бүлгийн даргын хуваарь 22 оны 11 дүгээр сарын 24-ний өдрөөс 22 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн хооронд албан томилолтоор явах болсон тул миний тавьсан асуултын хариуг сонсохыг хойшлуулж өгөхийг хүсье гэсэн ийм бичиг ирүүлсэн УИХ-ын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс.

Ингээд УИХ-ын гишүүн Баагаагийн Баттөмөрөөс Дарханы арьс ширний цогцолборын үйл ажиллагааны талаар тавьсан асуулгын хариуг өнөөдрийн нэгдсэн

хуралдааны хэлэлцэх асуудлын дарааллаас хойшлуулж байна.

Хэлэлцэх асуудалдаа оръё, дараагийн асуудалд оръё. Хэлэлцэх асуудал.

Нэг.Газрын ерөнхий хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжлэл/

Асуулт хариулт явж байгаад завсарласан.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Хаянгаагийн Болорчулуун, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ, Барилга, хот байгуулалтын яамны ТНБД Сандагийн Магнайсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны ТНБД Пүрэвжавын Сайнзориг, ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цогтын Баярбат, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга Анандын Энхманлай, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газрын дарга Раднаабазарын Ганхуяг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга Цэвэлмаагийн

Энхбаяр, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Баянтүмэн, ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Батдэлгэрийн Нямдорж, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл, АМГТГ-ын Хуулийн хэлтсийн дарга Рагчаагийн Энхтайван, Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга Ганболдын Батзориг, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Гомбодоржийн Болормаа, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Базарпүрэвийн Гоёсайхан, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн Дэндэвийн Энхтуяа, ХХААХҮЯ-ны МАА-н бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Найдангийн Бямбадорж. Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

УИХ-ын гишүүд хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан үргэлжлүүлэн асуулт асууна.

Асуултаас бол өнөөдөр байхгүй байгаа Даваажанцангийн Сарангэрэл, Тилеуханы Аубакир, Баагаагийн Баттөмөр, Жадамбын Бат-Эрдэнэ, Цагаанхүүгийн Идэрбат, Дашдондогийн Ганбат нарыг хасна.

Асуулт асуух хүсэлт ирүүлсэн гишүүдээс нөхөж бол Лхагвын Мөнхбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Энхбаярын Батицугар, Цогт-Очирын Анандбазар, Хавдисламын Баделхан, Салдангийн Одонтуяа, Сайнхүүгийн Ганбаатар нар нэмэгдэх нь байна.

Асуулт хариултад оръё. Содномын Чинзориг гишүүн.

С.Чинзориг: Хэдэн зүйл тодруулъя. Сүүлийн жилүүдэд энэ төрийн өмчийн газрыг бусдад шилжүүлсэн, хууль бусаар ашигласан гэдэг асуудал маш их гардаг. Тэгэхээр та бүхэнд судалгаа байна уу, үгүй юу. Төрийн өмчит байгууллагуудын хэчнээн га газрыг хууль зөрчиж бусдад шилжүүлсэн, зориулалт бусаар ашигласан тийм судалгаа гэж юм байна уу, үгүй юу. Түүнийг засах талаар ямар арга хэмжээ авч байгаа вэ?

Ер нь цаашидаа энэ төрийн өмчийн байгууллагуудын сургууль, эмнэлгийн газрыг ингээд зориулалт бусаар ашигладаг, бусдад эзэмшүүлдэг ийм асуудлыг энэ хуулиар бас хорьж байгаа юм байна уу, үгүй юу, хязгаар хийж байгаа.

2 дахь асуудал нь тусгай хамгаалалттай газарт зориулалт бусаар бас газар авсан асуудал, зориулалт бусаар ашигласан гэдэг асуудал маш их гарах юм. Байгаль орчны яам дээр тийм судалгаа байна уу, үгүй юу. Улсын хэмжээгээр энэ тусгай хамгаалалттай газарт гэрээгээрээ төсөл хэрэгжүүлнэ гэж газар эзэмших газар авчхаад, түүнийгээ зориулалтаар ашиглаж байгаа, бусдад шилжүүлж байгаа тийм асуудал байдаг юм уу? Улсын

хэмжээгээр нэг тусгай хамгаалалттай газар эзэмшиж байгаа газрыг зориулалт бусаар ашиглаж байгаа хэчнээн хэмжээний га газрууд байна уу, үүнийг засах талаар ямар арга хэмжээ авч, цаашидаа тусгай хэрэгцээний хамгаалалттай газарт ингээд газар эзэмших эрх аваад зориулалт бусаар ашиглуулахгүй байх асуудлыг хэрхэн яаж засаж сайжруулах юм бэ? Энэ хуульд ямар заалт бол орж байгаа гэж.

3 дахь асуудал нь газар өмчлүүлэх тухай хууль хэрэгжээд олон жил боллоо. Энэ хуулийн хэрэгжилт ямар үр дүнтэй байна вэ? Миний авч байгаа мэдээллээр нэг иргэдийн бараг 20 орчим хувь нь л газар өмчлөх хуулийн дагуу газраа өмчилсөн гэдэг ийм л судалгаа байх шиг байгаад байгаа юм. Энэ нь юутай холбоотой байна вэ? Эдийн засгийн эргэлтэд орохгүй байгаатай холбоотой, төв суурин газарт бол иргэд газар өмчлүүлэх хуулийн дагуу газар байх сонирхол байдаг байх.

Хөдөө суманд байгаа жижиг говийн сумдад байгаа иргэд сумандаа газар авна, өмчлүүлнэ гэдэг асуудал бол сонирхол их багатай байх шиг байгаа юм. Энэ газар өмчлүүлэх хуультай холбоотойгоор өөрчлөлт орж байгаа юм байна уу, үгүй юу? Иргэд чинь хамгийн гол нь дэд бүтэцтэй газар л газар авах сонирхолтой байгаад байгаа шүү дээ. Газар эдийн засгийн эргэлтэд оруулах сонирхолтой байдаг. Энэ сонирхлыг нь яаж төрүүлэх юм.

Ер нь энэ газар өмчлөл хуульд иргэддээ төр ижил тэгш, боломжийг нь олгох талаар яам юу хийж байна вэ, энэ хуульд шинээр орж байгаа

ямар зохицуулалт, боломжууд бол байна уу гэж.

Дараагийн асуудал энэ бэлчээртэй холбоотой асуудал. Яах вэ, энэ ерөнхий хуульдаа бол энэ газрыг ашиглах, хамгаалах гээд асуудал орж ирсэн байна. Би бол бэлчээрийнхээ хуулийг ерөнхий хуулийг оруулж, хамт оруулж ирээд энэ бэлчээртэй холбоотой асуудлыг цэгцлэх ёстой юм болов уу гэж бодоод байгаа юм. Ер нь сүүлийн жилүүд энэ байгалийн ган зуд чинь маш их, давтамжтай болчихлоо, ойрхон. Энэ хуучны зарчмаар хаяа багтвал бууж, хамар хатгавал иднэ гэдэг зарчмаар чинь МАА-н үйлдвэрлэл чинь явах боломжгүй болчихлоо шүү дээ. Үүнтэй холбоотойгоор бэлчээрийн хуульд өөрчлөлт оруулахгүй юм уу, бэлчээрийг хуваарьтайгаар ашиглахтай холбоотой харилцааг шинээр нээж өгөх үү? Энэ хуулийн төсөл чинь бол яах вэ дээ, аймаг дундын, сум дундын бэлчээрийн нөөц газар бий болгоно л гэж л байна. Одоогийн практикаар бол аймаг дундын нөөц чинь нэг, 3 дөрөвхөн л газар байгаа шүү дээ. Тэнд чинь дандаа энэ төв суурин газрын, нөгөө фермерийн аж ахуйнууд нь орчихсон, төв суурин газар уяачдын хамаг мал орчихсон, хөдөөгийн энгийн жирийн иргэд, малчид орж чаддаггүй шүү дээ. Тийм учраас бол бэлчээрийг зүй зохистойгоор ... /минут дуусав/

Г.Занданшатар: Мөнхбаатар сайд 81. Бэгзжавын Мөнхбаатар сайд.

Б.Мөнхбаатар: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Газрын тухай хууль хэрэгжээд ирсэнтэй холбоотой өнгөрсөн жилүүдэд газрын

харилцаа, ялангуяа төрийн өмчийн сургууль, цэцэрлэг, төрийн өмчийн байгууллагуудаас газрыг шилжүүлэх байдлаар янз бүрийн асуудлууд гарсан асуудлуудыг бол хөндөж асууж байна. Ер нь бидний хийсэн судалгаагаар нэг сүүлийн жилүүдэд 106 гаруй газар шилжүүлсэн гэсэн тооцоо байдаг. Ингээд сургууль, цэцэрлэгүүдийн газруудаас тухайн сургуулийн захирлын зөвшөөрөлтэйгөөр газрын албанд хандаж юм уу, эмнэлгийн байгууллагын даргын зөвшөөрлөөр хандаж газрыг гаргасан тохиолдолд бол өнгөрсөн хугацаануудад байсан. Одоо бол бидний зүгээс бол үнэндээ Улаанбаатар хотод ч, бол газар ч байхгүй болсон. Ер нь бидний хувьд, энэ оруулж ирж байгаа хууль дээр бол энэ асуудлыг бол цэгцэлж байгаа, өөрөөр хэлбэл сая ч гэсэн бид нар ЗГ-ын хуралдаанаар боловсролын байгууллагуудын газрыг нэгдсэн кадастрт оруулж, тэндээ шилжүүлэх асуудлуудыг бол хориглосон. Эрүүл мэндийн байгууллагуудыг бид нар бас ингэж хориглосон. Үүнтэй холбоотой ТӨК-уудын газрыг эд нар бид нар бас бүгдийг нь бүртгэлжүүлж, кадастрт оруулж, тэр асуудлуудыг өөр ААН, иргэнд шилжүүлэх асуудлуудыг бид нар бол хориглож байгаа.

Газар өмчлөлийн тухай хууль хэрэгжээд ирсэнтэй холбоотойгоор бас таны хэлж байгаа асуудлууд бас зөв байгаад байгаа юм. Ингээд хорь гаруй хувь нь л 600 гаруй мянган л иргэн газрыг өмчилж авсан байгаад байгаа юм. Тэгээд газрын өмчлөлийг харахад бол яг сумын төвийн тул тэртээ тэргүй хашааны газраа аваад байж байгаа иргэд маань нэг дахиж өмчилж явах хандлага багатай, аймгийн төвд болохоороо дэд бүтэц багатай учраас бас хүмүүсийн бас

сонирхол нь бага байдаг. Улаанбаатар хотын хэмжээнд хүн амын төвлөрөл их болчихсон хэр нь өмчлөх газрыг олгож байгаа газрууд нь, тухайлбал нэлээн хэдэн жилийн өмнө дуудлага цахимаар өгсөн газрууд нь дандаа Улаанбаатар хотоос алслагдсан дэд бүтэц байхгүй, зам тээвэр байхгүй, худаг ус байхгүй гээд, тэгэхээр яг эдийн засгийн эргэлтэд орж ашиглах тал нь бага байгаад байдаг.

Тэгэхээр бид нар энэ газар өмчлөлийн тухай хуульдаа Монгол Улсын иргэн гээд хүүхэд хүртэл өмчилдөг байсан бол бид нар 18 нас гэж оруулж ирж байгаа. Мөн газар өмчлөлийг бид нар үргэлжлүүлэхдээ аль болох дэд бүтэцтэй нь уяж холбож эдийн засгийн эргэлтэд оруулах чиглэлээр нь хангуулж өгөхгүй бол энэ олон жил болгоод хэрэгжилт нь бага байгаа үндсэн шалтгааны нэг ээ гэж бол бидний хувьд бол үзэж байгаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн тодруулна. Тусгай хамгаалалттай газар бэлчээр ашиглах, бэлчээрийн хураамжтай холбоотой асуудал байсан 83 Магнайсүрэн дарга.

Чинзориг гишүүний асуултад хариулъя, Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн. Бэлчээрийн асуудлаар ер нь бол бэлчээртэй холбоотой 2007 оноос 17, 8 он хүртэл 7 тийм бие даасан хуулийн төсөл санаачилж бас явж байсан юм байна лээ. Бэлчээрийн тухай, бэлчээр хамгаалах тухай, бэлчээр ашиглалтын тухай гэсэн ийм нэртэй, хамгийн сүүлд бол 17 оны сүүлээр бас нэр бүхий гишүүд Бэлчээр хамгаалах тухай хуулийн төсөл боловсруулаад

Их Хурлын цахим хуудсанд байршуулаад ингээд санал авч байсан, ийм бас ийм түүхэн юу байна лээ. Ингээд бид нар энэ бэлчээртэй холбоотой асуудлыг тусгайлан энэ ХХААХҮЯ-тайгаа хамтраад, Хууль зүйн яамтайгаа хамтраад ажлын хэсэг багагүй хугацаанд сууж ажиллаад ямар байдлаар энэ концепт оруулж ирж байгаа вэ гэх зэрэг бэлчээрийн бие даасан хуулийн төслийг бол үүгээр энэ удаад энэ газрын ерөнхий хуулийн төсөлтэй хамт оруулж ирэх бол бололцоогүй байна. Энэ хуульдаа бол бэлчээртэй холбоотой ерөнхий зохицуулалтаа хийгээд, тэгээд бэлчээр ашиглалттай холбоотой ЗГ-ын журам гаргаж зохицуулья гэдэг дээр бид нар тохирч орж ирсэн. Өмнөх хуулийн төслүүд дээр хамгийн сүүлд 19 онд ҮАБЗ-ийн ажлын албанаас бас 15 шинжээч баг, шинжээчийн баг томилогдоод дүгнэлт гаргасан байдаг юм байна лээ. Энэ дүгнэлтээр бол ер нь энэ уламжлалт нүүдлийн МАА-н асуудал дээр бол нэлээн нухацтай хандаж авч үзэх шаардлагатай. Тухайн үеийн боловсруулсан тэр хамгийн сүүлийн хуулийн төсөл энэ тэр дээр бол энэ бол энэ шууд бэлчээрийг эзэмшүүлэх, энэ хуваарьт оруулж эзэмшүүлж гэрээгээр юу яах бололцоогүй юм. Энэ нь бусад улс оронд хэрэгжсэн зарим сөрөг үр дагаврыг шууд манай улс оронд авчрах ийм эрсдэлтэй юм байна гэсэн ийм үнэлгээ, дүгнэлт бас өгсөн байдаг юм байна лээ. Үүнийг бол бид нар бас харгалзаж үзэж, энэ хуулийн төслөө боловсруулж оруулж ирсэн.

Бэлчээртэй холбоотой асуудал бол ерөнхийдөө сум орон нутаг, баг, сумын хэмжээнд голчлон асуудал нь шийдэгддэг учраас сум, багийн Засаг дарга нар, иргэдийн хурал, ИНХ, тэгээд иргэдийнх нь түвшинд энэ

асуудлыг авч үзэх ийм зохицуулалт бол ер нь орж ирсэн. Өөрөөр хэлбэл бэлчээрийн асуудлыг дээш нь татаж хуульчлах, захиргааны аргаар асуудлыг шийдэх тусам илүү сөрөг үр дагавар гарч болзошгүй гэсэн ийм эрсдэл байсан. Тийм учраас бид нар энэ газар зохион байгуулалтынхаа төлөвлөгөөнүүдийнхээ хүрээнд холбогдох холбогдох байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэг, эрх хэмжээг нь бол тусгайлан оруулсан. Тухайлах юм бол энэ бэлчээртэй холбоотой журам гаргана. Тэгээд гэнэтийн буюу давагдашгүй хүчний шинжтэй нөхцөлд тухайн аймаг, сумын нутаг дэвсгэрт нүүдэллэх шаардлага гарсан тохиолдолд тухайн шатны Засаг дарга нар шийдвэрлэнэ. Шийдвэрлэж чадаагүй бол дээд шатны Засаг дарга буюу ЗГ хүртэл асуудлыг шийдвэрлэж байхаар бид нар өнөөдрийн бас үүсээд байгаа нөхцөл байдлыг зохицуулах, энэ хүрээнд зохицуулах шаардлагатай гэж ингэж үзсэн.

Гэрээгээр бол зөвхөн отрын нөөц бэлчээрийг л гэрээгээр ашиглана, бусдыг нь бол нийтээр ашиглана гэсэн ийм концепц орж ирсэн байгаа.

Г.Занданшатар: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд 80. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Чинзориг гишүүний асуултад хариулъя. Одоогийн байдлаар тусгай хамгаалалттай газар нутгуудын хувьд бол хамгийн их зөрчилтэй нь бол Богд хан уулын дархан цаазат хамгаалалтын бүс. Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт бол хамгийн их зөрчил байдаг. Богд хан уулын хувьд бол нийтдээ 42 орчим

мянган га талбайг Юнескод албан ёсоор бүртгэж авсан. Онгон бүсэд бол 6921,66 буюу нийт хамгаалалтын 16,3 хувь, хамгаалалтын бүсэд 28490 га буюу нийт талбай нь 67,3 хувь, хязгаарлалтын бүсэд бол 6859 га буюу 16,2 хувь нь хамаардаг.

Өнгөрсөн хугацаанд бол энэ Богд хан уулын дархан цаазат газрын хамгаалалтын хязгаарлалтын бүс дээр бол нийтдээ 3176 байшин барилга баригдсанаас 86,38 хувь нь буюу 2743 байшин нь бол нам давхар барилга, 13,6 хувь буюу 433 байшин нь бол өндөр барилга байгууламж баригдсан. Энэ өндөр барилга байгууламж баригддагийн хувьд бол 2013 оны УИХ-ын 23 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлагын баримт бичиг батлагдсанаар суурьшлын бүсийг бий болгосон байдаг.

Хууль бус зөрчилтэй холбоотой асуудал дээр бол 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар бол Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 72 удаагийн тушаалаар нийтдээ 159 нэгж талбар, 422,3 га газрын ашиглах эрхийг хүчингүй болгож шийдвэрлээд байгаа. Ялангуяа АТГ-ын мөрдөгчийн ирсэн мэдэгдлийн дагуу зориулалтын бусаар олгогдсон нийтдээ 311 иргэн, ААН этгээдтэй холбоо бүхий газрын зориулалтыг бол өөрчлөх ийм мөрдөгчийн мэдэгдэл ирсэн. Үүний дагуу өнгөрсөн хугацаанд бол тухайн 311 иргэн, ААН этгээдийн зориулалтын дагуу болгож өөрчилсөн байгаа.

Зориулалтын бус гэдэг нь бол манай тодорхой үе үеийн сайд

нартай холбоотой буюу аялал жуулчлалын чиглэлээр олгох ёстой байтал зуслангийн, амины гэдэг ийм зориулалтаар газар олгосонтой холбоо бүхий асуудлууд байдаг юм.

Ер нь бол цаашидаа Байгаль орчин, аялал жуулчлалын яамны хувьд бол нийт тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг бол бид нар 30 хувьд 2030 он хүртэл хүргэх ийм зорилттой ажиглаж байгаа. Одоо бол нийт газар нутгийн бол 21хувь буюу 32,7 сая га талбайг бол тусгай хамгаалалтад аваад байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Содномын Чинзориг гишүүн тодруулж асууна.

С.Чинзориг: Би бол яах вэ, энэ хуульд тэр отрын бүс нутгийн зохицуулалттай холбоотой юмнууд байна лээ л дээ. Тэгээд яг үүгээрээ бол нэг асуудал шийдэхгүй бол гэж л хараад л байгаа юм. Одоо орж ирж байгаа хуулиар чинь бол отрын нөөц бэлчээрийг, аймаг дундын, сум дундын, сумын гээд ингээд бий болгох л юм байна л даа. Одоогийн байгаагаар чинь аймаг дундын отрын нөөц бэлчээр чинь улсын хэмжээгээр нэг 4 тавхан газар байдаг шүү дээ. Тэнд чинь энэ мал чинь багтдаггүй юм шиг байгаа юм. Тэгээд дандаа энэ фермерийн аж ахуйтай улсууд нь орчихсон, хотын хамаг уяачид нь тэр отрын чинь бүс нутагт орчихсон, тэгээд энэ жирийн иргэдэд орж чадахгүй л байх асуудал байгаад байгаа шүү дээ.

Тэгэхээр нийт бэлчээртэй, тэр бэлчээрийг хуваарьтайгаар ашиглах асуудлыг бид бас хөндөхөөс л өөр үгүй.

2 дахь асуудал нь ер нь энэ улсын тусгай хэрэгцээнд газар авах, хайгуулын тусгай зөвшөөрөл энэ тэр авахад энэ орон нутгийн удирдлагуудын эрх мэдлийг бид нар яаж хангаж өгөх юм бэ? Манай Богд сум гэхэд бараг газрын тосны хайгуул гээд бараг нутаг дэвсгэрийн 80 хувь нь хам ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах юм, Сандагийн Магнайсүрэн, ТНБД 83.

С.Магнайсүрэн: Отрын нөөц бэлчээртэй холбоотой асуудал бол нэгдүгээрт улсын тусгай хэрэгцээнд отрын нөөцийг авч байгаа. Улсын тусгай хэрэгцээнд бас авч болохоор орж байгаа. Мөн аймаг орон нутгийн тусгай хэрэгцээнд, бас отрын нөөц нутаг болон хадлангийн талбайн зориулалтаар тусгай хэрэгцээ орон нутаг бас авч болж байгаа.

Ингээд сумын хэмжээний, сум дундын, мөн аймаг дундын гэсэн ийм 3 түвшний отрын нөөц нутаг байгаа. Манай хуулиар орж ирж байгаа концепт бол нийт Монгол Улсын нутаг дэвсгэрийн 10-аас доошгүй хувийг нь бол отрын нөөц нутаг байхаар төлөвлөе өө гэсэн ийм бас концепт орж ирж байгаа.

Одоо яг хэдэн га байгааг бол манай газрынхан хэлэх байх. Тусгай хэрэгцээний газрыг авахад улсын тусгай хэрэгцээний газар бид нар 13 төрлөөр авч байгаа. Орон нутгийн тусгай хэрэгцээнд 3 үндсэн зориулалтаар бол тусгай хэрэгцээнд авах ийм зориулалтаар орж ирж байгаа. Энэ тусгай хэрэгцээг авахад бол орон нутгийнх нь хурлын ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн асуулт асууна.

Ж.Батжаргал: Баярлалаа, тэгэхээр газрын багц хууль орж ирж байгаа юм. Энэ их том хууль, тэгээд үүнд ер нь иргэдийн оролцоо ямархуу байдалтай оролцох юм бэ? Бид ер нь бүх асуудал ярихаараа л ил тод, нээлттэй байдлын тухай яриад оролцооны тухай ярьцаагаад байгаа улсууд. Гэтэл энэ Газрын тухай хууль дээр иргэдийн оролцоог яаж хангах, тэр тусмаа тэр газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийгээд жилийн төлөвлөгөө боловсруулах үйл явцдаа иргэдийг яаж оруулах юм, яаж оролцуулах юм, энэ талаар зохицуулсан ямар харилцаа байна вэ гэдэг асуудал.

2 дахь асуудал, бэлчээрийн тусгайлсан бие даасан хууль гаргахгүй, энэ хуулиар зохицуулна гэж ингэж ярьж байгаа, байж болох байх. Гэхдээ одоогийн төсөлд ороод ирчхээд байгаа зохицуулалт бол бараг өнөөдөр мөрдөгдөж байгаа хууль дотор байгаа бэлчээрийн харилцааны асуудлаасаа бараг дордож орж ирсэн юм билээ. Үүнийгээ бид их бодох ёстой, бэлчээрийг хамгаална, зөв ашиглана л гэж ярьж байгаа бол тодорхой бэлчээр ашиглалтын хэсгүүд, энэ тэр гээд орон нутгууд бас санаачлаад янз бүрийн арга хэлбэрээр бэлчээр хамгаалалтынхаа асуудлыг хийх гээд оролдсон. Энэ талаар ерөөсөө өнөө бүх харилцааг нь үгүй хийж байгаа, зөвхөн отрын нөөц нутгийг л гэрээгээр ашиглуулна, бусдыг нь нийтээр ашиглуулна гэдэг ийм үг хэллэг оруулж ирээд, тэгээд ерөөсөө үндсэндээ бэлчээр ашиглалт чинь нэг дундын хэлбэрээрээ цаашид цөлжилт, талхлалд нь улам нэмэгдэх

үйл явц руугаа явах нь. Үүнийг юу гэж ойлгож, юу гэж харж байна вэ.

Отрын нөөц нутгийг гэрээгээр ашиглана гэдгээ юу гэж ойлгоод байна вэ? Тухайн жилийн ургамлын гарцтай нь уялдуулж, отрын нөөц нутагт ийм хэмжээний мал орж болох юм байна гэдэг юмаа тохироод, тэгээд тэр холбогдох аймаг, сумдтайгаа ийм хэмжээний мал оруулаа гэдэг гэрээг хийхийгээ ашиглалтын гэрээ гэж яриад байна уу, эс үгүй бол ерөөсөө нэг хэсэг улсуудад ашиглалтын гэрээгээр газраа олгочих гээд байна уу? Одоогийн байж байгаа практик хууль зөрчөөд байгаа үйл явц чинь бол нэг хэсэг улсууд отрын нөөц нутагт жилийн 4 улирал байгаад отрын нөөц нутаг биш болгоод байгаа шүү. Үүнийгээ юу гэж харж байна вэ гэж.

3 дахь асуудал 2 сумын хилийн цэсээс 2 тийшээ 5.5 километр газарт дундаа хэн ч ашиглаж болохоор ийм заалт оруулж иржээ. Энэ зөвхөн 2 сумын иргэдийн асуудлыг ишидэж байгаа зүйл биш шүү. Байдал цаг цаг уур хүндэрсэн ч гэдэг юм уу, төв рүү тэмүүлсэн нүүдэл энэ сумдын чинь хилийн цэс дээр ирж бөөгнөж, газар нутгийг чинь талхлах, ёстой зохицуулалтгүй бэлчээр ашиглалт чинь явагдах ийм эрх зүйн харилцааг нээж өгөх гээд байгаа ийм заалт болж орж ирж байгаа. Үүнийгээ бүгд юу гэж ойлгоод байна вэ? Үүн дээрээ нэг тодорхой хариулт өгөөч ээ гэж.

Дараагийн 4 дэх асуудал нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтэд тухайн орон нутгийн иргэд буюу багийн иргэд ямархуу байдалтай оролцож хариу өгөх юм бэ? Хэдийгээр Ашигт малтмалын хуулиар зохицуулна гэж та хэд

хариулах боловч энэ Газрын тухай хууль дээр тов тодорхой суурь, үндсэн заалт нь орох ёстой. Энэ талаар ер нь ямар ойлголт юу байна вэ? гэж.

5 дахь асуудал, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа гэдэг зүйлийг хэдэн жилд хийх ёстой юм. Ерөөсөө газар өмчлөл, эзэмшил ашиглалтаар иргэн хуулийн этгээдэд өгөхдөө анх яаж энэ газрын төлөв байдал чанарын хянан баталгаагаа хийж танд ийм л газар өглөө шүү, үүнээс дордуулахгүйгээр та авч явна шүү, тэдэн жилд бид баталгаат хяналт юмнуудыг нь хийж явна шүү. Тэгээд энэ асуудал дордсон байх юм бол цаашид хэдүүлээ хамтран ажиллах ... /минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах уу, 85.

Батжаргал гишүүний асуултад хариулъя, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Энхманлай байна. Газрын тухай шинээр боловсруулсан хуулийн төсөлд иргэдийн оролцоог хангах, газрын харилцааны асуудлыг шийдэхтэй адил иргэдийн оролцоог хангах, аймаг орон нутгийн ИНХ болон ИТХ-ын саналыг авч, газар зохион байгуулалтын ерөнхий болон тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж батлах ийм харилцаануудыг бол тодорхой зааж тусгаж өгсөн. Энэ нь яаж хангагдаж байгаа юм гэхээр тухайн төлөвлөгөөнүүд ямар цаглаварт боловсруулагдах юм, ямар цаглаварт бас тухайн иргэд өөрсдөө саналаа нээлттэй системээр дамжуулж өгөх вэ гэдэг энэ эрх зүйн орчныг бол хуульчилж хангаж өгсөн байгаа. Ийм учраас одоо бол мөрдөж байгаа зарчмаас тэс ондоо, өөрөөр хэлбэл

хэн ч байсан Монгол Улсын иргэн бол тухайн хуулийн төслийн дагуу хийгдэж байгаа газар зохион байгуулалтын, өөрөөр хэлбэл өөрийнхөө орон нутагт хийгдэж байгаа газрын харилцаатай холбоотой асуудалд оролцох, түүнд санал бодлоо илэрхийлэх, түүнд саналаа өгөх ийм боломж нөхцөлийг бол өнөөдрийн энэ хуулийн төсөлд бол тодорхой заасан. Энэ бол хууль дээр бол тусгагдсан байгаа.

Бэлчээрийн асуудлыг тодруулж байна. Бэлчээрийн харилцаа бол Үндсэн хуулиар олгогдсон, бэлчээр бол нийтийн өмч, нийтийн эдэлбэр газар бол төрийн нийтийн өмч, ийм учраас бол аль болох бэлчээрийг төр өөрийн мэдэлд, харин иргэдэд ашиглуулах ийм зарчмыг бол баримталсан. Энэ дотроо бол отрын нөөц элчээр бол гэрээгээр ашиглана. Одоо бол Монгол Улсын хэмжээнд нийт бэлчээрийн газрын 0,6 хувь буюу 600000 гаруй метр талбай, 600000 гаруй га талбай отрын нөөц бэлчээр байгаа. Тэгвэл энэ хуулийн төслөөр 10 хувьд нэмэгдүүлэх, өөрөөр хэлбэл 20 орчим хувиар нэмэгдүүлэх ийм төсөл боловсруулж орж ирсэн байгаа юм.

Энэ хууль дээр малчид яг ямар байдлаар энэ бэлчээрийг ашиглах юм бэ. Тэгвэл орон нутгийн иргэд бас энэ дээр ямар, орон нутгийн удирдах байгууллага, удирдлага ямар үүрэг хариуцлагатай байх юм бэ гэдгийг бас нарийн хуульчилж өгсөн. Бэлчээрийг нарийн төлөвлөгөөний дагуу хуваарьтайгаар өвөл, хавар, зун, намрын гэсэн 4 улиралд яаж бэлчээрийг зөв зохистой ашиглах вэ гэдгийг газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр нь зохицуулж өгнө. Үүнийг зохион байгуулах, хэрэгжүүлэх ажлыг бол орон нутгийн Засаг дарга,

удирдлагууд бол зохион байгуулахаар ингээж нарийн зохицуулж өгсөн байгаа.

Отрын нөөц бэлчээр дээр бол хэн гэрээ байгуулж, ямар хугацаанд ажиллуулахыг заасан, отрын нөөц бэлчээрт бол 6 сарын хугацаатай бол гэрээ байгуулагдана, малчидтай, тэгээд малчид бол 6 сарын хугацаанд отрын нөөц, бэлчээрийг ашиглаад буцаад, отрын нөөц бэлчээрийг бол чөлөөлж өгөх ийм үүрэгтэй байгаа. Отрын бэлчээрийн зориулалтаас төрлүүдээс хамаараад тухайн асуудлыг ХАА-н асуудал хариуцсан ЗГ-ын гишүүн, аль эсвэл аймаг дундын аймгийн сум дундын бэлчээрийг аймгийн Засаг дарга, сумын бэлчээрээ бол отрын нөөц бэлчээрээ сумын Засаг дарга нь хариуцаж энэ гэрээг малчидтай хийхээр ингээж нарийвчилж заасан байгаа. Сум дундын хилийн дагуу байрлаж байгаа 5 километрийн зурвас газрууд дээр иргэдийн эх хилийн цэстэй холбоотой маргаан гарсан, өөрөөр хэлбэл иргэд хилийн цэс тогтоохоос мөн тогтоосон хилийг нарийн сайн ойлгохгүйгээс болж малаа услах, малаа бэлчээрлүүлэх нь хил давдаг, энэ хоорондоо маргалддаг, ийм учраас бол тухайн 5 километрийн зайнд бол ямар нэгэн байдлаар мал бэлчээрлүүлэх, ус цэг ашиглахад бол янз бүрийн хилийн цэсийн маргааныг бол гаргаж болохгүй. Энэ дээр бол харилцан бие бие дээрээ орж ингээж ашиглаж болно гэсэн ийм зохицуулалт орж ирсэн.

Ашигт малтмалын асуудал дээр мөн адилхан, улсын жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ашигт малтмалын тухайн жилд ашиглуулах лиценз олгох газруудын

нэгдсэн саналуудыг төлөвлөнө. Тухайн сан ... /минут дуусав/

Г.Занданшатар: Жигжсидийн Батжаргал гишүүн тодруулж асууя, 1 минут.

Ж.Батжаргал: Тийм, та хэд ярихаараа нэг ийм юм яриад байгаа юм, гэрээгээр ашиглуулах тухай асуудал чинь яг эрх зүйн харилцаандаа бид нарын ойлгож байгаа 6 сарын ашиглалтын асуудал байна уу гэдэг асуудал их л бодох ёстой зүйл шүү. Тийм учраас би тухайн жилд энэ тэр гэж яг оруулж өгөхгүй бол наадах чинь нэг ашиглалтын ерөнхий харилцаа зохицуулдаг тэр ойлголтоороо явчих юм бол болохооргүй болчхоод байгаа. Үүнийгээ анзаарах ёстой гэж зориуд нэг хэлмээр байна.

Дараагийн нэг зүйл ерөөсөө энэ бэлчээр ашиглалтыг үнэхээрийн сайжруулъя, барья л гэж байгаа бол багийн ИНХ-аар нь бэлчээр ашиглалтын менежментийн төлөвлөгөө гэдгийг өөрсдөөр нь хэлэлцүүлж батлуулаад, түүнийг нь хэрэгжүүлэх арга хэмжээ дээр нь бид хяналт тавьж ажиллахгүйгээр нийтийн юм шиг байлгах юм бол явахгүй. Үүнийгээ энэ хуулийнхаа төсөл юман дээр их тодорхой болгож оруулж ирэх ёстой. Аль болохоор бэлчээр ашиглаж байгаа улсуудаар нь өөрсдийг нь оролцуулж төлөвлөлтийг нь хийж ... /минут дуусав/

Г.Занданшатар: 85

А.Энхманлай: Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг бид бүхэн бас маш нарийвчлалтай хийж хэрэгжүүлэхээр энэ хуулийн төсөлдөө тусгасан. Энэ бол 5 жил тутам

газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийгдэнэ. Мөн хугацаа сунгаж байгаа тохиолдолд мөн энэ төлөв байдал чанарын хянан баталгааг хийнэ. Иргэн, ААНБ-д олгогдоогүй газар дээр газрын мониторингийн хяналтуудыг төрөөс тавихаар ингэж зохицуулсан, ийм газар дээр бол ямар ч байсан хяналт шалгалтын ажлыг бол нарийн зохион байгуулах хийсэн. Анх удаа газрыг иргэн, ААНБ-д өмчлүүлэх хязгаарлагдмал эрхээр олгож байгаа тохиолдолд төрөөс хийгдсэн хянан баталгааг үндэслэж бол гэрээ байгуулж хүлээлгэж өгнө. Ингээд бол цаашид бол 5, 5 жилээр бол энэ хянан баталгааны ажлыг хийгээд хэлэлцээд явах ийм хуулийн зохицуулалт орсон байгаа.

Багийн бас иргэдийн хурал дээр саяын газар зохион байгуулалтын төлөвлөгөө түүнийг батлах дээр хамгийн гол нь ... /минут дуусав/

Г.Занданишатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн алга байна. Одоо Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн асуулт асууна.

М.Оюунчимэг: Энэ газрын асуудал бол өөрөө хүн бүхэнтэй холбоотой маш чухал асуудал, үнэ цэнтэй зүйл. Одоо ингээд иргэдтэйгээ, жишээлбэл ЧД-т иргэдтэйгээ яваад уулзаж байхад уулзалт болгон дээр гарч байгаа хамгийн том маргаантай асуудал энэ газар өмчлөлтэй холбоотой асуудал байна л даа. 0,007 га газраа ч өмчилж чадахгүй байхад тусгай хамгаалалттай газар ч гэдэг юм уу, эсвэл уул уулаар нь ингээд хашаалчихсан, тэрийгээ ашиглаж байгаа үгүй нь ч мэдэгдэхгүй хэдэн жил явчихдаг. Гэтэл бидэнд газар

олдохгүй байна гээд дүүргийн газрын албаны мэргэжилтэн, дарга нар иргэдийн хооронд бараг зодоон болох нь холгүй байж байна л даа. Тэгэхээр түүрүүн сайд ч хэлж байна, яг одоо шинээр 0,007 га газраа эзэмшүүлье гэхэд дэд бүтэцгүй, алслагдмал газар өгчихсөн, цахимаар гээд тэр газар нь очихоор ямар ч боломжгүй. Энэ дээр иргэд бол маш их гомдолтой байгаад байна л даа. Тэгэхээр газрын дахин хуваарилалтын асуудал ер нь энэ хуультай уялдаж хөндөгдөх үү.

Одоо яг тэр газраа авч чадаагүй, өмчилж чадаагүй гээд ялангуяа гэр хороололд бол энэ газрын маргаан, газартай холбоотой асуудал бол маш их байна. Тэгээд дүүргийн газрын алба нь Нийслэлийн газрын алба өгчихсөн гэдэг. Нийслэлийн газрын албан нь болохоор үгүй ээ, дүүрэг мэдээд ингээд өгчихсөн гээд нэг газар дээр хэд хэдэн хүний эзэмшил ингээд бүртгэгдчихсэн. Тэгсэн тэнд нь амьдарч байгаа хүн нь би газраа авах гэхээр бидэнд мэдэгдэхгүй энэ газрын өмчлөл нь өөр хүн дээр очоод тэр хүн нь хаана байгаа нь мэдэгдэхгүй байна гээд энэ яг газар өмчлөлтэй холбоотой мэдээллийн сан ч өөрөө бүрхэг байгаад байна л даа. Тэгэхээр энэ бүхнийг ер нь эргээд ахиж цэгцлэх юм уу, эсвэл цаашаа зүгээр шинээр явъя гэсэн бодлого энд барьж байгаа юм уу?

Одоо жишээ нь нэгдүгээр асуудал нь энэ байгаа юм, яаж энэ газар өмчлөлтэй холбоотой, ялангуяа нийслэлээс Улаанбаатар хот руу ороод ирчихсэн хүмүүс зарим нь газраа өмчилж чадаагүй хэр нь дураараа ингээд бууцгаачихсан, энэ нь эргээд дүүргийн газрын алба хоорондын маргаан байдаг. Нөгөө

талаасаа энэ газар өмчлөх эрхээ өгчөөд өмчилж байгаа хэр нь тэр нь нөгөө хэд хэдэн хүмүүст өмчлөгдсөн гэдэг юм уу, ийм маргаан жишээлбэл маш их байна. Тэгээд үүнийг яаж цэгцлэх вэ, энэ дээр яг шинэчлэл орж ирж байна уу? 1 дүгээрт энэ байна.

2-т нь, газрын үнэлэмжийн асуудал бол маш чухал байна. Газрын төлбөрийн асуудал гээд. Одоо жишээ нь бид гэр хорооллыг дэд бүтэцжүүлнэ, тэнд барилга байшин барина гээд эхэлж байна л даа, зарим газрууд нь дэд бүтэц очсон газар нь. Гэтэл яаж байна гэхээр иргэд бид нарын газрыг дэндүү бага үнээр үнэлж байна, ингэж болохгүй ээ гээд тэгээд газрын үнэлгээтэй холбоотой асуудлаас болоод нөгөө дэд бүтцийн юм уу барилга барих ажил нь бас удаашраад явдаггүй. Зарим нь бол миний газар бол үнэлэгдэх ёстой байхад төр үүнийг маш багаар үнэлээд байна гээд тэгээд үүнээс болоод асуудал нь ингээд хойшлоод ингээд яваад байна л даа. Тэгэхээр энэ газрын төлбөр, үнэлэмж дээр нэгдсэн нэг үнэ тогтоогоод ингээд явах эсвэл тухайн газар дэд бүтэц, нөгөө үнэлэмжээрээ шалтгаалж үнийг нь тогтоогоод яваад байх юм уу гэдэг асуудал байна л даа. Тэгэхээр энэ газрын төлбөр нэг га газрыг яаж үнэлэх вэ ч гэдэг юм уу тийм ээ, энэ дээр жишээлбэл энэ төлбөрийн тухай хуулийг шинэчилсэн найруулгаар бас орж ирж байна шүү дээ. Тэгэхээр энэ дээр яаж хандаж байгаа вэ гэдэг дээр 2 дахь асуулт байна.

3 дахь асуудал нь Бат-Эрдэнэ сайдаас асууя гэж бодож байна. Өмнө нь би нэг Өргөдлийн байнгын хорооны даргаар ажиллаж байхдаа Өргөдлийн байнгын хороо, тухайн үед Туул голын орчимд энэ Усны тухай

хууль, Гол мөрний урсац, бүрэлдэхүүний тухай хууль гээд маш олон хуулиудыг зөрчөөд, бүр нөгөө 50 метрээс нь илүү ойрхон газруудад хашаалчихсан, маш олон газруудыг хүчингүй болгох үүрэг чиглэлүүд өгөөд зарим нь хүчингүй болоод тэгээд энэ ажил овоо шүүх дээр очоод ингээд явж байсан. Гэтэл зарим нь гацаад ингээд үлдчихсэн байна гээд байгаа юм. Тэгэхээр энэ ажлын хүрээнд яг Туул голын орчинд зөвшөөрөлгүй буюу тэр хэд хэдэн хуулиудыг зөрчөөд барьчихсан энэ хашаа зүгээр нэг суурь цутгаад орхичихсон газрууд дээр яаж хандаж байгаа вэ, энэ хуулиар тийм газруудыг дүүрсэн хэрэг гээд цаашаа явах уу, эсвэл өмчлөлтэй холбоотой юм уу, түүнийг хуулийнх нь хүрээнд нураагаад түүнийг нь нийтийн өмч болгоод цаашаа явах уу? Өнөөдөр бол маргаантай нь зөндөө байгаад байна шүү дээ. Туул голын маань яг цаад талд нь хашаалаад нөгөө аялал жуулчлалын зориулалттай гэсэн хэр нь орон сууцны хороолол шиг юм бариад яваад байна шүү дээ.

Г.Занданишатар: 81,
Бэгзжавын Мөнхбаатар сайд
Барилга, хот байгуулалтын сайд.

Б.Мөнхбаатар: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Газар өмчлөлтэй холбоотой асуудлууд түрүүн хэлсэн, хэрэгжилт их хангалтгүй 20 орчим хувьтай, 600-аад мянган хүн газрыг өмчилж авсан байгаад байгаа. 0,07 хувийн газрыг аваад одоо Улаанбаатар хотод газар өгсөн 12,8 хувь л байгаа, нийт иргэдийн. Тэгэхээр Улаанбаатар хот маань өөрөө, тухайлбал Улаанбаатар хот маань гэр хорооллууд, өмнө байсан газруудаа хүмүүс нь өмчилж авсан, шинээр өмчилж авах хүсэлт тавьдаг боловч түрүүний хэлсэн

шалтгаануудаар дэд бүтэц байхгүй, алслагдсан бол ажлын байр байхгүй, худаг ус байхгүй гээд энэ асуудлууд нь бол эргэлтэд орж эрчимжиж өгдөггүй. Тэгэхээр бид нар энэ шинэ хуулийнхаа бид нар оруулж байгаа боломжуудыг иргэдэд нөхцөл боломжуудыг нь илүү нээж өгч байгаа юм. Одоо зөвхөн өмчилсөн газраа иргэн, хуулийн этгээд, гэр бүлийн хэрэгцээнээс бусад зориулалтаар иргэн, хуулийн этгээдэд шилжүүлэх эсвэл өөрөө худалдаа үйлчилгээнд зориулалтаар ажиллах боломжийг нээж өгч байгаа, зөвхөн өмчилсөн газар дээр байшин барих гэхээр нөгөө зөвхөн иргэн өмчилчихсөн байна гээд зориулалтыг нь өөрчилнө гээд бас их олон ажил болдог байсныг нь дэд бүтцэд ойрхон барилгажаад, дээр нь зарагдах бололцоотой болоод ирвэл иргэн тэр газраа өмчилсөн газраа өөр зориулалтаар шилжүүлж болох боломжийг нь бид нар эрх зүйн хувьд нээж өгч байгаа.

Үнэгүй өмчлүүлэх эрхийн хуулийн хугацааг бол бас хязгаарыг бол хязгааргүйгээр тавьж өгч байгаа. Тэгэхгүй бол бид нар нэг жил тавиад л, тэгээд л өмчлөл нь хэрэгжилт нь явахгүй байна гээд л сонгоод яваад байдгаа бид нар боломж гаргаж өгч байгаа. Ер нь газрын зөвхөн дэд бүтэц төлөвлөгдөж холбогдсон ус, хот суурин газар өмчлүүлье гэж байгаа. Тэгэхгүй бол нэг аймгийн бүр хаа л алслагдмал сумд, хаа хол алс газар тавьчихаад ер нь ашиглагдахгүй байгаа бид нар ер нь төлөвлөлтөөр ингэж дэд бүтэцтэй газар тавьж өгье гэж бодож байгаа. Мэдээж дэд бүтцийн газартаа тавьж өгнө өө гэдэг бол дэд бүтцийг хийнэ ээ гэдэг нь бас өөрөө их олон ажил болж хувирна.

18 нас хүрсэн иргэнд бол газрыг өмчилдөг байя гэж, одоо бол насанд хүрээгүй хүүхдүүдийн өмнөөс эцэг эх нь өмчилж аваад янз бүрийн харилцаанд оруулаад зарж үрчих тохиолдлууд байгаад байдаг. Тэр утгаараа бид нар бол насны хязгаар тавьж өгч байгаа. Өмчилсөн хүсэлтийг нөгөө хүмүүс хүсэлт тавьчихаад хугацаа байхгүй, шийдэж өгөхгүй байгаад байдаг байсныг бид нар 90 хоногт багтаан шийдэж байгааг 30 хоногт бол цахимаар шийдэж 30 хоногт шийдэж өгнө гэж хугацааг нь наашлуулж гаргаж өгч байгаа.

Иргэн, хуулийн этгээд өмчлөх болон газрын хязгаарлагдмал эрхтэй газраа газрын цахим биржээр дамжуулан олон нийтэд арилжаалах боломжийг нь бас бүрдүүлж өгч, өөрөөр хэлбэл мэдээллийг ил тод болгоё гээд ингээд газар өмчлөлтэй холбоотой бид нар нэлээн олон харилцаануудыг бол гаргаж өгч байгаа. Мэдээж уулын орой дээр гарчихсан, баригдчихсан, өмчилчихсөн газар дээрээ байшин барья гэхэд тэр зах зээлийн хувьд мэдээж зараад бариад борлуулагдах нь нөгөө бас зах зээлээсээ хамаараад байдаг. Төв зам дагуу дэд бүтэц сайтай бол тэнд бол үнэлэгдэх үнэлэмж нь өөрөө байдаг юм. Газрын үнэлсэн хэмжээ бол метр квадрат хот суурин газрын бүсчлэлээр болоод хэмжээг нь тогтоодог, өгсөн бол зах зээлийн ханшаараа бас өөрчлөлттэй, холбоотой асуудлууд их байдаг юм. Тэгэхээр зах зээлийн харилцааг бид нар Улаанбаатар болон аймгийн төвүүдэд бол зах зээл нь бол тэр зах зээлийнх нь арилжаанаас явагддаг юм, үүнийг нь бид нар зарж борлуулах нь бас цахим байдлаар гаргаж өгнө өө гэсэн бас шинэ харилцааны газар

өмчлөлийн иргэнд газар өмчлөлийн тухай хуульд бол бид нар бол нэмж оруулсан байгаа.

Г.Занданишатар: 80, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Оюунчимэг гишүүний асуултад хариулъя. Усны тухай хуулийн 22.1-22.4 дээр заасан байдаг. Усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүс, ус хангамжийн эх үүсвэрийн тэжээлийн мужийн заагийг, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын асуудал эрхэлсэн болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлтийг үндэслэн тогтооно гэж. Туул голын дагуух онцгой хамгаалалтын бүсийг НИТХ-аас тогтоож өгч байгаа гэсэн үг. Ялангуяа сүүлийн үед яригдсан усан паркттай холбоо бүхий асуудал байна, тухайлбал. Энэ нийслэлээс олгосон газар олголттой холбоотой асуудлууд. Бид нарын хувьд бол Туул голын сав газрын дагуу бол бүрэн хяналт шалгалтыг хийсэн, одоогоор баригдчихсан байгаа энэ барилга байгууламжийг цаашидаа ашиглалтыг нь яах вэ, эдийн засгийн эргэлтийн хувьд бид нар яаж тооцох вэ гэдэг энэ тооцооллын асуудлуудыг бид нар хийгээд явж байгаа. Цуцлах асуудлыг бол мөн нийслэлд хандчихсан явж байх жишээтэй байна. Ялангуяа энэ шинээр газар олголтыг бол хийхгүй байх, иргэдийн амралт чөлөөт цаг зугаалга хийх ийм бүсийг бол олон нийтийн төлөө байгуулах гэдэг дээр бол нийслэл маань бас нэлээн сайн ажлуудыг бол хийгээд явж байгаа.

Ер нь зүгээр энэ газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар,

Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, нийслэл гээд ингээд энэ хамтын ажиллагааны хүрээнд цаашидаа бид нар хэрхэн асуудлыг шийдвэрлэх вэ гэдгээ нэг мөр болгох ёстой гэж харж байгаа юм. Ялангуяа энэ газрын нэгдмэл сангаар бид нар дамжуулж энэ олон замбараагүй байдлыг цэгцлэх ёстой гэсэн ийм бодлогыг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам барьж байгаа. Нийслэл тусдаа газар олгодог, сум тусдаа газар олгодог, аймаг олгодог, Байгаль орчны яам олгодог, энэ өөрөө энэ нэгдсэн сандаа төвлөрдөггүй байдалтай, үүнээс улбаатайгаар маш олон зөрчлийн асуудал, энэ өөрөө тэгэхдээ эргээд төрийн олгосон зөвшөөрөл, шийдвэрийн дагуу ААН, иргэдийн хохирдог ийм хэлбэр байж болохгүй ээ гэдэг ийм агуулгыг бол бид нар барьж явж байгаа. Тэгээд одоогийн байдлаар бол бид нар Туул голын дагуу тодорхой цуцлах саналуудыг нийслэл рүү бол хүргүүлчхээд байж байгаа.

Цаашидаа бол олгохгүй байгаа асуудал дээр бол тохирсон гэж ойлгож байгаа.

Г.Занданишатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууя.

М.Оюунчимэг: Бат-Эрдэнэ сайд та тэр юуг нь хэлчхээрэй, өмнө нь зөрччихсөн, ингээд нөгөө аялал жуулчлалын зориулалттай авчихсан хэр нь хотхон бариад байгаа газруудыг ингээд түр зогсчихсон байгаад байгаа шүү дээ, түүнийг ер нь тэгээд бүр зогсоогоод цуцлаад өөр яг аялал жуулчлалынх нь чиглэлээр явах энэ асуудал чинь ингээд удаашираад зүгээр юу нь гарчихсан, тогтоол шийдвэр нь гарчихсан хэр нь тэнд нь ингээд байгаад байгаа

байхгүй юу. Тэгэхээр энэ асуудлууд яах юм бэ? Сая та бас усан паркийн тухай ярьж байна тийм ээ, тэгээд нийслэлтэйгээ ярьдаг, нийслэл нь ч, Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь чинь ингээд хамтраад, үүнийг ер нь энэ хуулийн хүрээнд зохицуулах бололцоо байгаа юм уу, үгүй юу гэдэг дээр нэг та бас тодорхой ярих хэлмээр байна.

2-т нь Барилга, хот байгуулалтын яам, сайд аа, сая та бас хэлж байна, одоо энэ дүүрэг дээр жишээлбэл ингэнэ, хорооны засаг дарга нар маань та нар маань сайн ингээд ингээд явчихвал та нарт зуслангийн бүсэд газар өгнө гэх мэтчилэн. Үүнийг нэг улс төрийн зорилгоор ч гэдэг юм уу, эсвэл янз бүрийн зорилгоор тийм юм хүртэл амлаад явж байгаа зарим дүүргийн Засаг дарга нар байна гээд бид нарт мэдээллүүд бас ирж байна л даа. Тэгэхээр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Ингэж газрыг нь чөлөөтэй өгөөд байх бололцоо байгаа юм уу гэж байна. Хэн хариулах юм. Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны ТНБД 83.

С.Магнайсүрэн: Оюунчимэг гишүүний асуултад тодруулж хариулъя. Бид нарын оруулж ирж байгаа газрын багц хуулийн төслөөр бол тийм бололцоо байхгүй. Газар зохион байгуулалтын улсын газар зохион байгуулалтын төлөвлөгөө 30 жилээр, тэгээд жилийнх нь тухайн жилээрээ, аймгийнх 15 жилээр, сум нь 7 жилээр ингээд төлөвлөлтүүд хамгийн гол нь гарна. Энэ төлөвлөлтүүд цахим систем дээр сууж, ерөөсөө л цахимаар үндсэндээ шалгуур хангасан тэр цахим дээр олгогдохоор бололцоотой тэр

хүсэлтийн дагуу л асуудал цахимаар шийдэгдэж, тэгээд аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллагууд дээр нь шийдэл нь гарч байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол төлөвлөлт нь маш чухал байна. хатуу тогтсон тийм шийдвэрийн дагуу тэгээд түүний дагуу шийдэгдэх учраас илүү дутуу өөр хүний оролцоо бол байхгүй болчихож байгаа юм. Тийм учраас бид нар энэ нөгөө Засаг дарга нар асуудал шийддэг биш, энэ мэргэжлийн байгууллага нь тэр цахимаар шийдэх учраас түүн дээр нь шийдлийг нь гаргаад явна гэдэг ийм төлөвлөлтөөр ерөөсөө нэг ... /минут дуусав/

Г.Занданшатар: 80, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Өлзийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Туул голын дагуу ашиглагдаж байгаа, ихэнх нь бол аялал жуулчлалынхаа чиглэлээр явж байгаа, тухайлах юм бол зөрччихсөн Белла спа, Ривер гарден, Хан хийлс гээд маш том хэмжээний барилга байгууламж баригдчихсан газрууд бий.

Хувь хүний өмчийг хуулиар хамгаалдаг, нэгэнт улсын бүртгэлд бүртгэгдээд, өмчлөлийн гэрчилгээ авчихсан орон сууцанд амьдарч байгаа иргэдийн хувьд бол өнөөдөр бид нар хууль, эрх зүйн орчин дээрээ зохицуулалтыг нь хийгээд явахаас өөр арга байхгүй.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг бид нар удахгүй оруулна. Энэ хуулиар бол бид нар дотоод бүсийн асуудлыг Байгаль орчин, аялал жуулчлалын яам шийдэж байгаа. Энэ дээр бол бид нар тав дахь ангиллыг оруулж ирж байгаа, энэ нь бол байгалийн нөөцийн ашиглалт бүхий

газар гэсэн ийм ялангуяа төвлөрсөн суурьшлын бүсүүд дээр ийм дотоод бүсийг гаргаж ирэхээр ажиллаж байна. Энэ бол саяын хэлдэг шийдвэрлэгдэхгүй байгаа асуудлуудыг шийдвэрлэнэ ээ гэж харж байгаа.

Газар ашиглагч нарын мэдээллийг бол Байгаль орчин, аялал жуулчлалын яам нээлттэй ... /минут дуусав/

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодотгоё, 1 минут.

М.Оюунчимэг: Иймэрхүү асуудлуудаа бол яг нэг талдаа гаргаад цэгцлээд шийдээд явах нь чухал байгаа шүү. Энэ чинь олон мянган хүний ундны устай холбоотой асуудал, цаашидаа ер нь ус яах вэ гэдэг асуудал байгаа шүү дээ, 1-д,

2-т нь, Ноён уулын асуудал, өнөөдөр бас тэр иргэдийн дунд хүлээлт үүссэн байгаад байна л даа, тусгай хамгаалалттай газар, дархан цаазтай газар гэгчихсэн. Тэгэхдээ тэр нөгөө нэг эзэмшиж байгаа компани гээд тэнд бас тодорхойгүй, эрх зүйн байдал нь хаалттай хэвээр байгаад байна. Тэгэхээр энэ Ноён уулын асуудал дээр ямар бодлого барьж, үүнийг хэзээ яг энэ тусгай хамгаалалттай дархан цаазтай гэдэг зориулалтаар нь явах юм бэ? Ер нь энэ асуудал яаж байгаа бол? Энэ дээр нэг тодорхой хариулт товчхон өгөөдхөөч.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ сайд 80.

Б.Бат-Эрдэнэ: Тодруулж хариулъя, Ноён уултай холбоо бүхий асуудал дээр бол бид нар тусгай

хамгаалалтад авч хамгаалалтын бүсэд байгаа ААН-үүдийн кэмнийг нүүлгэх ажлыг бол бид нар хийж байгаа. Ялангуяа Сэлэнгэ аймгийн Засаг даргад бол бид нар албан тоотыг хүргүүлсэн, 7 сарын 1-ний өдрийн байдлаар. Тухайн Ноён уулын тусгай хамгаалалтын бүс дотор бол 4 ААН-ийн кэмп бол өнөөдрийг хүртэл байж байгаа, тухайн кемпүүдийг бид нар яаралтай гаргах ийм ажлыг бол хийгээд явж байгаа. Фурам ХХК бол 1,3 га газрын хилийн гадна орчмын бүс дээр бол Фурам ХХК 1,3 орчим га газар ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй байгаа. Усны сан бүхий газрын онцгой бүсийн давхцалтай байгаа. Мөн энэ Гацуурт ХХК, Сентра гоулд ХХК-ийн тоног төхөөрөмж, Сон гоулд, Өрмөн уул гээд энэ компанийн тээрмийг гаргах болон орчны ... /минут дуусав/

Г.Занданшатар: Гомбодоогийн Мөнхцэцэг гишүүн, Чинбатын Ундармаа гишүүд алга байгаа учраас хаслаа. Адъяаа гишүүн яасан, Ширнэнбаньдын Адъяаа гишүүн алга байна. Дамбын Батлут алга байна. Хаслаа. Наянтайн Ганибал гишүүн.

Н.Ганибал: Газрын тухай хууль дээр ер нь шинэчилсэн найруулгын хүрээнд бол гол гол асуудлуудаа авч хэрэгжүүлээгүй байна, оруулж ирээгүй байна гэдэг шүүмжлэлийг өгч байгаа юм. Ер нь тэгээд бас манай энэ Барилга, хот байгуулалтын яамныхан, харин өнөөдөр бас ХАА-н сайд, Байгаль орчны сайд энэ тэр ирсэн байна. Энэ чинь өөрөө Газрын тухай хууль бол бүхий л салбарыг хамарсан цогц, ийм бодлогыг бичиг баримтаа бид нар эхэлж гаргах гээд байна шүү дээ.

Ер нь дэлхийн улс орнууд Газрын тухай хуулийн хамгийн чухал асуудал бол энэ газраа бүртгэж авдаг юм байна лээ. Тэгээд хэрэглэгчээ бас тодорхойлдог. Тэгэхээр манай энэ хууль болохоор та бүхний оруулж ирж байгаа энэ хууль болохоор тэр бүрэн зураглалаа гаргаж ирээгүй. Монгол Улс цаашид яаж явах юм, газраа яаж ашиглах юм, газрын дээр байгаа тэр бэлчээрээ малчид нь яаж ашиглах юм, уул уурхайн тэр газрын хэвлий дэх баялгаа яаж ашиглах юм, тэр газар тариалан, аялал жуулчлалын бүс, эд нарын хоорондын харилцаа, зохицуулалт үүнийгээ л бид нар ярих ёстой байхгүй юу. Түүнээс ямар бэлчээрийн асуудал гэхээр нэг отрын бүсийн тухай ойлголт яриад өөдөөс ийм байдлаар энэ хууль явахгүй л дээ.

Тэгэхээр ер нь зүгээр та бүхэн бид нар бүгдээрээ мэдэж байгаа, уул уурхайн ашиглалт, хайгуулын бүх талбай нь бол лицензтэй, кадастртай, газар тариалангийн бүс нутгууд, газар тариалангийн талбайнууд бүгд кадастртай, цаашилаад аялал жуулчлалын бүс нутгуудыг бас кадастржуулсан, тэгээд нөгөө бэлчээрийг нь болохоороо дунд нь хаячихсан. Бид нар олон жил, нүүдлийн МАА, зуу зуун жилийн өмнөх тэр байдлаараа л бид нар асуудалд хандаж байгаа. Энэ уулын амнаас энэ голын эрэг хүртэл манай өвөлжөө, түүнээс түүний хооронд манай хаваржаа, энэ зохицуулалтыг нь өнөөдөр газрын төлөвлөгөө дээр оруулаад явдаг, түүнийг нь нэг сумын Иргэдийн хурал, тэнд нэг мэргэжилтэн зохицуулдаг, энэ байдлаасаа бид нар хэзээ гарах юм бэ?

Өнөөдөр Эрдэнэбүрэнгийн УЦС-ын асуудал байгаа. Тэнд малчдын бэлчээрийн хэмжээ, талбай, цаашилаад шинээр бэлчээр олгох, шилжүүлэх энэ бүх асуудлууд яг л та нарын бэлчээрийн тухай хууль оруулж ирж байгаатай адилхан, ингээд л явдаг байхгүй юу, ямар ч тодорхойгүй. Тэгэхээр энэ асуудал дээр бид нар шинэ шинжлэх ухаанууд, энэ ололтуудыг бүгдийг нь ашиглах ёстой л доо. Ямар бид нар тэр үед кадастр гэж байгаагүй л байлгүй, одоо кадастр гээд бүхэл бүтэн шинжлэх ухаан байна. Тэгээд кадастр ярихаар бэлчээрийг бүгдийг нь хаших гээд байна гээд та нар ойлгоод байх юм. Өнөөдөр малчин хүмүүст өөрсдийнх нь бэлчээр нь өвөлжөө, хаваржаа нь тодорхой байх шаардлага гараад ирсэн. Дээрээс нь өвөлжөө дээрээ юм уу хаваржаа дээрээ аль нэгэн дээр нь нэг 2-3 га газрыг хашаад, тэр олон наст ургамлуудыг нь, тэжээлийн таримлуудын тарих тэр шаардлага гараад ирсэн. Шинэ үеийн бэлчээрийн МАА ингэж цаашаа хөгжиж явах ёстой. Энэ болгон дээр бид нар хариулт өгч л энэ хуулиудыг хийнэ үү гэхээс ямар нэгэн байдлаар ЗГ журам хийгээд, бэлчээр ашиглах энэ асуудлыг зохицуулна гэвэл энэ боломжгүй эд ээ. Өнөөдөр Монгол Улсын хэмжээнд нийт нутаг дэвсгэрийн 76 хувь нь цөлжих, цөлжих аюулд орсон байна гээд судлаачид гаргаад ирсэн. Жилээс жилд малын бэлчээрийн хэмжээ багасдаг, тэгэхдээ багасаж болно, хамгийн гол нь уул уурхайн компани, малчин 2 энэ асуудлаа зохицуулдаг, шийддэг байх ёстой, тэр нөхөн төлбөрөө авдаг байх ёстой. Ингэж байж энэ харилцаа зохицуулагдаж байж өнөөдөр энэ газрын багц хууль чинь явна уу гэхээс ингэж явж болохгүй л дээ. Ингээд ерөнхий

байдлаар ингээд хэн нэгэнд хаясан ийм байдлаар явж бол ... /минут дуусав/

Г.Занданшатар: 81,
Бэгзжавын Мөнхбаатар сайд хариулъя.

Б.Мөнхбаатар: Ганибал гишүүний асуултад хариулъя. Энэ газар ерөнхий хуульд орж ирж байгаа нэг өөрчлөлт бол таны хэлдэг шиг газрын нэгдмэл харилцааг цогцоор нь харах, газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөө хийхээр бол тусгачихсан байгаа. Өмнө нь болохоор түрүүн Бат-Эрдэнэ сайд хэлсэн Богд хан уулын тусгай хамгаалалттай газар Горхи Тэрэлжид төлөвлөлт байхгүйгээр тухайн үед ямар асуудал үүссэнээс болоод газар олголтууд олгоод яваад байдаг байсан. Ашигт малтмал ч гэсэн тухайн үеийн нөхцөл байдлаас өгөөд гэнэт олгоод хийгээд байдаг. Тэгэхээр энэ байгууллагууд маань жилийн төлөвлөгөөгөө хийнэ ээ гэсэн үг. Горхи Тэрэлжийнхэн өөрсдөө төлөвлөөд одоо дүүрчихсэн байгаа бол энд бид нар олгоно, олгохгүй гэдгээ төлөвлөж хийгээд эхлэхээр төлөвлөлтөө хийж эхэлнэ. Төлөвлөлтийн дагуу олголт хийгээд ирэхээрээ тэрийгээ газар зохион байгуулалтын нэгдсэн төлөвлөгөөнд ингээд тусгуулаад ирэхээр Монгол Улсад хаана ямар газар яаж олгогдох вэ гэдэг нь бүгд цогц нэгдмэл нэг болгож ирснээрээ бид нар энэ нэг цогц болоод ирснийхээ дагуу бид нар үүнийг олголтуудыг нь цахимаар хийгээд, хараад хянаад ирэхээрээ энэ бүх асуудлуудыг бас цогцоор нь шийдэх бололцоотой байгаа юм гэж харж байгаа юм.

Бэлчээрийн асуудал мэдээж түрүүн бас манай ТНБД хэлсэн

нүүдлийн соёлтой улсын хувьд бид нар бас их онцлог байгаад байгаа. Тэгэхээр малчдын хувьд бол өвөлжөө хаваржааны 1 га газрыг бол энд бол олгогдож байгаа. Түүн дээр барилга байшин барих эрх нь бол нээлттэй байгаа.

Бид нар энэ бүсчлэл тогтооно гэдэг нь эрчимжсэн, холимог, бэлчээрийн гээд бүсчлэлүүд гарч ирэх байх. Мэдээж эрчимжсэн МАА-тай тохиолдолд тухайн өвөлжөө хаваржааных нь хажууд нэг хэдэн га газар ногоон таримал тарих шаардлагууд ч гарч ирэхийг үгүйсгэхгүй.

Хоёрдугаарт, Монгол Улсын маань бас түрүүн хэлж байсан, ҮАБЗ-өөс гарсан шинжээчдийн судалгаагаар нүүдлийн соёлын малтай байдаг бидний хувьд бас ингээд газрыг тодорхой хашаад, эс үгүй бол кадастр яаж өгөх нь энэ өнөөдрийн тохиолдолд зайлшгүй хүнд асуудлууд байгаад байдаг. Энэ өвөлжилт зудаас болоод малчид маань нааш цаашаа нүүх асуудлууд гарч ирдэг. Тэгээд энэ асуудлуудыг нь бид нар бас тухайн үед бол харж үзэж, ЗГ-ын тэр бүсчлэлийн дэглэм тогтоох байдлаар бид нар зохицуулах байдлаар уян хатан байя гэсэн зохицуулалтуудыг энэ хуульд тусгасан байгаа юм.

Г.Занданшатар: Наянтайн Ганибал гишүүн тодруулъя, 1 минут.

Н.Ганибал: Тийм ээ, тэгээд юу шүү дээ, заавал хашаажуулна гэдэг үгийг оруулж ирж бүх юмаа мушгиад яах вэ дээ? Та хэд маань өнөөдөр шинжлэх ухааны газрын мэргээжилтнүүд, газар гэдэг чинь өөрөө эдийн засгийн харилцаанд орох ёстой. Бэлчээр өөрөө бас эдийн

засгийн харилцаанд орох ёстой байхгүй юу. Өөрийнхийгөө ашиглана, бусдынхыг ашиглавал тэр төлбөрөө төлөх ёстой, ингээд нэг ийм өнөөдрийн нийгмийн харилцааныхаа энэ асуудлуудыг энэ та хэд ингээд оруулж ирэхгүй, үндсэн концепцоо хийхгүй, зүгээр л ингээд хэн нэгэн нь нэг 82 хуулийн өөрчлөлтөө ингээд нэгтгээд орж ирсэн гээд нэг тайлбарлаад байгаа.

Дээрээс нь газрын энэ ашиглалтын гол гол асуудлууд чинь ингээд орхигдоод байгаа нь л хамгийн асуудал татаад байна шүү дээ. Жишээлбэл Тэрэлж энэ Богд хааны уулын энэ дархан цаазтай газар нутагт 1400 хэд ч билээ газар олгочихсон, нэг нь ч кадастр байхгүй, нэг нь ч зөвшөөрөл байхгүй, гэрээ хийгдээгүй ингээд яваад байдаг юм шиг байна лээ шүү дээ. Тэгээд энэ болгонуудыг бүгдийг нь цэгцлээд шийдэх шийдлүүдийг л энэ хууль гээд байгаа шүү дээ. Өөр одоо ... /минут дуусав/

Г.Занданшатар: 85.

А.Энх-Амгалан: Ганибал гишүүний асуултад тодруулж хариулъя. Одоо бол улсын хэмжээнд бид бүхэн бас 160 сум дээр 88000 малчин өрхийг хамруулсан 1500 бэлчээр ашиглалтын хэсэг гэж бас тодорхой, бас энэ Монгол Улсад хэрэгжсэн төслийн хүрээнд энэхүү бэлчээр ашиглалтын хэсгүүд байгуулагдаж, үүнтэй холбоотой бэлчээр ашиглуулах 1200 гэрээг бол байгуулаад ажиллаж байгаа. Эдгээр гэрээнээс бол бид бүхэн бол 900 гаруйг бол саяын газрын мэдээллийн сандаа бол бүртгэсэн. Гэсэн хэдий боловч энэ бүртгэсэн гэрээнүүд дээр бол ямар нэгэн байдлаар орон нутгууд маань

гэрээ дүгнэсэн, тухайн бэлчээрийг яг ингэж гэрээгээр ашиглаад яг ямар үр дүнд хүрсэн юм бэ, ямар ашигтай байгаа юм бэ гэдгийг бол тодорхой үр дүн гаргаагүй байгаа. Өөрөөр хэлбэл бид нар бол энд газрын мониторингийн сүлжээгээр бол хяналт тавьж үзэхэд тухайн бэлчээрүүд дээр бол сайжирсан үзүүлэлтүүд ерөөсөө харагдахгүй байгаа байна ... /минут дуусав/

Г.Занданшатар:

Дагдэмбэрэлийн Бат-Эрдэнэ гишүүн алга байна. Тогмидын Доржханд гишүүн.

Г.Доржханд:

Баярлалаа.

Хуулийн төслийн концепцыг нь бол дэмжиж байгаа. Тэгээд асуулт бол байна. Энэ Зайсангийн орчим, тэгээд Яармагийн орчим, тэгээд энэ Богд уулын орчмын газрууд бол бүгдээрээ аялал жуулчлалын зориулалттай газар байна гэсэн мөртөө дандаа орон сууц барьчихсан байдаг. Тэгээд дийлэнх байшингууд нь гэрчилгээ байхгүй, баталгаажсаагүй, гэрчилгээ байхгүй байгаа болохоор банканд барьцаалж эх үүсвэр татах боломж байдаггүй, эдийн засгийн эргэлтэд ордоггүй, нэг ийм байдлаар 20, 30 жил ингээд яваад ирчихлээ. Тэгээд үр дүнд нь бид нар эдийн засгийнхаа боломжийг бол алдаад байгаа, тэгээд энэ дээр хэний буруу юм бэ гээд тэгэхээр худалдаж авсан иргэдийн буруу бол биш ээ, нэг. Тэр газрыг олгох шийдвэр гаргасан байгууллагын буруу бол байна, тийм биз дээ.

Дээрээс нь газар дээрээ байшин бариад тодорхой хэмжээний авлига энэ тэрийг нь өгөөд тэгээд явчихсан барилгын компаниудын бас тодорхой асуудлууд бас байна. Энэ дээр та нар яг ямар байдлаар хууль дээрээ тусгаж

байгаа юм бэ? Тэгээд хариуцлагын асуудал яаж явах юм бэ? Тэгээд ер нь цаад агуулгаараа эдийн засгийнхаа эргэлтэд оруулах энэ асуудлаа та нар яг яаж харж байгаа юм? Судалгаа тооцоо юу байна вэ гэж.

Дараагийн нэг асуудал нь болохоор энэ хэн хариуцах юм бэ гэдэг асуудал бол байна. Ялангуяа ийм үнэ цэнтэй газрууд дээрээ Байгаль орчны яам нь зөвшөөрөл өгчихдөг, гэтэл нэг ширхэг ч музей байхгүй, зочид буудал нь байхгүй, дандаа орон сууцны хороолол. Үр дүнд нь бид нар ингээд түгжрээд байгаа шүү дээ. Ингээд хотын төвөөрөө ингээд битүү өндөр байшингууд, тэгээд түгжрэл, тэгээд Богд уулаа тойроод битүү байшингууд, бас түгжрэл, тэгээд дотор нь болохоор сургууль, цэцэрлэг ч байдаггүй ингээд төлөвлөлтийн асуудлууд гарч ирээд байгаа юм. Гэтэл энэ асуудлыг чинь зөвшөөрлийг нь Байгаль орчны яам өгөөд байх нь зөв юм уу. Тэгэхээр цаашаага яг хэн нь хариуцах юм бэ. Барилга, хот байгуулалтын яам нь хариуцах юм уу, Нийслэл нь хариуцах юм уу. Энэ дээр бас нэг тодорхой хариулт өгөөрэй.

3-т нь бол бид нар Хотын эрх зүйн байдлын тухай хууль гэж баталсан. Тэгээд түүн дээр бол нэг тодорхой заалт оруулсан нь нягтаршил өндөртэй газар шинээр байшин барихгүй ээ гэдэг, харин юу хийх юм бэ гээд тэгэхээр ногоон байгууламж болон нийтийн зориулалтаар ашиглана гэдэг ийм хуулийн зохицуулалт бол орчихсон одоо ингээд хүчин төгөлдөр явж байгаа. Тэгэхээр газрын энэ ашиглах, өмчлөх энэ хуулийн концепц дээр, тухайлбал яг ийм нягтаршил өндөртэй газарт ямар байдлаар зориулалтаар ашиглах юм бэ гэдэг

ийм тусгагдсан тодорхой зүйл байгаа юу. Энэ хуультай зөрчилдсөн зүйл байгаа юу. Тэгээд цаашаага энэ Улаанбаатар хот, тэгээд цаашаа бас хотууд үүснэ шүү дээ төвлөрөл үүсэж байж, хотууд чинь үнэ цэнтэй болно. Тэгээд хамгийн их төвлөрсөн газар бол газар нь бол үнэ цэнтэй байна, гэтэл тэнд ингээд өндөр өндөр байшин бариад л байх юм бол энэ түгжрэлийн асуудал бол шийдэгдэхгүй нь тодорхой. Тэгэхээр ийм тохиолдолд өндөр байшин барихгүй, тодорхой ингээд хязгаарлалттайгаар барина, 10 давхар ч гэдэг юм уу, хэдэн давхар байдаг юм, ийм байдлаар төсөөлж оруулж ирж байгаа зохицуулалт байна уу. Баярлалаа.

Г.Занданшатар: Бат-Өлзийн Бат-Эрдэнэ Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, 80.

Б.Бат-Эрдэнэ: 1 дүгээр асуултын хувьд бол Богд хан уулын дархан цаазат газарт Байгаль орчин, аялал жуулчлалын яам бол газар олголтыг хийсээр ирсэн. Өнөөдөр бол би түрүүн хэлсэн нийт 72 удаагийн тушаалаар 150 нэгж буюу тодорхой газруудыг бол бид нар цуцалсан 433 га газар, 22 га газар. Цаашидаа бол бид нар энэ цуцлах ажиллагааг бол эрчимтэй явуулж байгаа. Өнөөдрийн байдлаар бид нар Нүхтийн ам, Залаатын зүүн богиньн ам, Шажин хурхын ам гэх мэтчилэнгээр Тайны ам гээд энэ гэх мэтчилэнгээр бид нар тодорхой газар олголтуудыг бол бүрэн зогсоогоод байгаа. Газрын маргаантай холбоо бүхий асуудлууд бий, хилийн цэстэй холбоотойгоор. Хан уул дүүргийн Түргэний амын хилийн цэсийн маргаантай хэсэг дээр бол 150 орчим нэгж талбарт газар эзэмшүүлж, газрын кадастрын

мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, 30 нэгж талбарыг кадастрын мэдээллийн санд бүртгэж оруулаагүй байгаа жишээтэй байгаа.

Богд хан уулан дээр бид нар 5594 га газраар бол хамгаалалтын бүсийг тэлсэн. Горхи Тэрэлж дээр бид нар 55202 га газраар хамгаалалтын бүсийг тэлсэн, энэ бол цаашидаа газар олголт ашиглагдахгүй хэлбэр дээр. Нэгэнт газар аваад байшин бариад амьдарч байгаа иргэдийн хувьд бол эдийн засгийн эргэлтэд оруулах ёстой гэдэг дээр бид нар зарчмын хувьд санал нэг байгаа. Яг энэ концепцоор явж байгаа. Газрын ерөнхий хуулийн оруулж ирж байгаа хуулийн 3.1.2 дээр бол тусгай хамгаалалттай газар нутгийн харилцааг тусгайлсан хуулиар зохицуулна гэдэг ийм заалт бол орсон. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд бол бид нар шинэчилсэн найруулга дээр байгалийн нөөцийн ашиглалт бүхий газар гэдэг энэ хот суурин төвлөрсөн газрын суурьшлын бүсийн хамгаалалтын юу хязгаарлалтын бүсийг ийм анги бүслэл рүү шилжүүлэх, энэ бүслэлээрээ бид нар эдийн засгийг эргэлтийг дэмжих байдлаар бол бид нар оруулаад явж байгаа.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам цаашидаа газар олголт хийхгүй гэдэг байр суурьтай байгаа. Байгаль орчин, аялал жуулчлалын яам бол байгаль орчноо хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх ёстой төрийн захиргааны төв байгууллага болохоос биш байгаль орчноо сүйтгэх, газар олголтыг хийх, энэ харилцаанд ороод явах энэ харилцааг бол бид нар цаашидаа энэ газрын ерөнхий хууль, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай

хууль хэрэгжээд явахаар бүрэн зогсох болов уу гэсэн ийм бодолтой ажиллаж байгаа.

Цаашидаа бол бид нар энэ Газар зохион байгуулалт геодезийн газар, Барилга, хот байгуулалтын яам, нийслэл Байгаль орчин, аялал жуулчлалын яам бол энэ ялангуяа энэ газрын асуудал дээр бол нэгдсэн сангаараа явж байх ёстой гэдэг ийм нэгдмэл байр суурьтай байж байгаа.

Г.Занданшатар: 81 Бэгзжавын Мөнхбаатар Барилга, хот байгуулалтын сайд.

Б.Мөнхбаатар: Доржханд гишүүний асуултад бас нэмэлт, гэхдээ яг энэ газрын багц хуультай төдийлөн уялдахгүй, хот байгуулалттай уялдах асуудлаар би хариулт өгье гэж бодож байна. Нийслэл Монгол Улсын нутаг дэвсгэр 0,03 хувийн газар нутагтай. Улаанбаатар хот, тэр дотор Улаанбаатар хот нь 0,3 Улаанбаатар хот нь 0,01 хувь, төвийн 6 дүүрэгт Монгол Улсын 0,01 хувь, Монгол Улсын 99,99 нь задгай. Монгол Улсын 0,01дээр Монгол Улсын хүн амын тал нь овоорчихсон байгаа юм. Одоо яг бид нар бодитой харах ёстой.

Улаанбаатар хот цаашиа тэлэх гээд Налайх руу тэлэлтийг ярьдаг боловч Хонхор луу цэвдэгтэй. Тийшээ тэлэлт явж чадаагүй. Хойшоо гүнж цаашидаа энэ Улиастай ам руу явна, Гүнжийн хагарал гарч ирж байгаа юм. Улаанбаатар хотыг тойроод гэр хорооллууд нь байгаа, хүссэн хүсээгүй тэлэлт энэ их бол эдийн засгийн өрсөлдөөнд Яармаг руу явсан юм. Тэгэхээр Бат-Эрдэнэ сайд хэлж байгаа, удахгүй Тусгай хамгаалалтын тухай хуулийн

өөрчлөлтөөр орж ирж, бид нар энэ асуудлуудыг зайлшгүй зохицуулах асуудлууд гарч ирж байгаа юм. Тэгэхээр өөрөө газар нутаггүй газар тэлэлт бий болох гээд байгаа, хүссэн хүсээгүй Яармаг руу явсан энэ харилцаа цаашаа Буянт ухаа, Морин даваа буюу Хөшигийн хөндий гэсэн тэлэлт цаашид Улаанбаатарт явна. Тэгэхээр үүнийг нэгэнт явж байгаа энэ зүй тогтлуудыг бид нар хууль, эрх зүйн хувьд бид нар бас харж үзэж цэгцлэх нь бол зүйтэй. Улаанбаатар хот цаашид энэ нам ашиглалтын шаардлага танай дүүрэг дээр ч яригдаж байгаа Хан уул дүүргийн тэр нисэхийн 10 байшингууд ашиглалтын шаардлага хангахгүй байшингуудыг буулгаад бариулж өгөөч ээ энэ тэр гээд. Одоо цаашид энэ төвийн 6 дүүрэг маань 45 хувь нь дэд бүтэцтэй, төрийн ордноос хойшоо Ногоон нуур нэг километр дэд бүтэц байхгүй, Дамбадаржаа, Чингэлтэй бүх энэ уулууд дэд бүтэц байхгүй. Байгаа дэд бүтэц дээрээ л өнөөдөр байшингууд баригдаад байгаа юм. Тэгэхээр 5 давхар байшин буугаад яг бодит байдал нь өндөр 10 болж л баригдаж байгаа. Дэд бүтцийн тэлэлтийг бид нар энэ 20, 30 жил хийж чадаагүйд бол бид нарын асуудлууд бол байгаад байна.

Тийм учраас хот байгуулалтын хувьд аль болох нягтаршуулж, төвийн дүүргүүдэд өндөр байшин барихыг бол засгаас түр хориглож байгаа. Гэхдээ зөвшөөрөл авсан компаниуд нь хийгдэх байх. Цаашид нөгөө дэд бүтцээсээ болоод л газраасаа болоод л өндөр байшин барих явцууд явж байгаа. Яармагийн энэ асуудлуудыг газрын асуудлаа шийдсэний дараа энэ төлөвлөлтийнх нь дагуу хэрэв ингээд шийдвэл төлөвлөлтийнх нь дагуу барьж байгуулах ёстой байгаад

байгаа юм. Тэгэхээр Яармагийн хэсэгчилсэн төлөвлөлт гэж байдаг хэр нь тэр нь мөрдөгдөхгүй байгаад байгаа юм. Өөрөөр хэлбэл нэг сургууль, цэцэрлэг, эмнэлэг, улсын чанартай объектууд суух ёстой олголтуудыг нь бас хийж чадаагүй. Энэ асуудлуудыг бид нар засаж янзлах, явах ёстой байгаа юм гэж ойлгож байгаа.

Г.Занданшатар: Тогмидын Доржханд гишүүн 1 минут тодруулъя.

Т.Доржханд: Тэр Байгаль орчны яамны барьж байгаа байр суурь бол зөв байна. Тэгээд цаашаа бол газар өгөхгүй, байгаль орчноо хамгаална гэдгийг бол сайд нь бол өөрөө мэдэгдэж байна. Энэ дээрээ бол тууштай байх нь зүйтэй байх, нэг. Тэгээд энэ Барилга, хот байгуулалтын сайдын бас зовлонг л ойлгож байна, тэгэхээр нэг ийм юм байна л даа.

Олон улсад чинь газрыг хэн зардаг юм бэ гэхээр нэг дарга биш шүү дээ. Энэ чинь дуудлага худалдаагаар зардаг, газар яаж зарагддаг вэ гээд тэгэхээр дэд бүтэцтэй байж байж л зарагддаг, үнэ ордог. Тэндээсээ буцаагаад санхүүжилтээ олж аваад өөрөөр хэлэх юм бол зарсан эх үүсвэрээр эргэлтийн сан үүсгээд, тэндээсээ ингээд дараагийн шатныхаа нөгөө газар доорх дэд бүтцийнхээ санхүүжилтийг ингээд хийгээд явчихдаг. Тэгэхээр төсөв дээр бид нарын анхных нь эх үүсвэр суух ёстой байхгүй юу. Яг ийм байдлаар бид нар цаашаа ингээд дэд бүтцийнхээ асуудлыг шийдэж авахгүйгээс болоод өнөөдөр яг үнэн, хаана дэд бүтэц байна, тэнд төвлөрөл үүсээд байдаг, тэнд хахууль бас яваад байдаг.

Яагаад гэхээр нээлттэй биш байгаа байхгүй юу. Үүнийг яаж нээлттэй болгох юм бэ, энэ дээр ... /минут дуусав/

Г.Занданшатар: Сандагийн Магнайсүрэн 83. Барилга, хот байгуулалтын яамны ТНБД.

Доржханд гишүүний асуултад тодруулж хариуля, Магнайсүрэн. Саяын асуудал бол Доржханд гишүүний ярьсан саяын концепцын асуудлууд бүрэн сууж орж ирсэн. Нэгдүгээрт, хот байгуулалтын хууль бол манай газрын багц хуулийн хэлэлцүүлгийг хүлээгээд Их Хурал дээр нэгдүгээр хэлэлцүүлгийн шатанд хүлээгдэж байгаа. Энэ дээр бол түрүүний ярьсанчлан бүсчлэлийн асуудал, 10 бүсийн асуудал орж ирсэн, суурь зохицуулалтууд нь бол энэ хууль орж ирээд тэгээд Хот байгуулалтын хуультай хамтраад ингээд шийдэгдэнэ, түрүүний ярьсны дагуу.

Хоёрдугаарт саяын ярьсантай холбогдуулаад дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, дуудлага худалдаа нь бол үндсэндээ газрын эрх олгох үндсэн арга зам нь. Хүсэлтээр шууд олгож байгаа иргэдийн зайлшгүй хэрэгцээнд олгож байгаа цөөн тохиолдол байна. Дуудлага худалдааны анхны үнээр олгож байгаа бас цөөн тохиолдол байгаа. Тэгээд төсөл сонгон шалгаруулалтаар ЗГ-ын баталсны дагуу олгох, тэгээд дуудлага худалдаа гэсэн ийм 4 арга замаар бүх асуудал шийдэгдэж байгаа ... /минут дуусав/

Г.Занданшатар: Цогтгэрэлээс бусад гишүүдийг хаслаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн байгаа, уучлаарай. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн

байгаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаа. Учир нь одоо байгаа хууль бол хамгийн аймшигтай газрын наймааны тухай хууль. Үүнээс өөр муу хууль гэж байхгүй учраас үүнийг дэмжиж байгаа. Харин нуухыг нь авах гээд нүдийг нь сохолж болохгүй гэдгээр би нэлээн олон асуултууд гарах юм. Тэгээд цаг нь хүрэхгүй л байх даа. Шууд асуултаа асуугаад явчихъя, харин хариулна шүү.

Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг одоогоор Байгаль юу, Барилга, хот байгуулалтын яам байгаа, хууль батлагдсаны дараа энэ байдал хэвээр байх уу, өөрчлөгдөх үү, ямар бодлого байна вэ. Миний асуулт.

Төслийн хорьдугаар зүйлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын тогтолцоог тодорхойлжээ. Энд нь төв байгууллагын эрх үүргийг ерөөсөө огт томъёолоогүй байна. Надад тодорхой болгож өгөөч.

2 дугаар асуулт, Төслийн хорьдугаар зүйлд аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын асуудал эрхэлсэн албан тушаалтанд тавигдах шаардлагыг тодорхойлсон байна, маш тодорхой байна. Харин газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын удирдлага бүр яг даргад нь тавигдах шаардлага томилж, чөлөөлөх тэр бүх асуудлууд нь тодорхойгүй байна. Учир юунд байна вэ, хэрхэн шийдвэрлэх вэ? Надад яг тодорхой хэлж өгвөл их сайн байна шүү.

Ер нь бол тэгээд л шатыг дээрээс шүүрддэг шүү дээ, Хамгийн том хулгайч нар хамгийн дээрээ л байдаг.

Гуравдугаарт, төслийн 29.6-д бүх шатны газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төслийн боловсруулах ажлыг газар зохион байгуулалтын үйл ажиллагаа эрхэлж, тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр гүйцэтгүүлэх болно гэж заасан байна. Ингэж төр залхуурал хийж болдог юм уу, төрийн мэргэшсэн алба энэ ажлыг хийх ямар ч чадваргүй гэсэн үг үү, яагаад ийм хуулиар залхуурлыг бий болгож байгаа юм бэ? Саяхан батлагдсан Зөвшөөрлийн тухай хуультай уялдаж байгаа юу? би тодруулъя. Саяын асуусан асуултаа.

31.4, 32.3 боловсруулах ажлыг зохион байгуулах гэсэн зохицуулалтууд л байгаа. Төрийн захиргааны газрын мэргэжлийн байгууллагууд зөвхөн зохион байгуулах л үүрэгтэй байх гэсэн ийм ойлголт энд төрж байна. Зөвхөн зохион байгуулах. Миний ойлголт зөв үү, буруу юу. Зохион байгуулахаас өөр ямар нэгэн алхмууд энэ дотор байгаа юу?

4 дүгээр асуулт, Төслийн 6.1-д аймаг, сум, нийслэл, дүүрэг бүр хилийн цэстэй газар зүйн нэрийн зурагтай байна гэж заасан байгаа. Аймгийн төвийн сум, сумын төв, суурин газар бүрийн хилийн цэстэй газар зүйн нэрийг зурагтай байх тухай заалт төсөлд орсон уу. Одоогоор хилийн цэс газар зүйн нэрийн зураггүй, аймгийн төвийн сум, сумын төв суурин байна уу. Энд надад хариулж өгөөрэй

5 дугаарт, төслийн 39.1-д, хот тосгон, бусад суурины эдэлбэр газрын ангилалд хамаарах газраас Монгол Улсын иргэний өмчлөлд шилжүүлнэ гэж заасан байна. Одоо иргэний өмчлөл дээрх хэлбэрээс бусад, тухайлбал сумын төв суурины хилийн цэсээс гадна тэр бэлчээрээс иргэнд газар өмчлүүлсэн байгаа. Энэ өмчлөл хуульд өөрчлөлтөөр хэрхэн шийдэгдэх вэ, өмчлөл цуцлагдах уу, эсвэл дагаж мөрдөх хуулиар ямар нэгэн зохицуулалт хийгдэх үү. Энэ миний асуулт их тодорхой гэж ойлгож байна шүү, би ойлгохгүй бол тодруулж асууж болно.

6. Төслийн 40.1-д нэг удаа өмчлүүлэх газрын хэмжээг тогтоосон. 40.2-т орон нутагт өмчлүүлэх газрын дээд хэмжээг аймгийн ИТХ тогтооно гэжээ. Нийслэлд өмчлүүлэх газрын дээд хэмжээг ямар байгууллага хэн тогтоох вэ, нэг ... /минут дуусав/

Г.Занданшатар: *6 асуултад 83, Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны ТНБД, дараа нь нэмж*

Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн. Газар зохион байгуулалт, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага бол Барилга, хот байгуулалтын яам. Барилга, хот байгуулалтын яамны чиг үүрэг Монгол Улсын ЗГ-ын тухай хууль, яамны эрх зүйн байдлын тухай хуульд бол тодорхой тусгагдсан. Газрын ерөнхий хуульд бас холбогдох хэсгүүдэд бол чиг үүрэг, эрх хэмжээ тусгагдсан байгаа. Мэргэжлийн байгууллагын хувьд бол газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу манай газар зохион

байгуулалт, геодези, зураг зүйн газар, энэ агентлаг энэ байгууллагын тогтолцоонд үндсэн гол чиг үүрэг нь төрийн захиргааны байгууллага гэдгээрээ тодорхойлогдсон. Үүнээс доош аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын чиглэлийн алба, тэгээд суманд газар зохион байгуулагч, дүүрэгт бас алба бий. Энэ байгууллагын даргад, агентлагийн даргад шаардлага тавиагүй байна гэдэг зүйл хэллээ. Энэ дээр бол төрийн албаны тухай хуульд агентлаг, агентлагийн дарга, ТНБД гээд ингээд ямар шаардлага хангасан этгээд шалгаруулалтад орж тавигдах вэ гээд ингээд тодорхой байдаг учраас энэ нь тэр хуулиараа зохицуулагдаад энэ хэсэг нь, бусдынх нь шаардлагыг бол бид нар энэ хууль дээр хуульчилж өгсөн байж байгаа.

Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хийхэд тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдээр ер нь 2 түвшний төлөвлөлт дээр хийж болно гэж оруулсан. Ер нь бол энэ хуулийн үндсэн концепт бол энэ газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр төрийн бодлого зангидагдаж, түүнийг ягштал хэрэгжүүлэх асуудлыг дээрээсээ авхуулаад доод шатандаа хүртэл хэрэгжүүлдэг байх ийм үндсэн гол шаардлагыг тавьж байгаа. Тийм учраас газар зохион байгуулалтын төлөвлөгөөнүүдэд ямар шаардлагууд тавигдах вэ, яаж хэлэлцэж, ямар цаг хугацаанд батлах вэ гээд цаглаврыг нь бид нар улсын хөгжлийн төлөвлөгөө батлагдахаас 7 сарын 01-нээс авхуулаад 12 сарын 01 хүртэл батлагдах улсын төсөв батлагдах хүртэл энэ цаглавартай уялдуулж ингэж бол газар зохион байгуулалтын төлөвлөгөөг батлахаар тусгасан. Энэ төлөвлөгөөнүүд бол хамгийн чухал, бид нарын мөрдөх ийм

гол баримт бичиг болох ёстой. Энэ төлөвлөгөө дээр тэр 2 түвшний төлөвлөгөө дээр бид нар мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрөлтэй ийм мэргэжлийн байгууллагын зарим зүйлийг бас хийлгэж болох юм гэж зүгээр ингэж нээж өгсөн байгаа.

Өнөөдөр хүчин төгөлдөр 01 сарын 01-нээс үйлдэх Зөвшөөрлийн тухай хуультай бол энэ асуудал бол шууд уялдаж тусгагдсан байгаа. Зүгээр гишүүд энэ асуудлыг хөндөх юм бол бид бас хэлэлцүүлгийн шатанд эргэж харах бололцоотой, ийм заалт байгаа юм.

С.Одонтуяа: 85 дугаар микрофон нэмж хариулъя.

А.Энхманлай: Ганбаатар гишүүний асуултад тодруулж хариулъя. Хилийн цэсийн асуудал, хилийн цэсийг бол УИХ-аас тогтоодог байгаа. УИХ-ын тогтоолоор хилийн цэс тогтоно. Тэгэхдээ ямар ч байсан газар зүйн нэрийг бас УИХ-аас баталдаг, энэ хуулиар бол хилийн цэс болон газар зүйн нэрийн асуудлыг бол бүх аймаг орон нутгууд, сум, нийслэл бүгдээрээ хилийн цэстэй болон хилийн цэсийн зурагтай газар зүйн нэрээр ингэж тодорхойлогдсон байна гэж зааж өгсөн байгаа. Тэгэхээр бол аймаг, сум, дүүрэг, нийслэл бол хилийн цэсийн өөр өөрийн гэсэн зурагтай явагдана. Одоо бол ийм бас хилийн цэсийн нэр болон зурагтай явж байгаа энэ хилийн цэсийг бол бид бүхэн бас 2012-15 оны хооронд тоон хэлбэрт шилжүүлээд, бол ингээд кадастрын мэдээллийн санд оруулаад энэ хилийн цэсийн дагуу бол үйл ажиллагааг бол мөрдүүлээд явж байгаа.

Хот, суурины ангиллын газраас гаднах, бусад ангиллын газар дээр иргэдэд газар өмчлүүлэх ажил бол одоо бол ингээд хийгдээд явж байна. Тэгэхээр энэ асуудал бол хууль батлагдсанаар бол бид бүхэн тухайн газар өмчилсөн иргэдийн асуудлыг бол холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх шаардлагатай. Нэгэнт иргэдэд өмчлөх асуудлыг шийдвэрлэхсэн учраас тухайн иргэнийг бол хохироохгүй, нөхөн олговортойгоор тухайн газрыг өөр зориулалтаар ашиглах, ийм шаардлага үүссэн тохиолдолд бол шийдвэрлээд явах ийм зохицуулалт байгаа.

Газар өмчлөх хэмжээний асуудал байгаа. Хуулиар бол угаасаа нийслэлд 0,07 га, аймгийн төвд бол 0,35, сумын төв тосгонд бол 0,5 га хүртэл гээд ингээд заачихсан. Энд бол яах вэ, орон нутгууд дээр бол газрын хүрэлцээний байдлаас хамаараад аймгууд бол өөр, өөрсдийн газрын хэмжээгээ хуулиар заасан хэмжээг бол багасгаж, ингэж иргэдийн хурлаараа л тогтоож, шийдэж, шийдээд явж байгаа, одоо бол. Энэ бол бас яг хэвээрээ үргэлжлээд, шинэ хуулиар бол бас тухайн орон нутгийнхаа онцлог хот төлөвлөлттэй нийцүүлээд энэ хуулиар олгогдсон дээд хэмжээнээс хэтрүүлэхгүй багасгаж бол ингэж шийдэж болно гэсэн ийм хуулийн зохицуулалтыг бол нэмж оруулж өгсөн байгаа.

С.Одонтуяа: Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Миний асуултуудад бас тодроод гарч ирэх болов уу гэсэн нэг 2 асуултыг тодруулчихъя. Нэгэнт өмчлөгдсөн газар өвлөх эрхээр дамжаад олон удаа

өмчлөл гээд үе дамжаад явчихаар үндсэндээ чөлөөлөгдөхгүй.

Төслийн 39.1-д заасан эдэлбэр газар хязгаарлагдмал учир ирээдүйд нэгэн цагт өмчлөх газар дуусна. Монголын газар сунахгүй, ирээдүйд төрөх Монгол Улсын иргэдэд өмчлөх авах газаргүй үлдэж, ялгаварлалд өртөнө өө гэсэн ойлголт байдаг. Энэ тухай төсөл санаачлагч ер нь ямархуу үзэл баримтлал, саналтай шийдэлтэй байгаа вэ? Ямар ч газрын хуулийн үзэл баримтлал энэ тухай заавал туссан байх ёстой, энэ тухай би олж уншсангүй, энэ талаар.

93.3-т ашигт малтмал хайгуул ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг газар одоо хилийн бүсэд ороогүй байгааг тайлбарлаж өгөөч.

93.3-ыг би асууж байна шүү.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ, Магнайсүрэн үү, 83 дугаар микрофон.

С.Магнайсүрэн: Ганбаатар гишүүний асуултад тодруулж хариулъя, сүүлийнхээс нь. 93.3 дээр бол ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хориглох олгохыг хориглох газар заасан. Энэ дотор улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээний газар гэж байгаа. Улсын тусгай хэрэгцээний газар дотор бол хилийн зурвас орчихсон байгаа. Өөрөөр хэлэх юм бол улсын тусгай хэрэгцээний газар бол 13 төрлийн тусгай харилцааны газар байгаа. Энд хилийн зурвас орж байгаа учраас ингээд хориглогдчихож байгаа юм.

Өмчлөлтэй холбоотой асуудал бид нар бол өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль 600 гаруй иргэн

өмчилсөн байдаг, энэ бол маш бага хувьтай, өнөөдрийн байдлаар 28 орчим хувьтай, өмчлөлтэй байгаа. Ингээд бид нар шинэ хууль оруулж ирэхдээ бол энэ концепцын өөрчлөлт хийсэн, өөрөөр хэлэх юм бол аж ахуйн зориулалтаар бол газар олгохыг хориглосон, өөр газар биш, зөвхөн хот тосгоны хэлбэр газар буюу тэр төлөвлөгдсөн инженерийн дэд бүтэцтэй тийм газар олгоно. Энэ нь бол хот тосгон, бусад суурины гэж байгаа учраас ... /минут дуусав/

С.Одонтуяа: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууна. Хурлын дарга нөгөө байхгүй гишүүдийг бүгдийг нь нэрийг нь хасчихсан байгаа.

О.Цогтгэрэл: Газрын тухай хууль, ерөнхий хууль багц хуулиуд орж ирж байна. Газрын хууль гэдэг өөрөө асар чухал, яагаад гэвэл энэ зах зээлийн эдийн засгийн харилцаанд эдийн засгийн энэ утгыг нь газаргүйгээр ойлгох аргагүй, ийм болохоор өнгөрсөн 30 жилийн хугацаанд бас олон л асуудал хуримтлагдсан байж таарах байх, ил тод биш байдаг, түүний цаана хээл хахууль маш л олон зүйлүүд байдаг, тэр тусмаа газар олгодог субъектүүд олон, үүнийг дагаад нэгдсэн биш бодлоготой олон зүйлүүд энэ газрын хууль дээр явж байгаа юм байх.

Тэгэхдээ өнөөдөр хэлэлцэх эсэх буюу үзэл баримтлалын түвшинд орж ирж байгаа болохоор бас тодорхой зүйлүүд энд ярихаас өөр аргагүй болчихоод байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг нутгийн өөрөө удирдах ёс гэдэг том үзэл баримтлалын том суурь тэнд байж байдаг. Ингээд аливаа нэг хууль орж орохоор тэнд

ямар нэгэн шалтаг шалтгаанууд гараад орон нутгийн өөрөө удирдах ёс буюу орон нутгийн эрх мэдэл рүү халдсан заалтууд маш ихээр орж ирдэг. Одоо энэ дээр нэгдсэн мэдээллийн сантай байна энэ тэр гээд л олон зүйлүүд ярьж байна. Тэр нь өөрөө заавал тэнд байгаа суманд байгаа газрын харилцаа эрхэлсэн түшмэдийг төвөөс томилно гэсэн үг болж яагаад заавал ингэж хувирчихдаг юм бэ? Хууль бүхэнд орж ороход нөгөө нэг Үндсэн хуулийн үзэл санаа биш төвлөрсөн удирдлагын зарчим гэдэг юм энэ улсад ерөөсөө нэг л хууль бүхэн дээр л тийм юм болчихлоо, ерөөсөө л төвлөрсөн д удирдлагын зарчим буюу тэр үзэл, Үндсэн хуулийн үзэл баримтлалаас нөгөө тийшээ явж байгаа.

Орон нутгууд явсаар байгаад эрх мэдлийн тухай ярихад санхүүгийн эрх мэдэл, боловсон хүчний эрх мэдэл гээд олон зүйлийг ярьж болдог. Санхүүгийн эрх мэдэл гэсэн чинь бие дааж байгаа орон нутаг байхгүй, бүгдээрээ төвөөс татаас авдаг, дээрээс асуудал шийдэгддэг, дээшээ харсан ийм нэгжүүд. Дахиад тэр боловсон хүчний эрх мэдлүүд нь ингээд бага багаар алхам алхмаар бүгд байхгүй болж байгаа.

Тэгэхээр эндээс юу хэлэх гэж байна вэ гэхээр АН-ын бүлгээс яг энэ Газрын тухай хууль, Газрын ерөнхий хууль дээр, Газрын ерөнхий хууль дээр бид бүхэн бас бүлэг дээрээ мэдээллүүдийг дахин авч сонсьё. Энэ салбарын оролцогч мэргэжилтнүүдийн үгийг сонсьё гэдэг ийм зорилготойгоор УИХ-ын тухай хуулийн 33.1-д заасан эрхийн хүрээнд ажлын 5 хоногийн завсарлага энэ хууль дээр авъя.

Хурал даргалагч УИХ-ын дэд дарга энэ асуудлыг шийдэж өгөөч.

С.Одонтуяа: УИХ-ын дэгийн тухай хуулийн 15.1-д зааснаар нам, эвслийн бүлгийн хүсэлтээр завсарлага авч болно гэсний дагуу АН-ын бүлгийн хүсэлтээр ажлын 5 хоногийн завсарлага өглөө.

13.11 цаг

Үдээс өмнөх хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Үдээс хойших хуралдаан 14 цагт эхэлнэ.

ҮДЭЭС ХОЙШИХ ХУРАЛДААН.

Г.Занданишатар: Амгаланг айлтгаад үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье.

Газрын ерөнхий хууль бол дагалдсан 40 хуультай том хууль. АН-ын бүлгээс завсарлага авсан байна.

Хоёр.Кадастрын тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Одоо Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар танилцуулна. Бэгзжавын Мөнхбаатар сайдыг индэрт урьж байна.

Б.Мөнхбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулахтай холбоотойгоор хийсэн тандалт судалгааны үр дүнд үндэслэн 1999 онд батлагдсан өнөөг хүртэл мөрдөгдөж байгаа Кадастрын зураглал ба Газрын кадастрын тухай хуулийг иргэн, хуулийн этгээдүүдийг газрын харилцаатай холбоотой үйлчилгээгээр хүртээмжтэй хангах, газарт тавих төрийн хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн хэрэгцээ, шаардлага болон олон улсын жишигт нийцүүлэн өөрчилж, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 6 бүлэг, 37 зүйлтэйгээр боловсруулаа.

Кадастрын үйл ажиллагааг нарийвчлан боловсронгуй болгох, 3 болон 4 хэмжээст кадастрын системийг бий болгох, олон улсын жишигт нийцүүлэн олон зориулалтат кадастрыг хөгжүүлэх, иргэн, хуулийн этгээдийн газрын харилцаатай холбоотойгоор үйлчилгээгээр хүртээмжтэй хангах, газарт тавих төрийн хяналт, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн дараах хэрэгцээ, шаардлагад хүрээнд хуулийн төслийг боловсруулаа. Үүнд:

1. кадастр гэдгийн нэгж талбар, түүний дэд талбар, хэл, зааг, байришил, хаяг, тухайн нэг талбартай холбоотой эрх, эрхийн хязгаарлалт, зураглал, үнэлгээ, татвар, төлбөр шинж чанар, төлөв байдал, нөөц нөөцийн чадварыг агуулсан мэдээлэл бүхий олон зориулалт, бүртгэл, түүнийг эрхлэх цогц үйлчилгээ, үйл ажиллагаа байхаар хуулийн төслийг боловсруулна.

2 дугаарт, Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийг хамруулан газрын нэгдмэл санг газар ашиглалтын зориулалтаар нарийвчлан тооллого хийж, улсын хэмжээнд ирэх төрөл харгалзахгүйгээр газрын гадарга, газар, түүний дэд талбар, объектыг улсын бүртгэлд бүртгэх, кадастрын зураглалын ажлыг хийх, кадастрын мэдээллийн сан үүсгэх, газрын үнэлгээ, төлбөр, татварын нэгдсэн тогтолцоог байгуулах шаардлагатай байгаа тул кадастрын нэгдсэн тогтолцоо бий болгохтой холбоотой эрх зүйн зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан болно.

3-т, Газрын холбоотой өргөдлийг хүлээж авахаас өгсүүлээд түүнийг судлах, зураглах эрхийг бүртгэж баталгаажуулах хүртэлх кадастрын дэс дараалсан үйл ажиллагаа болон оролцогч талуудын эрх, үүргийг нарийвчлан хуульчлаагүйгээс иргэдийн өргөдөл, хүсэлт шийдвэрлэгдэхгүй байх, газрыг давхардуулан олгох үйл ажиллагааны дараалал алдагдах, зарим үйл ажиллагааг орхигдуулах зэргээс болж иргэд хохирох тохиолдол гарч байгаа тул кадастрын дэс дараалсан үйл ажиллагааг хуульчилж, тодорхой болгохоор хуулийн төсөлд тусгалаа.

Мөн хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд улсын хэмжээний кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системд суурилсан дундын мэдээллийн сан байгуулах, тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн газартай холбоотой мэдээллээр тухай бүр хангах, кадастрын зураглалын ажил болон хээрийн судалгааны ажлыг нэгдсэн системд оруулах баталгаажсан кадастрын зургийн зохицуулалтын талаар тодорхой тусгасан болно.

Мөн газрын маргаан гарахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, газрын кадастрын мэдээллийн сангийн хяналтын талаар шаардлагатай зохицуулалтууд болон мэдээллийн санд санаатай болон санаандгүй өөрчлөлт оруулсан, хууль тогтоомж зөрчсөн албан тушаал нь хариуцлага тооцох зүйлийг ч тусгаж өгсөн болно.

Газрын үнэлгээтэй холбоотой нэр томъёог бусад хууль тогтоомж, олон улсын стандарттай нийцүүлэх, газрын үнэлгээний үйл ажиллагаанд оролцогчдын эрх, үүргийг тодорхойлж, олон улсын жишигт нийцсэн, өөрийн орны онцлогт тохирсон газрын үнэлгээний тогтолцоо бий болгох боломжийг хуулийн төсөлд нэг бүлэг болгон оруулна.

Хуулийн төслөөр дундын мэдээллийн сангаар дамжуулан газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэх, нэгж талбарын цахим хувийн хэргийн иж бүрдэл шийдвэрлэх хугацаа болон харилцан мэдээ солилцох, дугаар олгох үйл ажиллагаа зэргийг оруулсан болно.

Энэхүү хуулийн төслийг эцэслэн шийдвэрлэж өгөхийг хүсэж байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Нанзадын Наранбаатар танилцуулна, индэрт урьж байна.

Н.Наранбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын

ЗГ-аас 2022 оны 6 сарын 17-ны өдөр Монгол УИХ-д өргөн мэдүүлсэн Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын нутаг дэвсгэрт кадастр эрхлэх, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах, кадастрын нэгдсэн тогтолцоог бий болгох, кадастрын үйл ажиллагааг тодорхой болгох, дундын мэдээллийн сангаар дамжуулан газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийг эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгэхэд нэгж талбарын цахим хувийн иж бүрдэл шийдвэрлэх хугацаа болон харилцан мэдээлэл солилцох, дугаар олгох үйл ажиллагааг зохицуулах зэрэг асуудлыг шийдвэрлэхээр уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар кадастрын мэдээллийн нэгдсэн сантай болох, иргэдийн газрын эдийн засгийн өгөөж, үнэ цэний ойлголт, үнэлэмжийг нэмэгдүүлэн газрын зах зээлийн үнэд тулгуурлан төлбөр, татварын хэмжээг бодит байдалд нийцүүлэн тогтоох, цахим бүртгэлийн үйлчилгээг кадастрт нэвтрүүлэх нэгдсэн бүртгэлтэй болсноор улсын хэмжээний статистик тоо мэдээ бодитой, үнэн зөв гарч, газар, үл хөдлөх эд хөрөнгийн эрхийг газрын нэгж талбарт суурилсан кадастрын зургийг үндэслэн бүртгэдэг болсноор давхардал, хийдэл гаргахгүй гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг парламент.мн цахим сайтад

байршуулж, иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Байнгын хорооны хуралдаанаар төслийг хэлэлцэх үед УИХ-ын гишүүн Туваан орон нутагт кадастрын зөрчил, маргаан ихээр гардаг, үүний нөхцөл шалтгааныг тодорхойлж, хуулийн төсөл, зохицуулалтыг тодорхой тусгасан эсэх, кадастрын зураглал хийдэг компани, ААН-ийн үйл ажиллагаанд салбарын яам, холбогдох байгууллагын тавих хяналтын тогтолцоо хэрхэн хэрэгжиж байгаа талаар асуулт асууж, хариулт авлаа.

Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63,6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Кадастрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Кадастрын зураглал ба газрын кадастрын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хаягжуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хот байгуулалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Сэргээгдэх эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрчим хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах

тухай, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Ойн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Харилцаа холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Усны тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хот суурины усан хангамж, ариутгах, татуургын ашиглалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Бэгзжавын Мөнхбаатар Барилга, хот байгуулалтын сайд, Хаянгаагийн Болорчулуун сайд хаана байна, ХХААХҮ-ийн сайд, Бат-Өлзийн Бат-Эрдэнэ сайд хаана байна, Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Барилга, хот байгуулалтын яамны ТНБД Сандагийн Магнайсүрэн, Хууль зүй, дотоод хэргийн яамны ТНБД Пүрэвжавын Сайнзориг, Сайнзориг дарга хаана байгаа юм, алга байна, ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Цэндгомбын Болорчулуун, Болорчулуун сайдыг дуудъя. Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга Бямбарагчаагийн Тэлмүүн, Тэлмүүн хаана байна. Ажлын хэсэг нь байхгүй юм байна шүү дээ энэ чинь. Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Цогтын Баярбат, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн

газрын дарга Анандын Энхманлай, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын Захиргаа удирдлагын хамтын ажиллагааны газрын дарга Раднаабазарын Ганхуяг, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын Газрын зохион байгуулалтын хэлтсийн дарга Цэвэлмаагийн Энхбаяр, Газар зохион байгуулалт, геодези зүйн газрын Кадастрын хэлтсийн дарга Пүрэвдоржийн Баянтүмэн, ХХААХҮЯ-ны Хуулийн хэлтсийн дарга Энхбаатарын Цолмонжаргал, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хуулийн хэлтсийн дарга Сүхбаатарын Цогтгэрэл, Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Батдэлгэрийн Нямдорж, АМГТГ-ын Хуулийн хэлтсийн дарга Рагчаагийн Энхтайван, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга Ганболдын Батзориг, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Гомбодоржийн Болормаа, Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлого хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч Базарпүрэвийн Гоёсайхан, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн Дэндэвийн Энхтуяа, ХХААХҮЯ-ны МАА-н бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Найдангийн Бямбадорж.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцууллаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал,

дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүд нэрээ бүртгүүлнэ үү.

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн асуулт асууна.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Газрын тухай багц хууль бол үнэхээр чухал ач холбогдолтой хууль. Ерөнхий хууль дээр нь сая бас АН-ын бүлэг завсарлага авлаа. Одоо Кадастрын тухай хуулийг хэлэлцэж байгаа юм.

Монгол Улсад энэ газрын шинэтгэлийг хийх зайлиггүй шаардлага үүссэн. Тэгээд энэ дотор нэг чухал байр суурьтай хууль нь бол яахын аргагүй Газрын кадастрын тухай хууль байгаа юм. Би газрын кадастртай холбогдуулаад 2 зүйлийг хууль санаачлагчаас асууя гэж бодож байна.

Нэгдүгээрт нь, энэ газрын кадастрыг тогтоохдоо ил тод нээлттэй байх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр энэ хуулийн төсөлд юу орж байна вэ гэж асуух гэж байгаа юм. Энэ байдаггүйгээс болоод нөгөө танилтай талтай нь илүү мэдээлэлтэй нь газар авдаг аа гэдэг асуудал гарч ирж байгаа юм.

Хоёрдугаарт, кадастрын давхцал маш их байдаг. Энэ бол төв суурин дээр байдаг. Маш их хэмжээний давхцал гардаг, энэ давхцалаас болоод иргэд хохирдог янз бүрийн асуудлууд байна. Тэгэхээр цаашидаа зөвхөн кадастрын зураглалаар газар олгодог, кадастраар нь газар олгодог, засаг дарга захирамж гаргахдаа кадастраар нь олгодог, үүнийг энэ хуульд тусгаж өгч үү гэдэг ийм 2 дахь асуулт.

Гуравдугаарт нь хөдөө орон нутагт байгаа юм. Газар нутгийн нутаг дэвсгэртэй холбоотой асуудал. Монголчууд яах вэ, өмнө нь дандаа өндөрлөгүүд дээрээ газраа тогтоочихсон, өндөрлөг цэгээрээ. 1950-аад оны, 60-аад оны газар нутгийг тогтоохдоо бол сумдын газар нутгийг тогтоохдоо, аймгуудын газар нутгийг тогтоохдоо өндөрлөг цэгээрээ тогтоочихсон. Сая сүүлийн нэг арваад жилийн хугацаанд кадастрын зураглалаар үүнийгээ баталгаажуулсан. Ингээд баталгаажуулалт хийх явцад маш их хэмжээний үг хэл, маргаанууд гарсан. Жишээлбэл юу гэдэг юм, 60 онд энэ овоо манай сумын нутаг байсан, сая кадастрын зураглал хийгээд энэ манайх больчихлоо, өөр газар орчихлоо гээд ингээд хөдөөгийн малчдын газар нутгийн маргааны асуудал энэ кадастрын зураглал хийгдсэнээс хойш нэмэгдсэн, нэмэгдсэн.

Тэгэхээр энэ шинэ хууль батлагдаж гарсны дараа энэ кадастрын маргаан арилах уу гэдэг асуудал байгаа юм. Сая кадастрын зураглалыг хийлгэхдээ дандаа хувийн хэвшлийн компаниуд хийлгэж байгаа. Тэгээд аль хөдөлгөөнтэй сумдын дарга нар нь авч давхиад кадастрын зураглал хийлгээд, өөрсдөдөө давуу байдлыг бий болгоод байгаа юм харагдаад байгаа юм. Энэ бол газар нутгийн маргааны үндэс нь би эх нь юм болов уу гэж бодоод байгаа юм. Тийм учраас энэ хууль батлагдсанаар энэ саяын кадастрын зураглалаар хийсэн маргааныг 1960-аад оны үед тогтоосон хил, хилийн цэг 2-ыг яаж яг нэг цэгтэй болгох вэ? Үүнээс болоод малчдын дунд газар нутгийн маш их хэмжээний маргаан гарч

байна. Одоо энэ сүүлийн жилүүдэд ган зуд болж байна, бэлчээрийн татагдал нь л нэлээд хэмжээгээр бий боллоо, үүнтэй холбоотойгоор газар нутгийн маргаан бүр нэмэгдэж байгаа юм. Тийм учраас би энэ хуулийн төсөл хэлэлцэж батлагдсанаараа энэ газар нутгийн маргаан, кадастрын зураглал дээр гарсан энэ маргаан арилах уу гэдэг ийм 3 зүйлийг би хууль санаачлагч Мөнхбаатар сайдаас асууя. Баярлалаа.

Г.Занданишатар: Эхлээд хууль санаачлагч Бэгзжавын Мөнхбаатар сайд хариулна.

Б.Мөнхбаатар: Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Кадастрын асуудлууд энэ хуулиар бас нэлээн шинэчлэгдэж орж ирж байгаа, давхцалууд их байгаад байдаг, өөрөөр хэлбэл яг амьдрал дээр төлөвлөлтийн дагуу газар олголтууд хийх ёстой, тэр олголтууд нь кадастр нэгдсэн санд бүрдэгдэх ёстой байдаг нь бүртгэгддэггүй. Тухайлбал, Улаанбаатар хотод дүүргийнх нь олгосон олголтыг нийслэлийн кадастрын албанаас бүртгээгүй байсаар байгаад нийслэлд бүртгэнэ гээд ингээд олгочихсон газрууд дээр давхардаж болох зэрэг олон асуудлууд бол гарч ирдэг. Энэ асуудлыг бид нар кадастрын нэгдсэн сантай болж байгаа учраас бид нар энэ асуудлуудыг газар олголт, кадаструуд бүгд нэгдмэл байдлаар явах учраас энэ маргаануудыг бол бид нар шийдвэрлэнэ ээ гэж ойлгож байгаа.

Хөдөө орон нутгаа та хэлж байна, уулын оройноос уулын орой татчихсан байдаг, газрын хилийн цэсийг. Тэгээд нөгөө ард түмэн маань ярихдаа энэ манай энэ уулын ар өвөр

манай сумын нутаг гэж ярьдаг байсан. Тэгээд нэг уулын оройгоос уулын орой татчихаар уулын ар өвөр нь өөр сумдын нутаг бол болчихдог. Тэгээд энэ асуудлуудыг бид нар бас нэгдсэн нэг системтэй болж байгаа учраас энэ асуудлыг бид нар аль болох маргааныг цэгцэлж шийдэхээр энэ хуулийн төсөлд бол орж ирсэн байгаа.

Тэгээд хувийн компаниудыг та хэлж байна, сумын дарга нар кадастрын зураг хийдэг компанийг авч яваад байдаг, хилийг бол кадастрын нэгдсэн системд ороогүй хувийн компанийн хийсэн дээр мэдээллийн байр зүйн зураг нь бол яг албан ёсны бүртгэлд ороогүй учраас бол шийдэгдэх боломжгүй.

Нэмэлт мэдээллийг Энхманлай дарга.

Г.Занданишатар: 85, Энхманлай дарга хариулъя, Геодези газар зүйн

А.Энхманлай: Тогтохсүрэн гишүүний асуултад нэмж хариулъя. Кадастрын тухай бол бид бүхэн Монгол Улсын кадастрын нэгдсэн системд нийтдээ сая 155000 нэгж талбарыг өнөөдөр бүртгээд түүн дээр үйл ажиллагааг хэрэгжүүлээд явж байна. Ер нь улсын хэмжээний газрын бүртгэл, тооллого, мөн газар олгох харилцаануудыг бол энэ кадастрын тухай хуулиар нарийвчлан зохицуулсан. Тэгэхээр энэ хуульд бол зааснаар бид бүхэн бол 7 үндсэн систем дээр суурилж газрын олгох, түүнийг бүртгэх, хаягжуулах асуудлуудыг бол мөн үнэлгээ болон төлбөр тогтоох ажлууд бол энэ системүүдээр дамжиж хэрэгжинэ.

Өнөөдрийн байдлаар газрын кадастрын мэдээллийн систем улсын

хэмжээнд бол нээлттэй болсон байгаа. Энэ системээс бол иргэд өөрсдийн газар болон бусдын газар эзэмшиж, ашиглаж байгаа байдлыг бол чөлөөтэй харж, тэндээс мэдээлэл авах ийм бололцоог бүрдүүлж өгсөн.

Кадастрын давхцал зөрчлийг бол цаашид бол гаргахгүй байх ийм зохицуулалт орж өгсөн байгаа, яагаад гэвэл газар зохион байгуулалтын шат шатны төлөвлөгөөг заавал нэгж талбар бүрээр үүсгэж байж, өөрөөр хэлбэл кадастрын зураг дээр төлөвлөж, нэгж талбараар төлөвлөж байж асуудлыг шийдэж байгаа. Ингэхээр бол цаашидаа ямар нэгэн байдлаар зөвшөөрөл гарсны дараа энэ асуудал шийдэгдэхгүй, наана нь энэ кадастрын систем дээрээ урьдчилж бүртгэгдээд, зөвшөөрөл, шийдвэр гаргахаар албажиж, цаашаа баталгаажих зарчмаар энэ газрын асуудал ингэж бүртгэгдэж явна.

Хилийн цэсийн асуудал дээр бол бид бүхэн нэг нийт сумдын нэг, 226 сум нь бол 1977 оны АИХ-ын зарлигаар ингэж тогтоогдсон байдаг. Үүнээс хойш бол УИХ, АИХ-ын нийтдээ нэг 24 удаагийн тогтоол, шийдвэр, зарлигуудаар бол Монгол Улсын сумдын хилийн цэсийг бол тогтоосон байгаа. Тэгэхээр одоо ямар асуудал үүсэж байгаа вэ гэхээр үүнээс хойш 2002 онд УИХ-аар газар зүйн нэр батлагдсан байгаа юм. Тэгэхээр хилийн цэс тогтоосноос хойш газар зүйн нэр батлагдсан, гучаад жилийн дараа батлагдсан. Тийм учраас бол бид бүхэн энэ тогтоох явцдаа зарим нэг хилийн цэс тогтоосон газар нутгуудын нэрүүд, зарим нь бол өөрчлөгдсөн. Эндээс болж зарим иргэдийн хооронд маргаантай асуудал үүсдэг.

Мөн тогтоосон хилийн цэсийг газар зүйн нэрийг бас иргэд буруу ойлгосноос болж бас хоорондоо энэ бол манай хилд хамаарагдаж байгаа уул, эсвэл энэ нь ороогүй гэдгээр хоорондоо бас ийм маргаанууд үүсэж байгаа, одоо улсын хэмжээнд нэг 400 гаруй ийм маргаантай асуудал байгаа. 100 гаран сум дээр явагдаж байна. Бид хэд бол, энэ дээр бол ажлын хэсэг байгуулж, тухайн үед нь очиж газар дээр нь ажиллаж, хэмжилт болон тодруулалтын ажлыг хийж, энэ асуудлыг бол шийдээд явж байгаа. Цаашидаа бол энэ кадастрын хууль, Газрын ерөнхий хуульд зааснаар бид бүхэн бол энэ газар зүйн нэрийг нэг мөр УИХ-аар шийдүүлэх, хилийн цэсийн маргаантай асуудлыг, мөн Их Хурлаар орж шийдэхийг нь Их Хурлаар оруулж шийдэх, орон нутагт нь ойлгуулж, ард түмэнд бас зөв ойлголт төрүүлж, хилийн цэсийн маргаантай асуудлыг бол шийдэж явах ийм боломж нөхцөлийг бол бий болгож өгч байгаа.

Г.Занданшатар:

Дуламдоржийн Тогтохсүрэн гишүүн МАН-ын бүлгийн дарга тодруулж асууна. 1 минут.

Д.Тогтохсүрэн: Тэгэхээр энэ хуулийг дагаж та нар би ойлгохдоо энэ журмын тухай хууль дагаж мөрдөх журмын тухай хууль орж ирсэн юм, үг лав байхгүй байх юм. Сая Мөнхбаатар сайд, Энхманлай дарга нарын асуултаас би юу гэж ойлгож байна вэ гэхээр энэ хууль батлагдсаны дараа одоо кадастрын хувьд маргаантай байгаа хилийн цэсүүдийн маргааны асуудлыг цэгцлэх нэг тийм тодорхой хэмжээний журам гаргаж байгаа юм байна гэж ойлгосон. Гэтэл

тийм журам орж ирээгүй байгаа байхгүй юу. Маш их хэмжээний маргаан байгаа юм. Тэгэхээр би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр энэ хууль гарсны дараа тодорхой хэмжээнд энэ маргааныг цэгцлэх ажил хийх хэрэгтэй байгаа юм. Ингэхгүйгээр бид нар бас энэ газрын шинэтгэлийн ажлыг хийхэд хийсний дараа бол хийж болохгүй байгаа юм. Тийм учраас би бол юу гэж хэлэх гэж байна вэ гэхээр та бүхэн нэг тодорхой хэмжээнд цаг хугацаа гаргаж, энэ маргаантай сумдын хилийн цэсийг маргааныг нь шийдвэрлэх асуудлыг 2 талаас нь 2 талын оролцоо хоёуланг нь хангаж байж ингээд шийдэх ажил хиймээр байгаа юм. Ингэхгүйгээр энэ газрын шинэтгэл хийж болохгүй байгаа юм.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ. 85, Энхманлай.

А.Энхманлай: Тэгэхээр бол ер нь газрын, орон нутгуудын хилийн цэсийн маргаантай асуудлыг шийдэх ажлын хүрээнд, бас ЗГ-аас ажлын хэсэг байгуулагдсан. Энэ ажлын хэсгийн хүрээнд, бас бид нар ажлууд хийгдээд явж байгаа.

Мөн бас улсын хэмжээний газар зүйн нэрийг 20 жилийн өмнө батлагдсан газар зүйн нэрийг шинэчилж тогтоох бас ажлын хэсэг гараад бас энэ ажлууд бол орон нутгуудаар бас нэлээд сайн хийгдээд явж байгаа. Орон нутгийн иргэдийн хурлаар бүх асуудлууд дэмжигдэж, тэндээс тогтоол шийдвэр гаргаж ирэх ёстой. Одоогоор нэг 50 гаран хувьтай бол энэ орон нутгуудаас тогтоол гаргаж ирэх асуудал ирж байна. Тэгээд энэ асуудал бүрэн шийдэгдэхээр ЗГ хэлэлцээд Их Хурлаар энэ саяын хилийн цэстэй

маргаантай асуудлууд, газар зүйн нэрийн тодруулалттай холбоотой ажлууд бол орж ирж батлагдана. Тэгэхээр бол энэ хууль хэрэгжих шинэ хууль батлагдаад хэрэгжихийн наана бол энэ асуудлууд бол бүрэн шийдэгдээд явах бас боломж байгаа гэж бодож байгаа юм.

Г.Занданшатар: Мөнхбаатар сайд нэмж хариулах уу. Магнайсүрэн.

Тогтохоо дарга аа, цагийн дараа санал хураалт явуулна. Ирцүүд ээ, санал хураалтад бэлдээрэй. Би бас энэ геодези, газар зүйн тухай хууль энэ өргөн баригдчихаад хэлэлцэхгүй байх юм. Энэ Байнгын хороо нь яагаад, бараг хамт явахгүй бол энэ болохгүй л хууль байгаа юм даа. Үүнийгээ яагаад оруулдаггүй юм.

Одоо Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Энэ уг нь УИХ-ын гишүүдийн хамгийн анхаарах ёстой хуулийн нэг юм байгаа юм даа. Иргэд газрынхаа тухай 2-3 удаа очдог, тэр Тамгын газар тэр Засаг дарга байна уу, тэр холбогдох газар. 85 хувь нь дандаа хүнд суртлын бай болдог оо гэж судалгаа байгаа шүү дээ. Үүнийг л шийдэх гэж энэ байгаа гэж би ойлгож байна. Тэгэхдээ яах вэ, 99 онд энэ хууль анх гарсан кадастрын хууль, 9 удаа нэмэлт, өөрчлөлт оруулж, муу ч сайн ч Монгол Улс даяараа кадастрын тогтолцоотой болсон, одоо сайжруулах цаг болсон.

Тэгээд би асуулт асууя, надад тодорхой хариулж өгвөл их сайн.

1 дүгээр асуулт. Хуулийн үзэл баримтлалд дурдсан ерөнхий бүтэц,

зохицуулах ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ гэсэн хуудас тав дээр нь байгаа шүү. Хуулийн бичлэгтэй ерөөсөө тохирохгүй байгааг нэг тайлбарлаж өгөөч. Энэ бол ямар ч хуулийн бичлэг биш байна, 2-7 дугаар бүлэгт үзэл баримтлал ба бичлэг ерөөсөө огт тохирохгүй байгаа юм. Энэ дээр би асуулт хариулт авмаар байна.

2 дугаар асуулт. Үзэл баримтлалд 2 дугаар бүлэгт кадастр, кадастрын муж, тойрог, кадастр эрхлэх субъект, эрх үүргийн талаар тусгана гэж ээ. Төсөлд муж, тойргийн тухай ойлголт ерөөсөө олдоогүй, байхгүй байгаа. Би лав олж хараагүй, төсөл дээр.

Тэгэхээр кадастрын муж тойрог гэдэг энэ нь тогтмол юм уу, тогтмол бус юм уу, хуульд тусган тогтоох боломж байгаа юу. Төслийн 31.11, 31.12-т кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй этгээдийг эрхийг муж тойрог бүрд олгоно, тоог нь агентлаг тогтоохоор заасан. Одоо кадастрын үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй этгээд байгаа юу, хэд байгаа вэ. Хууль батлагдсанаар кадастрын хэдэн муж, тойрог, тэнд ажиллах тусгай зөвшөөрөлтэй этгээдийн тоо хэд байх урьдчилсан тооцоо байгаа юу, мэдээж байх ёстой. Түүнийг нь тодорхой хэлж өгнө үү.

3 дугаар асуулт. Төслийн 19.5-д ерөнхий үнэлгээг кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээд хийж болно гээд заачихсан байгаа. 2023 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжих Зөвшөөрлийн тухай хуульд кадастрын үйл ажиллагаа

эрхлэх мэргэжлийн байгууллагын эрхийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь олгоно гээд зохицуулчихсан байгаа. Тэгэхээр эндээс үзвэл кадастрын үйл ажиллагааг хувь хүн эрхлэхгүй байхаар зохицуулсан байгаа. Гэтэл хуулийн төсөлд хувь хүн гэж заачихсан байна.

Мөн Газрын хуулийн төсөлд газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг тодорхой зохицуулаагүй гэж би 1 дүгээр асуулт дээр байгаа, түүн дээр бол Барилга, хот байгуулалтын яам гээд тодорхой заах ёстой.

Миний энэ 3 дугаар асуултад хариулж өгнө үү.

4 дүгээрт, төслийн 19.5-д ерөнхий үнэлгээг кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээд хийж болно гэсэн нэг төрлийн тусгай зөвшөөрлийн эрхээр өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг хуулиар даван зөвшөөрч буй тийм буруу зохицуулалт болох гээд байгаа юм шиг практик ажиглагдаж байна. Энэ дээр надад тайлбар хэрэгтэй байна. Би ийм 4 асуултад хариулт авъя.

Г.Занданшатар: 85,
Энхманлай дарга.

А.Энхманлай: Кадастрын хууль. Кадастрын хууль маань бас өмнөх хуулиасаа илүү шинэлэг юу гэдэг юм, олон улсын, бас мөрдөж байгаа зарчмыг бид бүхэн бас энэ хууль дээр тусгаж өгсөн байгаа. Урьд нь бол бид бүхэн эрхийн кадастр эрхлээд яваад байсан, энэ бол цаасан суурьтай ч байсан, тэрийг бол бид бүхэн цахимжуулах, олон улсын бас

кадастрын хэмжил зураглаачдын холбооны хуралдаанаас тунхаглал батлагдсан байгаа, олон улсад мөрдөж хэрэгжүүлэх. Энэ тунхаглал дээр бол бүгд энэ цахим хэлбэр рүү шилжүүлэх ёстой.

Мөн газар болон үл хөдлөх хөрөнгө бол хамтдаа заавал бүртгэгдэх шаардлагатай, мөн энэ бүртгэгдэж байгаа мэдээллүүд, мөн газар үл хөдлөх хөрөнгүүд маань үнэлгээ, өөрөөр хэлбэл санхүүгийн кадастр бас хийгдэх хэрэгтэй. Мөн газар өөрөө өөрийн гэсэн нөөц чадвар, чадамжтай байдаг. Тийм учраас энэ газрын өөрийнх нь бас чадвар, чадамж, нөөц бололцоог бол заавал энэ бүртгэлийн юунд бүртгэгдэх ёстой гэсэн ийм зарчим ярьсан. Тэгэхээр энэ Кадастрын тухай хуулийн бас үзэл баримтлал дээр заасны дагуу энэ кадастрыг бол олон улсын жишигт нийцүүлж, нөөцийн, санхүүгийн, эрхийн гэсэн төрлүүд дээр бол заавал газар болон үл хөдлөх хөрөнгийг ингэж бүртгэж явах ийм хуулийн зохицуулалт бол орж ирсэн байгаа.

Мөн үүнээс гадна бас кадастрын үйл ажиллагаа хэрэгжүүлж байгаа байгууллагуудыг тодорхой эрх үүргийг нь зааж өгсөн. Кадастрын мэргэжлийн байгууллага гэхээрээ кадастрын зураглал үйлдэж байгаа, мөн санхүүгийн үйл ажиллагаа, үнэлгээ хийгдэж байгаа байгууллагуудыг нэрлэж байгаа. Мөн кадастр эрхэлж гол үйл ажиллагаа явуулах газар бол газрын салбар бүрийн байгууллагууд байгаа. Энэ хуулиар бас газрын эзэмшүүлэх эрх олгох, өмчлүүлэх эрх олгох асуудлуудыг нарийн хугацаа зааж хуульчилж өгсөн байгаа, өөрөөр хэлбэл газрын асуудал маш их удаан

хугацаанд ингээд шийдэгддэг байсан бол 3 дахин богиносгосон байгаа, одоо бол газрын асуудал 15-18 хоногт багтаж бол ихэвчлэн шийдэгдэхээр заасан. Хамгийн урт хугацаа бол газар өмчлөх харилцааг бол 30 хоногт, 90 хоногт шийддэг байсан бол энэ хуулиар бол 30 хоногт шийднэ гэсэн ийм бас хуулийн зохицуулалтыг орж өгсөн.

Одоо улсын хэмжээнд 245 кадастрын зургийн үйл ажиллагаа эрхэлдэг тусгай зөвшөөрөлтэй ААН-үүд байгаа. Бид бүхэн бол энэ тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийг бас одоогийн байдлаар явуулах бас их хүндрэлтэй байгаа. Яагаад гэхээр энэ кадастрын зургийн зөрчил нэлээд их гаргаж байна, хэмжилтийн алдаа их гаргаж байгаа, үүнийг бол журамлах, цаашид бол бас цэгцлэх үүднээс энэ нийт нутаг дэвсгэрийг мужийн тойрогт хувааж байгаа. Ингээд тойрогт нь хуваагаад тухайн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зөвшөөрөл авсан байгууллага, тэнд бол нэгж талбарын тоо, хүн амын тоо, газар нутгийн хэмжээнд нь тохируулаад хэчнээн мэргэжлийн байгууллага, энд бол кадастрын үйл ажиллагаа эрхлэх боломжтой юм, тэрийг нь тогтоогоод тэнд нь бол зөвхөн кадастрын зургийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг олгож, түүнд нь хариуцлага бусад үйл ажиллагааг мөрдүүлж ингэж тооцож явахаар бол энэ хуулийн төслийг зохицуулсан.

Газрын ерөнхий үнэлгээ газрын мөн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ хийх ажлуудыг бол бас энэ холбогдох үнэлгээ, үнэлгээний журам, мөн стандарт мөн бус санхүүгийн байгууллагуудаас гаргаж байгаа зарчмын дагуу бас ингэж хийхээр бол

бид бүхэн энэ хуулийн төсөлдөө бас тусгасан байгаа.

Г.Занданишатар: 6 асуулт асуусан. Талыг нь ч хариулсангүй шүү дээ, Та. Хэн хариулах вэ. Асуултад хариулахгүй бол яаж хууль чинь явах юм бэ? Яг тодорхой 4 асуулт тэгээд асуусан шүү дээ.

Эхлээд хариулчих, бичиж тэмдэглэж авдаггүй юм уу, энэ хүмүүс юм асуугаад байхад. Яг хуулийн заалтын 40.1 энэ тэр гэж байгаад асуусан шүү дээ. Хувь хүн гэххээд нэр томъёоны тодорхойлолт чинь буруу байна гэж байна. 84.

Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн дарга Баянтүмэн.

Үзэл баримтлалын 2 дугаар бүлэг дээр муж, тойрог гэсэн томъёолол орсон. Хуулийн төсөл дээрээ болон муж, тойргийг бол яг холбогдох журмаар зохицуулахаар хуулийн төслөөсөө бол хассан байгаа хэлэлцүүлгийн явцад. Хууль зүйн яамтай хамтран хэлэлцүүлэг дээрээс муж тойргийн зохицуулалтыг нь бол журмаар зохицуулъя гэдэг юугаар хуулийн төсөлд оруулж өгсөн байгаа.

Г.Занданишатар: Тэр мужлал, хувь хүн гэдэг нь яаж байгаа юм. Ээ хуулиа ер нь мэдэж байгаа улс байгаа юм уу, наана чинь. 82. Хуулийг нь аваад ир дээ.

Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын газрын дарга Баярбат.

Кадастртай холбоотой үйл ажиллагааг бол энэ хуулийн 31.7 дээр тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээд

эрхэлнэ ээ гэдгийг нь заагаад өгчихсөн байж байгаа.

Г.Занданишатар: 19.5-ыг асуугаад байна шүү дээ.

Ц.Баярбат: 19.5 дахь болохоор кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хувь, хуулийн этгээд бол ерөнхий үнэлгээ. Энэ бол нөгөө кадастрын үйл ажиллагаа биш шүү, энэ бол ерөнхий үнэлгээтэй холбоотой юун дээр орсон ийм заалт.

Г.Занданишатар: Үгүй ээ, үгүй, наадах чинь ерөнхий үнэлгээ, кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй хувь хүн, хуулийн этгээд хийж болно гэж байна шүү дээ. Тэгээд кадастрын тусгай зөвшөөрөлтэй хувь хүн байж болох юм байна гэж ойлгогдоод байгаа биз дээ, наад хуулийн чинь талаар. Түүнийг чинь асуугаад байна шүү дээ.

Ц.Баярбат: Тэгвэл байж болно. Түүн дээр заалт нь бол тийм утгатай байгаа.

Г.Занданишатар: Юу гэсэн үг вэ, наад чинь. Зөвшөөрлийн тухай хуулийнхаа зүйл, дагалдах хуульд. 83, Магнайсүрэн.

С.Магнайсүрэн: Ганбаатар гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ хуулийн төсөл маань 6 сард бид нар өргөн мэдүүлсэн. Ингээд одоо Зөвшөөрлийн хууль бол батлагдаад энэ 2023 оны 01 сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлнэ. Зөвшөөрлийн хуульд нийцүүлээд бусад хууль тогтоомжийг бид нар нийцүүлэх тийм чиглэлийн дагуу ЗГ-аас хуулийн төслүүдийн өөрчлөлтийг хийгээд УИХ-д өргөн мэдүүлсэн байгаа. Энэ хүрээнд энэ яг нийцээд явж байгаа. Энэ хувь хүн,

хуулийн этгээдэд кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл байхаар энэ хуулийн төсөл бол энэ б сард өргөн мэдүүлсэн гээд бас жоохон тийм нэр томъёоны хувьд бол зөрчилдөж байгаа юм байгаа юм. Үүнийг бид нар нийцүүлчих ийм бололцоо гарах байх гэж ингэж бодож байгаа.

Түрүүн бас Ганбаатар гишүүн хэлсэн, энэ үзэл баримтлалд байгаа зарим нөгөө зүйлийн агуулга, толгой, гарчиг нь бас зарим тохирохгүй байгаа. Ийм асуудлууд нь бол өргөн мэдүүлэх үед бид нар нөгөө олон хэлэлцүүлгүүд явуулаад, ингээд бас зарим зүйл бол зөрсөн байгаа. Гэхдээ агуулга концепцын хувьд бол эвдрээгүй, яг бас зарим гарчгийн хувьд бас зөрж байгаа юм байгаа, тийм.

Г.Занданишатар: Газрын ерөнхий үнэлгээ чинь суурь үнийг тогтоох үндэслэл шүү дээ. Газрын суурь үнийг тогтоох үндэслэл. Тэр нь тэгээд хувь хүн ерөнхий үнэлгээг хийх юм уу гэдэг агуулгаасаа тэр чинь хуулийн, тэгвэл Зөвшөөрлийн тухай хуулийн зөрчил биш, энэ хуулийн чинь концепц хоорондын зөрчлийг яриад бас гарч ирээд байна шүү дээ.

Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Ер нь бол Их Хурал дээр мань мэтэд, энэ ирж байгаа энэ хуулийн тогтолцоог чинь бүр а, б-гүй л мань мэт үзнэ шүү дээ. Үүний чинь ард хүмүүсийн амьдрал ёстой тэгээд л зовлон, зүтгүүр бүгдээрээ л байгаа гэж бодоод л, итгээд л уншаад зүтгээд байна, Харин ч энэ газрын хуулийнхан бас ч гэж нэг 20 хувьтай хариулаад байгаа байхгүй юу. Бусад нөхдүүд бол яамд

бол бүр шал тэс хөндлөн юм ярьдаг байхгүй юу, тэгээд л олны өмнө ичээгээд байлтай нь биш.

Би уг нь дараагийн тодруулга дээр асуух тэр барьцаалах тухай 9.1.10 дээр байгаа барьцаалах тухай аягүй олон заалтууд байгаа шүү. 9.1.10 газрын хязгаарлагдмал эрхийг барьцаалах гэж заалт орчихсон байгаа байхгүй юу.

9.8 дээр хязгаарлагдмал эрхийг барьцаалах тохиолдолд гээд ингээд заалтууд орчихсон, тэгээд би яах вэ, хэлэлцүүлгийн явцад ажлын хэсэг дээр асууя, миний асуултад та нар хариулаагүй. Зүгээр бичгээр хариулаад өгөөрэй. Энэ чинь яг иргэд, бидний чинь энэ дээр бүр а, б-гүй ... /минут дуусав/

Г.Занданишатар: 83. Магнайсүрэн дарга хариулъя.

С.Магнайсүрэн: Ганбаатар гишүүний асуултад би товч хариу хэлье. Газрын хязгаарлагдмал эрхийн гэрчилгээг бол барьцаалах, эдийн засгийн эргэлтэд оруулах энэ асуудал бол Газрын ерөнхий хуулиар нэлээн тодорхой болж, ингэж орж ирсэн. Өмчлөлийн газар, газрын хязгаарлагдмал эрхийг барьцаалах, шилжүүлэхтэй холбоотой асуудал, өмчлөлийн газрыг мөн зориулалтыг нь өөрчилж шилжүүлэхтэй холбоотой асуудал, зориулалтыг нь өөрчлөхгүй шилжүүлэхтэй холбоотой асуудал гээд ингээд тодорхой, энэ барьцаалбар байхаар өөрөөр хэлэх юм бол 18 онд баталсан улсын бүртгэлийн хууль, түүнийг дагаж гарсан тогтоол дээр энэ Иргэний хуулийн суурь зарчимтай нийцүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах энэ асуудлыг цэгцэлж орж

ирэх ийм үүрэг өгчихсөн. Энэ үүргийн дагуу энэ саяын таны тодруулдаг энэ асуудал тусаж зохицуулагдаж ингэж орж ирсэн байж байгаа. Тэгээд зарим ... /минут дуусав/

Г.Занданшатар: Сайнхүү Ганбаатар гишүүн 1 минут тодруулж асууя.

С.Ганбаатар: Саяын энэ барьцаалах асуудлууд дээр, бас би ажлын хэсгийн Байнгын хорооны бусад, өнөөдөр хэлэлцэх эсэх яригдаж байгаа учраас нэлээн дэлгэрүүлж асуух, тодруулах зүйлүүд байгаа. Тэгээд миний тодруулж хэлсэн түрүүний асуудлууд дээр тэр хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулалтын харилцаа, хамрах хүрээ гэдэг дээр 1 дүгээр бүлэг, 2 дугаар бүлэгт муж, тойрог, 3 дугаар бүлэгт сангийн тооллогыг явуулж гээд, бүр үүнийг заавал би ингэж деталины хуулийн нэр томьёо дээр ийм зөрчилтэй, хуулийн бичлэгийн тохирохгүй байгаа ийм олон зүйлүүд байгаа. Энэ дотор чинь л дараа нь энэ чигээрээ явчих юм бол хулгай нүүрлээд нөгөө Монголын ард иргэдийн чинь л одоо, та нар бод, тэр 20 хэдхэн хувь нь л өмчилхөөд байгаа бусад нь хүнд суртлаас болж байгаа шүү дээ. Энэ тогтолцоо нь өөрөө ард түмний эсрэг юм шиг ийм тогтолцоотой байгаа учраас ядраад байгаа байхгүй юу. Энэ жижигхэн ... /минут дуусав/

Г.Занданшатар: Магнайсүрэн дарга хариулъя.

Саяын Ганбаатар гишүүний асуултад Магнайсүрэн. Бид багц хуулийн төслөө хэлэлцэх эсэхийг нь шийдээд, ажлын хэсэг байгуулаад хэд хэдэн Байнгын хорооны хүрээнд танилцуулга, нарийвчилсан

мэдээллүүд өгөөд, ингээд гишүүд дээр ч гэсэн сая завсарлагаагаар ярьж байхад олон мэдээллүүд нарийвчилж өгөх шаардлагатай юм байна гэж үзсэн. Ингээд энэ тал дээр бид нар бүх талаар бас хамтарч ажиллая. Саяын саналуудыг хүлээж авч байна.

Г.Занданшатар: Санал хүлээж авч байгаа бол энэ чинь дэмжигдэхгүй боллоо гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа үг болно шүү дээ. Тэр нэр томьёо дээр кадастрын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлөө зохицуулаагүй, Зөвшөөрлийн хуулиар зохицуулна гэдэг үг, өгүүлбэр чинь байхгүй байна. Санхүүгийн кадастр, нөөцийн кадастр энэ тэрийг нэр томьёо дээрээ тодорхойлоогүй. Ерөөсөө л газар олгох эрхийг нэг булаацалдсан юм шиг хууль болоод байна гээд өчигдөр эртээдээс хойш шүүмжлээд байсан учраас хойшлуулсан шүү дээ. Тэгээд та нар нь ямар ч бэлтгэлгүй хуулиа. Газрын ерөнхий үнэлгээ чинь ерөөсөө суурь үнийг тодорхойлох аргачлал байж байгаа шүү дээ. Тэгээд газрын ерөнхий үнэлгээ, хувь хүн, кадастрын үйл ажиллагааны зөвшөөрөлтэй хувь хүн тогтооно гээд заачхаж байгаа болчхож байна шүү дээ, наадах чинь. Газрын үнэлэхийг, тэгээд хүн ямар хариуцлага хүлээж, ямар шаардлагатай хүн байх юм, ямар мэргэжилтэй хүн байх юм, зөвшөөрлийн хуулиар зохицуулна гэж ядаж байна, Зөвшөөрлийн хуульдаа тэгвэл дагалдаж өөрчлөлт оруулах хэрэгтэй шүү дээ.

Тэгэхээр энэ маш том зөрчилтэй асуудлууд гарч ирж байгаа юм.

Энхбаярын Батшугар гишүүн асуулт асууна.

Э.Батиугар: Баярлалаа. Ер нь кадастр ярихаар яалт ч үгүй газар ярьдаг, газар ярихаар хаягжилт ярьдаг. Тэгэхээр энэ хаягжилтын асуудлаа бид нар яаж шийдэж байгаа вэ? Ялангуяа гадаадын жуулчид ирэхээр, аль эсвэл ямар нэгэн байгууллагын хаяг нь ерөөсөө тодорхой бус байгаад байдаг, нэгдсэн хаягжилт байдаггүй, Монгол Улсад, байсан ч гэсэн тэд нар нь ил биш, тэгээд бид нар чинь заавал нэг дэлгүүр, их дэлгүүрийн хажууд, тэр хөшөөний хажууд ярьдаг. Энэ дээр яг ямар бодлого баримталж явж байгаа вэ гэж асуумаар байна.

2-т нь, газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар гэж байгаа. Энэ кадастрын хууль энэ дээр яаж авцалдаж байгаа вэ, хоорондоо зөрчил байна уу, үгүй юу. Эхлээд энэ газрыг ярих нь илүү зүйтэй л гэж бодож байна л даа.

3 дахь асуулт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж байгаа. Үүн дээр энэ мэдээлэл эзэмшигч мэдээллүүдээ ил тод гаргах ёстой гэж заасан. Тэгэхээр танай энэ хууль энэ дээр авцалдаж байгаа юу? Уялдсан байгаа юу? Жишээлбэл, 6.2.12-т, 8.6.12-т Тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашиглалтын төлбөр төлөлтийг ил байлгана, гаргана гээд ийм заачихсан байгаа. Тэгэхээр үүн дээр авцалдаж байгаа юу энэ хууль. Тэгээд энэ хууль ер нь хэрэгжиж байна уу гэж асуумаар байна. Баярлалаа.

Г.Занданшатар: 85,
Энхманлай.

А.Энхманлай: Батиугар гишүүний асуултад хариулъя. Хаягжилтын асуудал бол бас тун хүндрэлтэй явагдаж байгаа, яагаад гэвэл хаягжилтыг яг олгож байгаа субъектүүд маш олон, замбараагүй задгай, түр гээд л янз бүрийн байдлаар хаягжилтын асуудлыг шийдээд явж байсан. Тэгвэл сая өнгөрсөн 5 сард ЗГ-аас бид бүхэн хаягийн бас нэг шинэ системд шилжүүлсэн, өөрөөр Монгол Улсын хаяг бол олон улсын стандартын дагуу шинэчлэгдэж олгогдохоор ийм бэлэн болсон байгаа. Бид бүхэн бол улсын хэмжээнд хаягжуулалтын ажлыг бүгдийг нь зохион байгуулаад, хөдөө орон нутагт бол 100000-ны масштабтай зураг дээр өвөлжөө, хаваржаанаас авхуулаад бүх газар усыг бүгдийг нь хаягжуулсан.

Хот, суурины газар дээр 1:1000-ны масштабтай байр зүйн зураг дээр бүх хаягийг шинэчилж олгосон. Олон улсын гэдэг нь яаж нэрлээд байгаа юм гэхээр гудамж болон барилга, газар ямар системээр, ямар аргачлалын дагуу энэ хаягийг олгодог юм, хаягийг хэн олгох вэ, ямар шийдвэрээр олгох вэ гэдэг нь тодорхой болсон, цахим хаягийн системийг үүсгэсэн. Ингээд Цахим хөгжил, харилцаа холбооны яамтай бид бүхэн хамтраад бас ажлын хэсэг байгуулаад ингээд энэ шинэ хаягийн систем рүүгээ улсын хэмжээнд яг шилжүүлэх ийм ажлыг бол хамтраад хийгээд явж байна. Ингэхээр бол удахгүй бид бүхэн бол шинэ хаягийн систем шилжинэ.

Иргэдийн бичиг баримт дээрх хаяг бол цахим хэлбэрээр шилжинэ.

Хөдөө орон нутаг болон нийслэл хотод бол хаягжилтыг

тэмдэгжүүлэх ажлыг бас хийж хэрэгжүүлээд эхэлж байгаа. Энд бол тэмдэгжүүлэлтийн нэгдсэн стандартуудыг бас батлуулсан байгаа. Тэгэхээр хаягтай холбоотой асуудал бол нэг цэгцэрнэ, тэгээд энд хамгийн гол нь бизнесийн байгууллага, мөн төрийн үйлчилгээний байгууллагууд шинэ хаягийн системээр байршил тогтоох ийм бас системийг давхар хөгжүүлсэн байгаа. Ингэхээр бол түргэн тусламж, цагдаа, эмнэлэг гээд Онцгой байдал гэсэн байгууллагууд бол энэ системээр бол цаашид ямар нэгэн байдлаар зөв хаягаар, оновчтой хаягаар ингээд үйл ажиллагаагаа явуулах ийм нөхцөл, боломж бол бүрдэж байгаа.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу бид бүхэн бас энэ газрын кадастртай холбоотой газрын бүртгэл, мэдээлэлтэй холбоотой үйлчилгээнүүдийг бол бүгдийг нь нээлттэй болгосон. Энэ системээр дамжуулж иргэд бол өөрсдийн болон бусдын газар эзэмших, ашиглахтай холбоотой хуулиар хориглоогүй мэдээллүүдийг нээлттэй, ил тод мэдэж түүн дээр мэдээлэл авах бол ийм бүрэн бололцоог бол бүрдүүлж өгсөн байгаа.

Кадастрын бүртгэл болон үл хөдлөх хөрөнгийн бүртгэл 2 бол нэгдэж байгаа, өөрөөр хэлбэл бид бүхэн нэгдсэн дундын мэдээллийн сангаар дамжуулаад газар болон үл хөдлөх хөрөнгийг хоорондоо мэдээлэл дамжуулах зарчмаар харилцан нэг систем дээр бүртгэх ийм бас шийдвэрийг гаргаад энэ хуулиар бас үүнийгээ хооронд нь зохицуулж өгсөн байгаа. Тэгэхээр бол одоо Монгол Улсад газар болон үл хөдлөх хөрөнгө 2 хоорондоо нэгтгэгдэж бүртгэгдэнэ.

Цаашидаа бид нар энэ үл хөдлөх хөрөнгийг одоо барилгыг дээш нь, давхар давхраар нь доторх талбайгаар нь, бас энэ кадастрт бүртгэх ийм бас ажлыг хэрэгжүүлээд ТЭЗҮ-ийг нь боловсруулаад батлаад дууссан байгаа. Энэ ажлын хөрөнгийн асуудал шийдэгдчихвэл улсын хэмжээнд бүх үл хөдлөх хөрөнгүүдийг бол бүртгэж авна, газруудыг бүрэн бүртгэнэ. Ингэснээр бол татварын орлогын хэмжээ нэмэгдэх ийм бас бүрэн бололцоо бүрдэж байгаа.

Г.Занданшатар: Мөнхбаатар сайд аа, 81. Кадастр гэж ер нь яг юу гэсэн үг юм.

Б.Мөнхбаатар: Энэ маань зураглал, эрхийн бүртгэл байгаа. Тэгээд энэ газартай холбоотой эрхийн бүртгэл, зураглалыг холбогдох мэргэжлийн байгууллагууд нь хийх учиртай. Тэгээд энэ маань кадастрын нэгдсэн санд бүртгэгдэж явна, ер нь кадастрын сан маань сүүлийн хорь гаруй жил бүртгэгдээд шинэчлэгдээд яваад байсан. Энд энэ хуулийн шинэчлэл дээр гол асуудал нь давхардлыг л бид нар арилгаж өгөх гэж бол зорьсон байгаа. Яагаад гэвэл тодорхой, ашигт малтмалын ч гэсэн юмнууд нь суудаггүй, дүүргүүдийнх нь олголт хийчихсэн нь мэдээллийн сандаа суудаггүй, энэ бүх хариуцлагуудыг л цэгцэлж өгөх гэж энэ хуулийн төсөлд нэлээд тусгагдсан. Энэ дэс дарааллууд нь их тодорхой заагдаагүй байсан учраас хариуцлага, хийдэл гараад байдаг байсан. Тэгэхээр бид нар энэ хуулийн төсөлд бол гол нь кадастр энэ тогтолцоог дэс дарааллыг сайн гаргаж, хариуцлага алдсан этгээдүүдийг нь бас нэлээн хариуцлагажуулах чиглэлээр энэ

кадастрын хуульд бол тусгаж өгсөн байгаа юм.

Тэгээд энэ мэргэжлийн байгууллагууд бол хийдэг, тэгээд энэ дээр яах вэ тэр нотариат шиг тодорхой дүүргүүдэд тэд байна гээд заачихсан байдаг л даа. Тэрийг хүмүүс тойрог гэж яриад байх шиг байна. Тэгээд нэг хэт олон байвал болдоггүй учраас аймгуудад тэд, хүн амын тооноосоо хамаараад энэ тоогоо заагаад өгчихсөн байдаг энэ хүн амтай тоотой уялдуулаад. Түүнийгээ үргэлжлүүлээд явна л гэж бид бүхэн ойлгож байгаа.

Г.Занданшатар: Кадастр гэдэг үгийг нь Монгол хүн бүгд ойлгодоггүй, ер нь хууль ойлгомжтой, тодорхой байх ёстой шүү дээ, тийм ээ, Магнайсүрэн дарга аа. 83. Кадастр гэдэг үгийг Монгол хүн болгон ойлгодог уу.

Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яам. Кадастр гэдэг үгийг бол бид нар бол ер нь энэ газрын багц хуулийг орж ирэхэд олон тийм олон улсад хэрэглэгддэг нэр томъёонууд байсан. Тэгээд бид нар аль болохоор Монголчилж, хууль тогтоомжийн хуульд заасан шаардлагыг хангуулж яваад энэ кадастр, тэгээд сервитут узуфрукт гэсэн ийм гарцаагүй цөөхөн нэр томъёог Хууль зүйн яамтай яриад бол Монголчлоогүй үлдээсэн. Кадастр бол ерөнхийдөө л бүртгэл. Энэ ерөнхийдөө ерэн хэдэн онд анх кадастр, кадастрын зураглалын хууль батлагдаад л тэрнээс хойш ингээд тогтчихсон, практикт бол хэрэглээд тогтчихсон, бүртгэл гэдгээр нь бүртгэх үйл ажиллагааг ойлгодог, ийм ойлголтоор яваад өнөөдрийг хүрсэн. Тийм ч учраас энэ хууль

өнөөдөр ч хүчин төгөлдөр үйлчилж байгаа ийм нэртэй хууль байгаа, тэгээд үүгээр явж байгаа.

Г.Занданшатар: Тэгэхээр хуучин кадастрын тухай хуульд бол Кадастрын зураглал, Газрын кадастрын тухай хуульд бол кадастр гэдэг нэр томъёог тодорхойлсон байсан юм. Энэ ойлгомжгүй учраас.

С.Магнайсүрэн: Энд бол Газрын ерөнхий хуульд тодорхойлсон байгаа.

Г.Занданшатар: Кадастр бол тэр газар болон үл хөдлөх хөрөнгийн саяын асуугаад байгаа тэр хаяг, байриил, тоо эзлэхүүн, хэмжээ, тэгээд түүн дээрээсээ үндэслээд тэдгээрийн үнэлгээ, суурь үнэлгээ, эдийн засгийн үнэлгээ хийх, төлбөр ногдуулах үндэслэл, тэгээд эзэмшил ашиглалт, өмчлөлийн эрхийг баталгаажуулах ийм цогц үйл ажиллагаа шүү дээ. Энэ кадастрын тухай хууль дээрээ кадастраар ингээд оруулахаар газрын ерөнхий хууль дээр байгаа гэж хаячхаад газрын ерөнхий хууль дээр нь болохоор нь өөрчилчихсэн. Ингээд хүнд ойлгомжтой байх ёстой биз дээ, хууль. Хуулийг яагаад ингэж ойлгомжгүй болгож, тэгээд цаагуур нь ингээд хүн газрын үнэ, газрын эрхийг булаацалдсан юм шиг хууль болчихоод энэ гишүүд шүүмжлээд байгаа учраас наадах чинь энэ үндэслэл гарч ирж байгаа шүү дээ. Тэгээд энэ дээр ганцхан кадастрын зураглал гэж хуучин хууль дээр байсан юмыг Кадастрын зураг болгоод л тэгээд яг кадастрын тухай хууль болохоор кадастр гэдэг үгийнх нь нэр томъёо тодорхойлолт энэ тэрийг нь аваад хаячихаар чинь яаж хүмүүс ойлгож хэрэглэх юм бэ.

Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууна.

Г.Ганболд: *Бид нар газрын багц хууль хэлэлцээд л явж байгаа л даа. Тэгээд гол хуулиуд нь орж ирээгүй учраас үүнийг багц хууль гэж хэлэхэд хэцүү байгаа юм. Тусгай хамгаалалтын хууль орж ирээгүй, бэлчээрийн хууль орж ирээгүй, тийм учраас энэ хуулиуд нь орж ирэхдээ ингээд дутуу орж ирсэн, боловсруулалт муутай би дээр ч чуулганы хурал дээр хэлж байсан, би Байнгын хороон дээр ч хэлж байсан, саяын асуудлыг гадаад нэр томъёолол их ашигласан. Түүнийг нь бараг зарим мэргэжлийн хүмүүс нь ч ойлгодоггүй юм байна лээ шүү дээ. Тэгээд ирэхээр чинь энэ илүү ойлгомжгүй болоод эхэлнэ л дээ, тэгээд эхлээд ерөөсөө бид нар нэг ингэх юм. Хуулийн төсөл боловсруулах явцдаа ерөөсөө хэлэлцүүлэг, энэ мэргэжлийн байгууллагууд, ашиг сонирхол нь зөрчилдөж байгаа хөдөөгийн малчдын төлөөлөл, тэр тусгай хамгаалалт, иргэдийн хооронд явж байгаа зөрчлүүдийг гэдэг юм уу, аймаг суурин газруудын хүмүүсийн төлөөллийг оролцуулж байж хэлэлцүүлэг хийхгүй байж байгаад өөрсдөө нэг агентлагийнх нь нэг хэдэн хүний хүрээнд нухаж байгаад оруулж ирчхээд, тэгээд орж ирсэн хойно нь нэгэнт ороод ирсэн хойно нь бид нар чинь энд ажлын хэсэг гараад ч тэр Байнгын хороон дээр ингээд заавал нэг зарчмын зөрүүтэй санал гаргаж байж өөрчлөх болчихоод, эхнээсээ сайн шүүж орж ирээгүй юм чинь орж ирсэн хойноо их төвөгтэй байх юм. Тэгээд энэ дээр цаашидаа энэ оруулж ирж байгаа хуулиуд дээр нь оруулж ирэхээсээ өмнө нь өргөн хэмжээний хэлэлцүүлэг хийж байж нэлээн сайн нухаж байж оруулж ирдэг ийм хэлбэр*

лүү орж оруулж ирэхгүй бол энд ирээд төвөгтэй асуудал их үүсэх юм гэж би хэлэх гээд байгаа юм.

Тэгэхээр байршлын асуудалд энэ кадастр бол ер нь хил заагийн тухай л асуудал, одоо бол маргаан зөндөө байгаа. Хөдөө орон нутаг дээр маргаан байдаг, Улаанбаатар хотод бол бүр их маргаантай байдаг юм байна лээ. Тэгэхээр энэ цаашидаа ер нь энэ хуулиуд ороод ирэхээр яг Монгол Улс яг нэг нэг кадастрын яг нэгдсэн нэг сантай болж чадах уу? Бид нарын ингээд ажлын хэсэг яваад ажиллаж байгаагаар өнөөдөр ингээд зөвхөн Улаанбаатар хотод гэхэд Яармагийн дэнж дээр 3 өөр кадастр хилийн заагийн маргаан явж байна шүү дээ. Улаанбаатар хот болохоор зэрэг ерөөсөө ингээд л уулын ам руу нь билээд нь өгсөөгөөд авах гээд л манай хил зааг энд байгаа гээд нэг кадастртай.

Тусгай хамгаалалтын газар нь болохоор бараг Улаанбаатар хотын төв зам руу нь дөхүүлэх гээд л ингээд 2 кадастртай. Голоор нь энэ газрын харилцаа геодези, зураг зүйн газрынх нэг. Одоо Яармаг дээр гэхэд 3 өөр хилийн цэс байна шүү дээ, 3 хилийн цэс. Тэгээд энэ дунд нь ингээд олон хүмүүс газар давхиулж олгодог, нэгнийхээ эрх үүрэг рүү нөгөөдүүл нь орж олгодог гэдэг юм уу ийм зөндөө юм байгаа юм. Энэ яг яагаад ингээд яваад байдаг юм. Өнөөдөр яг Монгол Улсад ийм энэ зураглалын нэгдсэн сан кадастрын нэгдсэн санд гэдэг юм уу, хэдэн өөр төрлийн программ яваад байна. Цаашидаа энэ хууль бол батлагдсанаар яг нэг зураглалтай болж чадах уу? Эсвэл өөр өөрсдөө ингээд яам нь өөрийнхөөрөө гаргаад, нийслэл нь өөрийнхөөрөө, танайх ингээд өөрийнхөөрөө явж байгаа юм

уу. Энэ дээр нэг тодорхой хариулт өгмөөр байна.

Тэгээд гол юм би энэ хуулиуд гарахаас өмнө би энэ хуулийг бас нэлээн урт хугацаанд хэлэлцэгдээд явах байх гэж бодож байна. Олон хууль учраас. Тэгээд энэ хууль хэлэлцэгдээд явж байх хооронд энэ өмнөх зөрчлүүдээ арилгах тал дээр яг ямар ахиц дэвшил гараад явж байна. ЗГ-ын ажлын хэсэг хэр ажиллаж байгаа юм, энэ дээр ер нь танай яамны зүгээс энэ танайх дундуур нь ороод ингээд гуравдагч этгээд болж орох биш, нийслэл Улаанбаатар хот, энэ Байгаль орчин, аялал жуулчлалын яамныхны зөрчлийг уг нь арилгаж өгөх ёстой газар чинь та нар шүү дээ. Гэтэл дундуур нь хоёулангаас нь зөрөөд, ингээд голоор нь нэг чиг координат гаргаж хаячхаад ингээд яваад байдаг. Үүнээс чинь болоод ингээд зөрчил үүсээд байна.

Бид нар бол хаягжилт гэхээр зэрэг ингээд нэг гэр хорооллын хааша байшингийн дээр хаяг наах нэг дөрвөлжин ногоон хаягийн тухай л яриад байгаа байхгүй юу. Энэ чинь шал өөр ойлголт оо. Хөдөө орон нутгийн энэ хилийн цэсийн маргаанууд энэ сум орон нутаг, аймгуудын хоорондын ... /минут дуусав/

Г.Занданшатар: 85,
Энхманлай.

А.Энхманлай: Ганболд гишүүний асуултад хариулъя. Энэ кадастрын бүртгэл мэдээлэл цахим хэлбэрт шилжээгүй, мөн өмнө нь явж байсан бүртгэлийн ажиллагаанууд орон нутаг, байгууллагууд дээр тус тусдаа өөр өөрийн гэсэн ийм нэг тусгай системүүд дээр газрынхаа

бүртгэлүүдийг хөтөлдөг байсан. Тэгвэл энэ хуулиар өнөөдрийн бас бид нарын яг хэрэглэж байгаа кадастрын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд бий болгосон. Тэгээд энэ хууль болон Газрын ерөнхий хуулиараа бид бүхэн энэ газрынхаа бүртгэлийг нэг систем дээр улсын хэмжээнд хийнэ ээ гэсэн ийм зорилго тавьж, угаасаа энэ системээ хуульчилж байгаа гэсэн үг юм. Тэгэхээр энэ саяын ярьж байгаа, тусгай хамгаалалттай газар нутагт олгож байгаа аялал жуулчлалын зориулалттай газрууд, мөн уул уурхайн тусгай зөвшөөрөл, лицензүүд, тэгээд бусад энэ орон нутгууд дээр шийдэгдэж байгаа газар өмчлөх, энэ эзэмшиж байгаа зөвшөөрлүүдийг бүгдийг нь нэг систем дээр бүртгэх ийм эрх зүйн орчин болон системийн шийдэл нь ингээд батлагдаж байгаа юм.

Дээр нь бүр нэмэгдээд улсын бүртгэлийн, сая ярьсан үл хөдлөх хөрөнгүүд хүртэл ингэж газартайгаа уягдаж ингэж бүртгэгдэж байгаа юм. Тэгснээр улс бол өөрөө өөрийн гэсэн бүртгэлтэй болно гэсэн үг. Хэчнээн газартай юм, хэчнээн ямар ямар зориулалтаар ашигладаг юм, ямар хэмжээний үнэлгээтэй юм, тэндээс нь хэчнээн төгрөгийн орлого, татвар бид нар бүрдүүлэх боломжтой гэдэг чинь нэг мөсөн автоматаар системээр бодогдоод бүртгэлийн ийм системд орно. Одоо бол 1155000 газрын бүртгэл бүртгэгдсэн. Цаашидаа нэг 500 орчим газрын бүртгэлийг нэмж шийдэх шаардлагатай, эдгээр нь бол саяын ярьсан, зөрчилтэй ийм хэсэг дээр байрлаж байгаа газруудыг шалгаж байгаа юм. Сая бид нар бас хугацаа тавиад ингээд заасан чинь иргэд энэ бүртгэлийн системд бүртгүүлж

чадаагүй бол газар нь хүчингүй болчихно гэж ойлгоод нэлээн асуудал үүссэн, бас газрын албад дээр бас оочир дараалал үүссэн учраас хугацааг нь бол хойш нь сунгачихсан. Тэгээд энэ бүртгэлээ энэ шинэ систем рүүгээ оруулахдаа маш сайн шалгаж оруулж байгаа юм. Өөрөөр хэлбэл энд янз бүрийн зөвшөөрөлгүй юм уу, хууль бус бас шийдвэрүүдтэй газрууд орчих вий гэдэг дээр маш сэргийлж, хяналт тавьж ингэж оруулж байгаа.

Өмнөх зөрчлүүдийг арилгах тал дээр бас орон нутгууд, мөн бусад байгууллагууд руу бол бас бид нар энэ чиглэлээр үүрэг чиглэл өгөгдсөн. Түрүүний, бас УИХ-ын гишүүдтэй хийх уулзалтууд дээр бол энэ чиглэлээр бас асууж санал хэлж байсан. Тийм учраас бол бүгдэд нь бол албан бичгээр бол энэ ажлыг яаралтай зохион байгуул гэсэн чиглэл өгсөн.

Богд хан уулын хилийн цэсийн тухайд бол Байгаль орчны яам нэг хилийг мөрдөөд нэлээд олон жил ингээд явчихсан. Бас нийслэл хот болохоор өөрөө бас тусгай бас нэг юм хилтэй, манай энэ байгууллагын зүгээс бол ЗГ-аас бол хамтарсан ажлын хэсгийг байгуулаад шинжээч нар томилогдоод ингээд яг УИХ-аар батлагдсан, мөн Юнескод бүртгүүлсэн Богд хан уулын дархан цааст газрын хил бол яг энэ нь зөв өө гэдэг бол тэр дүгнэлтийг бол гаргаад өгчихсөн байгаа. Одоо гол нь энэ 2 орон нутаг болон яам маань зөв хилээ мөрдөх л хэрэгтэй. Энэ хил өөрчлөгдсөн, одоо энэ хоёрын буруу мөрдөж байсан хил нь өөрчлөгдсөнтэй холбоотой, дотор нь үүсэж байгаа, өөрөөр хэлбэл аль газрынх нь зөвшөөрөлтэй газруудаа хааш нь шилжүүлэх вэ, урьд нь авсан

төлбөр мөнгийг нь яаж тооцох вэ гэдгээ бол хоорондоо шийдэх ёстой. Түүнээс бол бид бүхэн УИХ батлагдсан хилийг бол өөрчлөх ямар ч эрх байхгүй, тийм учраас зөв хилээ л мөрдөж ажиллах бол энэ 2 эрх бүхий субъектэд бол оногдож байгаа.

Цаашидаа бол бид бүхэн газрын зөрчил, бас маргаантай асуудлыг хууль батлагдаад хэрэгжих хүртэл бол бас шийдээд ингээд дуусгахад бол бас анхаарал хандуулж ажиллах болно.

Г.Занданшатар: Гочоогийн Ганболд гишүүн тодруулж асууна.

Г.Ганболд: Харин тийм, ер нь энэ газрын асуудал чинь бол танай яамны асуудал шүү дээ, танайх эхнээсээ ингээд нэгдсэн программ оруулаад нийслэл Улаанбаатар хот өөрийнхөө кадастрын зураг руу оронгуут өөрийнх нь хилийн цэсээс гаднах, мэдээлэл нь орж ирдэггүй ийм түвшин рүү л оруулах ёстой байхгүй юу. Байгаль орчны яам өөрийнхөө ингээд тусгай хамгаалалтыг кадастрыг нээхэд тэр хилийн цэсээс гаднах нь ерөөсөө орж ирдэггүй, ийм юм руу л орчих юм бол хэн ч нэгэн рүүгээ ингэж давж газар олгож явах ямар ч боломжгүй болно шүү дээ. Тэгэхээр зэрэг уг нь би зүгээр ерөнхий хууль, ингээд багц хууль гэж байгаа юм чинь нөгөө тусгай хамгаалалтын хууль эд нарыг нь оруулж ирмээр байсан юм. Яагаад гэхээр Монгол Улс бол Үндсэн хуулиараа аймаг, нийслэл, сум, дүүрэгт л хуваагдана, засаг захиргааны нэгжийн хувьд. Гэтэл энэ нэгжүүдийн чинь өөрийнх нь эрхэн дундуур энэ тусгай хамгаалалт гээд дахиад нэгж шиг нөхдүүд орж ирээд ингээд газар олголт хийгээд үймүүлээд байгаа чинь энэ байхгүй

юу. Тэгэхээр зэрэг түрүүн Байгаль орчны сайд ч гэсэн өөрөө ер нь бодлого нь бараг манай яам цаашидаа байгалиа хамгаалдаг газар олгодоггүй ийм бодлого барьж байгаа гэж хэллээ л дээ. Үгүй ээ, үнэхээр ... /минут дуусав/

Г.Занданшатар: 85,
Энхманлай Геодези, зураг зүйн газрын дарга.

А.Энхманлай: Ганболд гишүүний асуултад нэмж тодруулъя. Саяын яг хэлж байгаа, таны хэлж байгаа кадастрын мэдээллийн сан дээр, өөрөөр хэлбэл орон нутаг болгон зөвхөн өөрийнхөө л газар дээр олгох тийм ээ, өөрийнхөө л хилийн цэс дотор газрын асуудлаа шийдэхээр ингээд бол зохицуулчихсан. Яагаад энэ цахим систем хийгээд бид нар бас цахимаар удирдан зохион байгуулна гээд байгаа нь үүгээрээ л илрээд байгаа юм. Өөрөөр хэлбэл бид бас тусгай маргаантай бүсүүд үүсэхэд шууд энэ дээрээс хааж байгаа, өөрөөр хэлбэл шинэ мэдээлэл оруулахыг хааж байна. Ийм удирдлага зохион байгуулалтаар хангах үүднээс цахим систем ажиллаж байгаа, өөрөөр хэлбэл хилийн цэсээс гадна зөвшөөрөгдсөн хилийн цэсээс гадна ямар ч газар зохион байгуулалтын газар олгох, бүртгэх үйл ажиллагаа бол явагдах ийм боломжгүй болсон. Тэгэхээр бол цаашид бид хүнийг цэгцэд орж байна гэсэн үг юм.

Г.Занданшатар: Тэгэхдээ ер нь энэ нэр томъёоны тодорхойлолтуудыг жигдлэхгүй хууль зүйн техникийн хувьд Магнайсүрэн сайн мэдэх ёстой хуульч хүн шүү дээ. Газрын тухай хуулийн 4.1.14-д заасан кадастр гэдэг тодорхойлолтыг авна гэж байгаа бол түүнийгээ эшлэх

хэрэгтэй силк хийж 4.1.14-өө. Геодези, зураг зүйн тухай хууль дээр чинь кадастрын зураг гэдэг нэр томъёоны тодорхойлолт тусдаа байгаа юм. Хэрвээ тийм нэг стандартаар явах гэж байгаа юм бол, энэ дээр ахиад нэг тодорхойлолт байгаа. Ингээд энэ кадастрын зураг кадастр гэдэг чинь өөр өөр хууль дээрээ нэр томъёог нь тодорхойлчихоод тэгээд энэ хуулийн чинь агуулга чинь яг тэр Кадастрын тухай хууль гэдэг чинь яаж гарч хүнд ойлгогдох юм гэдэг чинь.

Тэгэхээр энэ юмнууд чинь жигдэлж, хууль зүйн техникийн хувьдаа тэр хуулийн зорилт дээрээ ч гэсэн 4.1.14-өө эшилж байгаад, хэрвээ тэр бүртгэх үйл ажиллагаа эхэлж байгаа юм бол ерөнхий хууль дээрээ бүртгэх үйл ажиллагааг хэлнэ ээ л гээд тэгчихсэн байгаа ерөнхийд нь одоо. Нэгж талбайд суурилсан газар үл хөдлөх эд хөрөнгийн байришил, хэмжээ, хил зааг, эрх эрхийн хязгаарлалт, төлөв байдал, чанар чадавх үнэлгээ, татвар, төлбөрийн мэдээллийг бүртгэх үйл ажиллагаа гэж байгаа юм. Үүнийгээ нэлээн тийм цогц үйл ажиллагаа гэдэг энэ тэрийг нь яах вэ хуучнаасаа хасаад, кадастрын зураг, зураглалын тухай хууль дээр өөр дээр нь кадастр, хуучин хуульд бол кадастр гэдэг тодорхойлолт өөр дээр нь байсан хууль дээр. Яагаад гэвэл Кадастрын тухай хууль учраас кадастраа өөрийнхөө хуульд бас тодорхойлох ёстой. Ерөнхий хууль дээрээ тодорхойлсон бол тэрийгээ эшлэх ёстой Хууль зүйн техникийн хүрээнд, силк хийгээд 4.1.14. Тэгсэн мөртөө геодези, зураг зүйн хууль дээр кадастрын зураг гэдгээ томъёолчихсон мөртөө энэ дээрээ томъёолоогүй, хуучин кадастрын

зурган дээр чинь кадастрын зураглал гэдэг нь кадастрын хууль дээрээ, зураг гэдэг нь геодези зураг зүйн тухай хууль дээр байсан гээд. Тэгэхээр ийм сонин байдал бол.

Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Тэгэхээр энэ кадастрын хууль бол яах аргагүй багц хуулийн нэг нэлээн том амин сүнс нь л дээ. Бүртгэлийн асуудлыг тодорхойлоод байгаа зүйл байгаа юм. Тэгээд нэгж талбар түүний эргэлтийн цэгүүдийг газарт бэхлэх, кадастрын зураг хийлгэх харилцааг буйд нь зохицуулах гээд байгаа юм шиг байгаа юм, тэгж ойлгогдоод байгаа. Гэхдээ нэгж талбараа анх төлөвлөхдөө яаж төлөвлөх юм гэдэг асуудал байгаад байгаа юм. Газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд яаж төлөвлөлтөө хийх ёстой юм бэ гэж. Тэр төлөвлөлтийн дагуу тэр дуудлага худалдаагаараа байна уу, үнэ төлбөргүй байна уу, олголтын асуудал явагдана. Шийдвэр эрх бүхий этгээд гаргана, тэр гарсны ар дээр сая нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлэх, кадастрын зураг хийлгэх асуудлыг эрх бүхий байгууллагад хүсэлт тавих асуудал энэ хуулиар зохицуулж орж ирчхээд байгаа байхгүй юу.

Ер нь яг нарийндаа давхцал гэдэг юм чинь бол анх төлөвлөлт, тэр гаргаж байгаа шийдвэр 2 урьдчилж явагдаад байгаатай холбогдоод ард нь хийгдэж байгаа наад эргэлтийн цэгийг газарт бэхлэх, зураг хийх явц чинь ард нь хийгдэж байгаа учраас ийм нөхцөл байдлыг бий болгоод байна уу гэж би бол дотроо боддог юм. Тийм учраас үүнийг ер нь та нар

юу гэж ойлгоод үзээд байна вэ? Нэр томъёоныхоо тодорхойлолт дээр бол их тодорхой авсан юм билээ. Нэгж талбар гэж тодорхой байршил, хил зааг бүхий дахин давтагдашгүй дугаартай эрхийн кадастрын бүртгэл бүхий газрыг гэж, нэгж талбарын эргэлтийн цэг гэж нэгж талбарыг хязгаарласан хил заагийг газарт болон кадастрын зурагт тодорхойлсон цэгийг гэж хэлж байгаа юм. Тэгээд энэ 2 үйл явц нь түрүүлээд явчихсан энэ тодорхойлолтоос чинь харахаар зэрэг энэ үйл явц нь тэр газар олгох шийдвэр гаргахаас өмнө хийгдэх ёстой болж уншигдаад байна уу гэж би бодоод байгаа юм. Үүнийг ер нь юу гэж ойлгоод байна вэ гэж.

Газрын нэгдмэл сангийн тооллогыг бид нар 5 жилд хийх юм байна. Тооллогын дүнг үндэслээд газрын нэгдмэл сангийн өөрчлөлтийг хийх тухай орчихжээ, энэ хуульд. Гэтэл амьдрал дээр бид газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөндөө Хөдөө аж ахуйн газраас хот, суурины газар луу шилжүүлэлт хийгдэж байгаа, түүнийгээ урьдчилж хараад төлөвлөө гэж байгаа юм. Тэгээд тодорхой хугацааны ар дээр гэдэг юм уу, жилийн эцэс дээр тэр гүйцэтгэлээ бид хянаж батламжлах тухай асуудал яригдана. Тэгэхээр газрын асуудал эрхэлсэн байгууллага чинь тухайн жил жилдээ мэдээллийн сандаа өөрчлөлт оруулах тухай асуудал яригдана, тийм. Ингээд бодохоор зэрэг нэг бодохоор 5 жил болж байж нэг удаа өөрчлөлт орох юм шиг уншигдаад, яг газар зохион байгуулалтын харилцаатайгаа уялдуулаад харахаар зэрэг тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөө боловсруулахдаа бид ангилал хоорондынхоо өөрчлөлтийг

төлөвлөхөөр ерөнхий хуульд чинь байгаа шүү дээ, би тэгж л уншсан. Тэгээд түүнийхээ гүйцэтгэлийг батламжлахаар бид батламжилсан тоогоо яаж мэдээллийн сандаа өөрчлөлт оруулах юм, үүн дээр нэг тов тодорхой хариу авмаар байх юм, Нэг ийм 2 зүйлийг тодруулмаар байна.

Г.Занданшатар: 85,
Энхманлай газар зохион байгуулалт

А.Энхманлай: Батжаргал гишүүний асуултад хариулъя. Нэгж талбарыг яаж төлөвлөх вэ гэж байгаа. Ер нь бол бид бүхэн кадастрын зургийг мэдээж тухайн эрх үүсэж байж кадастрын зураг баталгаажиж бүртгэгдэнэ. Тэгвэл эрхийг яг яаж үүсэх вэ гэвэл газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслэж байж эрх олгох шийдвэр гаргах асуудал хэрэгжинэ. Тэгэхээр төлөвлөгөөг бид нар бол газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, өөрөөр хэлбэл тухайн жилд хэрэгжих аймаг, нийслэлийн газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн аймаг, нийслэлийн ерөнхий төлөвлөгөөг үндэслэнэ. Мөн хот байгуулалтын төлөвлөлтийн баримт бичгийг үндэслэж байж энэ тухайн жилд эзэмшүүлэх, өмчлүүлэх газрын байршил, хэмжээг нэгж талбар бүрээр нарийвчлан төлөвлөнө. Үүнийг бол газар зохион байгуулалтын төлөвлөлтийн систем дээр заавал хийгдэнэ. Ингээд төлөвлөлтийн систем дээр нэгж талбар бүрээрээ төлөвлөлтийн нэгж талбар гэж бүртгэгдэж байгаа. Одоо ч гэсэн энэ ажлууд бол хийгдээд явж байна.

Тэгэхээр энэ шинэ хууль бол яг энэ зарчмаар бол хийгдээд явна.

Ингээд Засаг даргаас байдаг юм уу, холбогдох эрх бүхий албан байгууллагаас тухайн төлөвлөгдсөн газар дээр газар эзэмшүүлэх, өмчлүүлэх шийдвэр гарахад үүний дараа бол Газрын кадастрын мэдээллийн сан дээр бол албан ёсоор баталгаажиж бүртгэгдэг юм. Энэ бүртгэгдсэний дараа бол газар дээр нь газрын мэргэжлийн байгууллагын албан тушаалтан очиж эргэлтийн цэгийг бол яг газарт нь бэхэлж, үүнийг бол хүлээлгэж өгөх ажлыг бол хариуцан зохион байгуулна.

Газрын нэгдмэл сангийн тооллого хийж гүйцэтгэх шат дамжлагыг бас хуульчилж өгсөн. Бусад байгууллагуудтай бас энэ ажлыг хийхдээ дундын мэдээллийн сангаар дамжуулж тухай бүрд нь өөрчлөлт оруулж явж байхаар ингэж хуульчилсан, өөрөөр хэлбэл Ойн сангийн газар, Усны сангийн газар мөн газар тариалангийн зориулалттай хөдөө аж ахуйн эдэлбэр газарт гэдэг юм уу энэ салбар салбарын газрууд дээр дундын мэдээллийн сангуудыг байгуулаад тухайн газар дээр орж байгаа өөрчлөлтүүд нь энэ газрын нэгдмэл сангийн цахим системд өөрчлөгдөж бүртгэгдэж байхаар ингэж хийсэн. 5 жил тутам бол бид бүхэн бол яг баталгаажуулах, тодруулах, өөрөөр энэ ажлыг бол бас улсын хэмжээнд хийж баталгаажуулах, ингэж явахаар энэ хуулийн төслийг тусгасан байгаа. Ингээд бол цахим орчин ийм систем ажиллуулж ашигласнаар бид бүхэн бол газрын нэгдмэл сангийн өөрчлөлтөө бол тэр дор нь бүртгээд, мэдээлээд ийм явах бол бололцоо бүрдсэн байгаад байгаа юм.

Г.Занданшатар: 82.

Батжаргал гишүүний асуултад нэмэлт тодруулга өгч хариулъя. Барилга хот байгуулалтын яамны газрын дарга Баярбат. Таны хэлсэн нөгөө иргэдтэй холбоотой энэ газрын нэгдмэл санд тухай бүрд нь өөрчлөлт оруулж явах асуудлыг тодруулж асууж байх шиг байна. Энэ бол энэ хууль Кадастрын тухай хуулийн 26.5 дээр, тухайлбал нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн тооллогыг, тухайн шатны Засаг даргын болон хязгаарлагдмал эрхтэй хүн, хуулийн этгээд гэрээгээр газар ашиглагчийн захиалгаар хугацаа харгалзахгүйгээр хийж болно оо гээд тусгачихсан байгаа.

Мөн 27 дугаар зүйл дээр Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санд өөрчлөлт оруулах гэдгийн 27.1 дээр саяын яг заасан ийм өөрчлөлтийг бол газар ашиглалтын зориулалтыг өөрчлөх асуудлыг бол эрх бүхий байгууллага, албан тушаалтан, шийдвэр гарсан нөхцөлд бол өөрчлөлт оруулж бүртгэнэ ээ гэдэг ийм хуулийн зохицуулалтыг нь тусгаж өгсөн.

Г.Занданшатар: *Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууна.*

Ж.Батжаргал: *Энэ хуулиар тэр засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хилийн цэсийн асуудлыг бол би хөндөхгүй юм байна гэж ойлголоо шүү дээ. Нэгж доторх хот, тосгоны хил хязгаарын асуудлыг бол энэ хуулиар зохицуулж болох юм байна. Түүнээс засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хилийн цэсийн асуудлыг бол энэ хуулиар зохицуулахгүй юм байна гэж ойлгосон мөн үү.*

Г.Занданшатар: *85 Энхманлай.*

А.Энхманлай: *Батжаргал гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ кадастрын хуулиар бол яг сая хэллээ, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэстэй холбоотой асуудлууд шийдэгдэхгүй. Харин түүний дотор байгаа тухайн хот суурины газрын эдэлбэр газрын асуудлуудыг зохицуулж явахаар ингэж заасан байгаа. Түүнийг бол тухайн иргэдийн хурал нь өөрөө шийддэг, энэ дээр бол бүртгэлийг нь хийгээд өөрчлөөд явах ийм бололцоотойгоор хуульчилсан байгаад байгаа юм.*

Г.Занданшатар: *2 гишүүний асуулт хариултын дараа дэмжсэн, дэмжээгүй 3 гишүүн үг хэлээд, санал хураалт явуулна. Гишүүд чуулганы танхимд цуглаарай.*

Ширнэнбаньдын Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: *Өнөөдөр энэ УИХ-аар газрын багц хуулиуд орж ирж байгаа. Үндсэн хуулийн өөрчлөлтийн дагуу олон хууль тогтоомжийг бид УИХ баталж гаргах ёстой, түүний нэг нь энэ газрын багц хуулиуд байгаа. ЗГ-аас өргөн мэдүүлсэн энэ газрын багц хууль өнөөдөр баталж гаргах нь энэ парламентын үүрэг мөн. Гэхдээ энэ Үндсэн хуулийн дараа орох энэ хуулийг ийм байдлаар хэлэлцмээргүй байна. Өнөөдөр энэ УИХ-ын танхим чинь 10 гишүүн байна, 76-аас 10 хүн хэлэлцээд ийм хуулийг ингэж шийдэх нь зөв үү. Энэ УИХ-ын дарга энэ хурал зохион байгуулагчид энд анхаармаар байна.*

Дээр нь энэ олон асуудлуудыг нэг Байнгын хороогоор хэлэлцэх нь ямар вэ. Өнөөдөр тэр орон нутгийн хилийн цэсийн асуудал, хот тосгоны

хилийн цэсийн асуудлыг энэ Хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хороогоор хэлэлцэж, ганцхан Байнгын хороогоор оруулж ирэхгүй ээ. Энэ ТББХ хэлэлцэх ёстой. Хамгийн их маргаан дагуулсан олон асуудал дагуулсан энэ асуудал бол энэ орон нутгийн хилийн цэсийн аймгуудын, сумуудын аймаг доторх багуудын хоорондын хилийн цэсийн асуудал байгаа шүү дээ. Үүнийг энэ ТББХ хэлэлцье.

Дээр нь энэ ашигт малтмалын кадастрын асуудал гэж олон хэл ам, хэрүүл маргаан дагуулсан, ашиг сонирхлын хамгийн зөрчилтэй энэ асуудал байгаа. Үүнийг тэр Эдийн засгийн байнгын хороогоор нь хэлэлцье л дээ. Тэгээд ингээд ийм том асуудлыг Монгол Улсын үндэсний эрх ашигтай, үндэсний аюулгүй байдалтай холбоотой, Монгол Улсын эдийн засгийн эргэлттэй холбоотой ийм асуудлыг нэг Байнгын хороогоор шийдэх нь учир дутагдалтай гэж би үзэж байна.

Ийм учраас би УИХ-ын даргад нэг горимын санал гаргая. Энэ Төрийн байгуулалтын хорооны харьяалагдах Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны харьяалагдах энэ асуудлыг тус тусынх нь Байнгын хороогоор хэлэлцье. Ийм горимын санал оруулж байна.

Надад энэ хуулийн төсөл санаачлагчаас асуух асуулт алга байна. Энэ асуудлыг шийдсэний дараа энэ асуудал дээр УИХ хариуцлагатай, анхааралтай шийдье л дээ. Бэлчээрийн асуудал гэж өнөөдөр хөдөө орон нутагт зөндөө асуудал байгаа шүү дээ. Үүнийг тэр жинхэнэ тэр хүнс, хөдөө аж ахуй, байгаль орчны байнгын хороо нь хэлэлцье.

Ингээж байж энэ асуудлыг олон талаас хэлэлцэж байж Монгол Улсын үндэсний эрх ашгийг хангасан, өнөөдөр нийгэмд шаардлагатай байгаа энэ нийгмийн харилцааг зохицуулсан энэ хуулийг баталж гаргах нь өнөөдөр энэ УИХ-ын шийдэх ёстой хамгийн хариуцлагатай ажлын нэг ээ. Энэ асуудалд ингээж хандмааргүй байна, дарга аа, энэ дээр миний энэ горимын саналаар санал хураалт явуулж өгөхийг би Их Хурлын даргаас хүсэж байна.

Г.Занданшатар: Асуулт асуусангүй, хуулиа уншаагүй, ойлгоогүй. Нөгөө Газрын тухай хуулийн түүний хэлэлцүүлэгт оролцоогүй учраас бас энэ юмнуудаа Байнгын хорооны хуралдаанд оролцоогүй байна, түүндээ сайн оролц.

Наянтайн Ганибал гишүүн асуулт асууна.

Н.Ганибал: Нэг хэд хэд асуулт байна. Ер нь яах вэ, Кадастрын тухай энэ хуулийн шинэчилсэн найруулга дээр бол энэ орон нутаг дээр хэд хэдэн асуудлууд байдаг.

1-д нь болохоор сумдад бол энэ кадастрын тусгай зөвшөөрөлтэй компани үйл ажиллагаа байдаггүй. Тэгээд аймгийн төв дээр нэг, зарим аймгуудад хэд хэдээрээ байдаг. Энэ боловсон хүчний нөөц бололцоо, энэ кадастрын тусгай зөвшөөрөлтэй компаниудын хүрэлцээ ер нь хэр нэмэгдэж байгаа вэ? Энэ дээр энэ хуульд гарч байгаа нөгөө хүндрэл нь болохоороо тухайн суманд кадастрын ямар нэгэн компани үйл ажиллагаа хийдэггүй учраас аймагт байгаа компаниудад Улаанбаатарт байгаа компаниудад захиалга өгдөг. Тэгээд

энэ захиалгын тодорхой цаг хугацаа нь бас хүлээлтэд орж ингэж явдаг л даа. Тэгээд энэ асуудал дээр ямар давуу талууд үүсэх боломж байна уу. Энэ нэг ийм асуудал байгаа юм.

Ер нь энэ Богд хаан уулын эргэн тойронд 1473 газар ингээд ашиглах гэрээ байгуулаад үл хөдлөх хөрөнгөө баригдчихсан гээд байдаг ч энэ кадастрын санд ингээд бүрдүүлэлгүй яваад байдаг. Энэ ер нь яаж шийдэх юм бол? Үүний шийдвэр энэ хуулийн шинэчлэл дотор байна уу? Улаанбаатар хотын эргэн тойронд бүр ашигт малтмалын 181 лиценз олгогдсон, тэгэхдээ ямар ч кадастргүй. Тэгэхээр үүний хариуцлагыг энэ кадастрын тухай хуульд кадастрт оруулаагүйгээр үйл ажиллагаа явуулснаар ямар хариуцлага үүрэх ёстой юм? Эсвэл энэ нөхөн олгох ёстой юм уу? Тэгээд бид нар чинь нэг ийм байгаа хуулиудаараа ингээд шийдэгдэж болоогүй, ингээд шийдэгдээгүй баахан асуудлууд байгаад байдаг, эд нарын шийдэл нь байх юм уу? Эсвэл хүчингүй болгоод тэр эрхийг нь цуцлаад л ингээд явах ёстой юу, нэг эсвэл кадастрт оруулах ёстой юу? Тэгээд энд бас нөгөө нутгийн бид нар чинь нэг 32 жилийн өмнө бүгд одоо 30 жилийн өмнө, Үндсэн хууль тийм ээ, газар эзэмших эрх ингээд явахаар, нэн ялангуяа зарим нэгэн Хан-Уул дүүрэг дээр энэ тэр байдаг л даа. Олон жил нутагласан гэдэг нэр томъёоллоор тэр газрыг эзэмшиж байсан хүмүүст тэр эрхийг нь олгоогүй үйлдлүүд бас байдаг. Тэгээд түүнээс болоод маргаан маш их удаан үргэлжилсэн, энэ асуудлыг энэ кадастрынхаа энэ асуудлуудтай яаж уяж ингэж явж байна вэ гэдэг асуултуудыг асууя.

Г.Занданшатар: 85, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Энхманлай, 85.

А.Энхманлай: Ганибал гишүүний асуултад хариулъя. Ер нь бол кадастрын зураг үйлдэх тусгай зөвшөөрөлтэй, өнөөдөр 253 ААН үйл ажиллагаагаа явуулж байгаа. Тэгээд энэ ААН-үүд бас ихэвчлэн дандаа Улаанбаатар хотод л үйл ажиллагаа явуулаад байгаа юм. Хөдөө орон нутагт кадастрын зураг хийлгэх, эрэлт хэрэгцээ бас хааяа байнга гардаггүй учраас энэ байгууллагууд энд төвлөрч, зөвхөн үйл ажиллагаа хийгдээд байна. Тийм учраас энэ шинэчилсэн кадастрын хуулиар, бас энэ нийт газар нутгаа бид нар муж, тойрогт хуваагаад тухайн муж, тойрогт нь байгаа нэгж талбар, хүн ам, нутаг дэвсгэрийнх нь хэмжээнд тохируулж энэ кадастрын зураг хийх ААН-үүдийн тусгай зөвшөөрлийг олгож, тэнд нь үйл ажиллагааг нь явуулъя гэсэн ийм бодлого барьж энэ хуулийн төслийг боловсруулсан. Ингэхээр бол бас тухайн муж, тойрогт эрх олгосон ААН маань өөр өөрийнхөө аймаг, сум дээр кадастрын зургийн үйл ажиллагааг бол ингээд хэрэгжүүлээд явах бол ийм боломж нөхцөл бүрдэж байгаа юм.

2 дахь асуудал болох энэ тусгай хамгаалалттай газар нутаг, мөн ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй ААН-үүдийн газрууд бол энэ газрын мэдээллийн санд бас бүртгэгдэхгүй байна гэсэн асуудал байна. Тэгэхээр энэ хуулиар бол бид бүхэн тусгай хамгаалалттай болон саяын ашигт малтмалын зориулалтаар газар олгож байгаа тохиолдолд заавал газар зохион байгуулалтын төлөвлөгөө дээр үндэслэж олгоно, улсын. Тэгээд

мэдээж энэ төлөвлөгөө дээр үндэс олгосон учраас энэ бүртгэл бол нэг ийм саяын газрын кадастрын бүртгэлийн нэгдсэн санд бол ингээж цаашидаа бол бүртгэгдэж явахаар хуульчилж ингээж боловсруулсан байгаа юм. Тэгэхээр бол бид бүхэн бол энэ саяын төрлүүд дээр газар олгогдсон асуудлыг иргэд бас нээлттэй мэдэх, мөн шинээр олгох гэж байгаа тохиолдолд бас төлөвлөгөөг нь саналаа өгч оролцох, хяналт тавих ийм бүрэн нөхцөл бүрдэж байгаа юм. Мэдээллийн ийм нэгдсэн бас энэ сан тогтолцоонд шилжсэнээр бид бүхэн бас татварын орлогыг үнэн зөв гүйцэд бүрдүүлж авах ийм бололцоотой болно. Газар ашиглаж байгаа, субъект бүхэн газрын төлбөр төлөх, үүргээ бас биелүүлэх ийм боломжтой болж байгаа юм. Одоо бол ашигт малтмалын чиглэлээр энэ манай газрын кадастрын мэдээллийн санд 1243 нэгж талбар бүртгэгдсэн байгаа, бүртгэгдээгүй бас нэгж талбаруудыг бид нар бол орон нутгуудтай хамтарч бас бүртгүүлэх ажлыг бас хамтарч зохион байгуулж байгаа. Ер нь бол маш их хэмжээний татвар төлбөрөөс бол энэ татвар төлбөр орж ирэхгүй байгаа энэ шалтгаан бол бас энэ газрын мэдээллийн санд ашигт малтмалын тусгай зөвшөөрөлтэй газрууд бүртгэгдэхгүй байгаа явдал юм. Хэрвээ энэ асуудал бүртгэгдчих юм бол орон нутгийн бас төсвийн орлого, татварын орлого нэмэгдэх ийм бас боломж суурь нөхцөлд бол бүрдүүлэх ийм боломж бүрдэх юм гэж байгаа юм.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүн байна уу, дэмжсэн, дэмжээгүй. Алга байна.

Жигжидийн Батжаргал гишүүнээр тасаллаа. Сайнхүүгийн Ганбаатар гишүүн үг хэлье.

С.Ганбаатар: Энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаа. Яагаад гэвэл энэ анх 1999 онд батлагдсан хууль, 9 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тэр үед чинь газрын тухай ойлголт Монголчууд бидэнд байхгүй байлаа, нөгөө ардын засаг ч гэж юу байлаа, авдаг өгдөг нь ч гэж юу байлаа гэдэг шиг бид ямар ч ойлголтгүй байсан. Одоо бол үндсэндээ 99 оноос хойш бараг гурван 10 жил бид энэ газраараа тоглолоо, наймаа нэг цэцэглэлээ, зарим улс төрчид нь бол энэ нүдээ бүлтэртэл баяжлаа, тэгээд энэ асуудлыг зогсоох, энэ асуудлыг цэгцлэхээс өөр арга байхгүй. Яагаад гэвэл энэ хууль тааруу хууль байна, энэ хуулийг бүр сайжруулъя гээд хойш нь татаад явах л юм бол одоо хорт хавдар шиг биднийг идэж байгаа энэ аймшигтай газрын кадастрын хуулиуд чинь ажилласан чигээрээ л амралтгүй ажиллаж байгаа шүү дээ тэр чинь.

Тэгэхээр энэ хуулийг бол хэлэлцэх эсэхийг нь дэмжээд, харин энэ дотор оруулах ёстой заалтуудаа, харин гишүүддээ би хандаж хэлье. Зүйл заалт бүрээр нь үг болгоноор нь уншихгүй бол энд чинь нөгөө та бидний бөөн юм болж сонгосон ард иргэдийн чинь л ёстой амьдрал тэр чигээрээ байгаа шүү дээ, үг үсэг болгон нь учиртай. Энэ дээр бол сайн уншаад, үүнийгээ бол дэмжээд хэлэлцэх эсэхийг нь дэмжээд явах ёстой гэж бодож байна.

Өнөөдөр алсын хараа дотор хүн амын нутагшилт, суурьшлын зохицол тогтолцоонд тулгуурлаж

хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно оо гээд заачихсан байгаа. 20-24 оны хөтөлбөрт энэ ЗГ-ын хөтөлбөрт хотуудын зэрэглэлийг тогтооно. Газар, үл хөдлөх хөрөнгийг нэгдсэн бүртгэл, үнэлгээ, төлбөр, татвар системд оруулна гээд заачихсан. Тэгэхээр үүнийг бол хэлэлцээд сайжруулаад явах ёстой гэдэг байр суурийг би дахин хэлж байна.

Ер нь бол бидний хамгийн том алдаа бол кадастрын хэмжилт, зураглалт, кадастрын бүртгэл гэдэг 2 юмыг хоёр өөр ертөнц, 2 өөр шинжлэх ухаан юм шиг авч яваад тэгээд улсаа сайхан газраар нь ер нь бол дампууруулж байна даа. Тэгээд энэ хуулийг хэлэлцээд тэртээ тэргүй аймшигтай муу юмыг нэг жоохон сайжруулна гэж би итгэж байгаа учраас хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байна.

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Тэгэхээр энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь дэмжье, ажлын хэсэг дээр нэлээн сайн ярилцах ёстой байх. Тэгэхдээ бид багцаар нь хуулиа оруулаад ирчихсэн учраас хууль хоорондын уялдаа хангах заалтуудаа их хармаар байгаа юм. Дан дамаа тэр 12.1 дээр тэр аймгийн газрын асуудал хариуцсан байгууллага шийдвэр гаргахаар байгаа. Гэхдээ тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг үндэслээд тэр 9-д дурдсан тэр нэг хүсэлт гээд нэг баахан дараалал байна шүү дээ. Түүнийг оруулаад ирсэн зүйл дээр нь тулгуурлаад шийдвэр гаргана гэдэг байдлаар бүтэн агуулгаар нь авмаар байна. Тэгж байж энэ асуудал өөрөө нэгдүгээрт зөв шийдэгдмээр байна.

2 дахь асуудал, Ганибал гишүүн их тодорхой асуулт асуусан. Бид 300 гаруй сумтай. Энэ сумд дээр чинь энэ газрын кадастрын чинь асуудал яаж явах юм бэ, тэр нэгж талбарын эргэлтийн цэгийг газарт бэхлэх, кадастрын зураг хийлгэх, тэгээд кадастрын мэдээллийн санд бүртгэх тухай асуудал яригдаж байгаа байхгүй юу. Тэгээд газар өмчлөх гэдэг юм уу тэр эзэмших, ашиглах шийдвэр нь гарчихдаг, нөгөө асуудлууд нь хийгдэхгүй, нэг хэсэг хугацаа авчих гээд байгаа байхгүй юу. Орон нутгуудад сумдад чинь яг мэргэжлийн эрх бүхий байгууллага байхгүй шүү дээ. Тэгэхээр тэр газар зохион байгуулагч нар буюу танай албад энэ улс орныхоо онцлогтой уялдуулаад сумын түвшиндээ ямар эрх эдэлж энэ юмаа хийх юм бэ гэдэг юмыг энэ хуулиар тодорхой болгож өгөхгүй бол нэг хэсэг тусгай зөвшөөрөлтэй хуулийн этгээдийг хараад энэ ажил чинь хаягдаад үлдэх гээд байна шүү. Үүнийгээ энэ хууль дотроо их тодорхой оруулж өгөх зайлшгүй шаардлага байна. Үүнийгээ нэг авч үзээч ээ гэж.

Дараагийн нэг асуудал, би зүгээр ер нь бол бодож байна, ажлын хэсэг дээр судлах ёстой байх. Энэ хууль батлагдаад гарчихсанаар өнөөдөр газрын албанд техник технологийн ямар хэрэгцээ үүсэх юм бэ гэдэг асуудал. Бид нар бүртгэл мэдээллийнхээ асуудлыг нарийсгах гээд байна, мэдээллийн сангаа сайжруулах гээд байна, үүнийг дагаад бид нарын өнөөдрийн ашиглаж байгаа наад өнөө солбицол тогтоогоод байгаа Жи пи-үүд чинь мөн үү, өөр юм байх юм уу, юу байлгах гээд байна, боловсон хүчнээ яаж бэлтгэх вэ энэ тэр гээд олон зүйлүүд уг нь тэр энэ

хуулийг дагаж гарах журмын хуулиараа зохицуулагдаж гарч ирвэл зүгээр сэн бэлтгэл зохион байгуулалтаа хангахтай холбоотой асуудлаа. Нэг ийм хэдэн зүйлийг цаашид анхаарвал хэдүүлээ зохилтой болов уу гэсэн ийм бодолтой байна.

Г.Занданшатар: Лхагвын Мөнхбаатар гишүүн.

Л.Мөнхбаатар: Газрын багц хуулийн төслүүд орж ирсэн, уншиж танилцлаа. Газрын асуудал бол яах вэ, бүх юмны суурь байгаа. Ийм учраас зөвхөн Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хороогоор хэлэлцэх нь хэлэлцээд, ингээд УИХ-ын чуулганы хуралдаанаар ингээд хэлэлцээд явахад бол бас учир дутагдалтай зүйл харагдаад байгаа юм. Энэ дээр ямар зүйлүүд орж ирж байна гэхээр Байгаль орчин, хөдөө аж ахуйн байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний асуудлууд байна. Дээр нь ТББХ-ны асуудал буюу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжид хил хоорондын цэсийн асуудлууд байж байна. Бүртгэлийн асуудлуудыг бас нэгтгэж байгаа газрын нэгдмэл бүртгэлтэй болохтой холбоотой бүртгэлийн асуудал буюу ХЗБХ-ны асуудал энэ дээр орж ирж байна. Эдийн засгийн агуулгаар нь бол Эдийн засгийн байнгын хороо бас энэ дээр хэлэлцэх шаардлага байгаа юм.

Ийм учраас энэ Газрын тухай багц хуулийг хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараа эдгээр Байнгын хороодоор бүгдээр нь хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн ийм ийм зарчмын саналтай байгаа юм, зарчмын саналтай байгаа.

Үүн дээр бас нэгтгээд ярихад нэр томъёоны хувьд, хууль зүйн нэр томъёоны хувьд ч гэсэн бид бас эргэж

харах зүйлүүд бас нэлээдгүй байна. Ингээд хуулийг уншаад үзэхээр бол нэр томъёог жигдлэх, ойлголтуудыг нэг мөр болгох, иргэний эрх зүйн хуулийн нэр томъёонд бас нийцүүлэх, шинэ нэр томъёонууд ч гэсэн энд бол нэлээн биччихсэн харагдаж байна шүү дээ. Нийгмийн зайлшгүй хэрэгцээ гээд тодорхойлчихсон, нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж гээд бид нар бол биччихсэн байгаад байгаа юм. Энэ яг юуг ойлгох вэ гэхээр инженерийн барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ гэдэг бол ойлгомжтой. Харин нийгмийн дэд бүтцийн барилга байгууламж гэж яг ямар хуульд байгаа юм бэ гэдэг ч юм уу. Энэ бол ямар нэгэн хуульд байгаа эсэхийг нь бол би санахгүй байна, хэрвээ байдаг бол тэр хуулийнх нь ойлголтыг нэгтгэж оруулж ирдэг ч юм уу. Энэ мэтчилэн хууль зүйн нэр томъёо хийгээд агуулгынх нь хувьд цэгцлэх шаардлагууд байна. Энэ агуулгаараа ХЗБХ, ЭЗБХ, ТББХ, БОХХААБХ-оор бүгдээрээ хэлэлцүүлэг явуулсны эцэст анхны хэлэлцүүлгийг нь хийх нь зүйтэй, нэгдсэн чуулганаа хийх нь зүйтэй гэсэн ийм зарчмын саналтай байгаагаа хэлье.

Энэ дээр бас нэмээд хэлэхэд энэ бэлчээрийн тухай хуулийн асуудал байгаа юм. Бэлчээрийн газрын ерөнхий хууль байгаад байгаа, ерөнхий хууль бол ер нь ингээд ерөнхийд нь зохицуулалт хийгээд нарийвчилдаг. Гэтэл энэ бусад 7 хуулиар ингээд нарийвчлан зохицуулж байгаа энэ зохицуулалтууд байгаа мөртөө бэлчээрийнх нь хуулийг газрын ерөнхий хуулиар зохицуулаад яваад байдаг, тэр журмаар зохицуулна гэж байгаа юм. Энэ нь цаашидаа бол нэлээн хүндрэл үүсгэнэ. Ийм учраас энэ бэлчээрийн хуулийг бол бие даасан

хууль болгон оруулж ирэх нь зүйтэй байна.

Нөгөөдөх нь энэ геодези, зураг зүйн хууль бас орж ирсэн санагдаж байна. Эдгээрийг бас нэгтгээд хамтад нь хэлэлцэх нь зүйтэй. Ингээд иж бүрнээр нь хэлэлцэж, энэ хийж байж та бүгдийн энэ газрын тухай хуулийн багц хуулиуд, том реформын шинэчлэлийн агуулгуудаа хадгалсан ийм хууль болж батлагдах байх гэж би бодож байгаа. Энэ зүйлийг хэлье.

Г.Занданшатар: Гишүүд дэмжсэн, дэмжээгүй үг гэж дууслаа.

Санал хураалт явуулах ёстой.

Ер нь 15 хуулийг хэлэлцэх эсэхийг хамт шийднэ. Кадастрын тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн 15 хуулийг. Гишүүд асуулт асууж, хариулт авч, үг хэлж дууссан.

Одоо МАН-ын бүлгийн дарга, УИХ-ын гишүүн Дуламдоржийн Тогтохсүрэн үг хэлнэ.

Д.Тогтохсүрэн: Кадастрын тухай хууль их чухал, хариуцлагатай ийм хууль байгаа. Тэгээд энэ хууль дээр МАН-ын бүлэг хуулийн дагуу 5 хоногийн завсарлага авч байна.

Г.Занданшатар: МАН-ын бүлгээс ирэх 7 хоног хүртэл завсарлага авах хүсэлт ирүүлсэн. Үүний дагуу ирэх 7 хоногийн 4 дэх өдрийн чуулган хүртэл завсарлага өглөө.

Энэ 7 хоногт үндсэндээ 34 гишүүн гадаад, дотоод ажилтай, орон нутагт томилолттой, өвчтэй, чөлөөтэй байна. Сүүлийн үед бас энэ. Тийм учраас энэ гадаад, дотоод томилолт ирц, санал хураалтыг бас

уялдуулах зохион байгуулах талаар Тамгын газар, намын бүлгүүд анхаарах хэрэгтэй байна шүү.

Энэ асуудлыг хойшлууллаа, завсарлага авсан учир хойшлууллаа.

15.42 цаг

Дараагийн асуудалд орёе.

Гурав.Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хууль санаачлагчийн илтгэлийг Монгол Улсын Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Мөнхбаатар: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль анх 2002 оны 6 дугаар сарын 27-ны өдөр батлагдаж, 2003 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөж эхэлсэн. Хууль хэрэгжиж эхэлснээс хойш хугацаанд Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуульд 7 удаа нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд үүний 3 нь гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэ төлбөргүй газар өмчлүүлэх хугацаа буюу хуулийн 19.1.2, 1.3, 1.4 дэх заалтуудыг дагаж мөрдөх хугацааг 5, хамгийн сүүлд 10 жилээр сунгасан болно.

Газар өмчлөлийн мэдээнээс харахад хууль хэрэгжиж эхэлсэн эхний 5 жилд улсын хэмжээнд нийт өрхийн 28,1 хувь нь гэр бүлийн хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилж авсан бол хууль хэрэгжиж

эхэлснээс хойш 2021 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт иргэдийн 19,8 хувь нь гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар газрыг үнэгүй өмчлөн авчээ.

Иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэгүй газар өмчлүүлэх ажлыг хугацаанд баригдалгүй оновчтой, нэгдсэн төлөвлөлт бүртгэлтэйгээр зохион байгуулж, улмаар өмчилсний дараа газрын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн зохицуулалт, насанд хүрээгүй иргэний өмчийн газрыг түүний хууль ёсны төлөөлөгч нь захиран зарцуулах, барьцаалах зэргээр өмчийн эрхэд халдаж байгааг хязгаарлах, мөн газрын улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн уялдааг сайжруулах асуудал эрхэлсэн байгууллагуудын хооронд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх, улсын газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөг ЗГ-аас баталсны дараа уг төлөвлөгөөг үндэслэн аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, мэргэжлийн төлөвлөгөөг түүнчлэн газар өмчлүүлэх шийдвэр гаргадаг байх, хот суурины хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, түүний бүсчлэлийн шаардлага, дүрэмд нийцүүлэн өгөх, өмчийн газар дээр жижиг үйлдвэрлэл, аж ахуй эрхлэх, зохицуулах шаардлагатай байгаа юм.

Хуулийн төсөлд нэр томъёоны тодорхойлолт, төрөөс газрын өмчлүүлэхийг баримтлах зарчим, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бүрэн эрх, газар өмчилж авах тухай өргөдөл гаргах, түүнийг хянах, газар өмчлөгч, иргэнд хориглох зүйл, иргэний газар өмчлөх эрхтэй холбогдсон бүртгэл,

хөдөлгөөний талаар тодорхой зохицуулалтуудыг тусгасан болно.

Хуулийн төсөл нь 7 бүлэг, 31 зүйлтэй. Үүнд:

1 дүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл буюу хуулийн зорилт, Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль тогтоомж, хуулийн нэр томъёо, тодорхойлолт, газар өмчлүүлэхэд баримтлах зарчим, Иргэнд газар өмчлүүлэх газрын хэмжээ, байрилыг тогтоох, газар өмчлөлийн талаар тусгасан болно.

2 дугаар бүлэгт газар өмчилж авах тухай хүсэлт гаргах, түүнийг хянах газар өмчлүүлэх тухай шийдвэр гаргах, иргэний газар өмчлөх эрхийг баталгаажуулах, иргэний газар өмчлөх эрхийн болон газар өмчлөх эрхтэй холбоотой өөрчлөлтийн бүртгэл, иргэнд газар өмчлүүлэх газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны талаар тусгасан болно.

3 дугаар бүлэгт газар өмчлөгч иргэний эрх, үүрэг, газар өмчлөгч иргэнд хориглох зүйл, иргэн өмчийн газраа бусдад ашиглуулах, иргэн өмчийн газраа нийтийн эдэлбэр улс орны нийтийн хэрэгцээнд түр ашиглуулах, иргэн өмчлөх эрхээ бусдад шилжүүлэх, газар өмчлөх эрхийн газрын бусад эрхээр иргэн, хуулийн этгээд шилжүүлэх, газар өмчлөхтэй харилцааны онцлог, зохицуулалтыг тусгасан болно.

4 дүгээр бүлэгт Иргэний газар өмчлөх эрх дуусгавар болох иргэн, өмчийн газрын улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор солих буюу эргүүлэн авах, газар өмчлөгч иргэний эрхийг хязгаарлах эрх,

иргэний өмчийн газрыг дайчлан ашиглах, иргэний газар өмчлөх эрхийг хүчингүй болгох зохицуулалтыг тусгасан болно.

5 дугаар бүлэгт иргэний газар өмчлөл өмчлөх зөрчигдсөн эрхийг сэргээх, газар өмчлөх эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулахыг хориглох, гомдол гаргах эрх, иргэний газар өмчлөх эрхийн баталгааны талаар зохицуулалтыг тусгасан болно.

6 дугаар бүлэгт иргэнд газар өмчлүүлэх болон хувийн өмчийн газрын харилцааг зохицуулах талаар төрийн байгууллага, нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийг тусгасан болно.

Эцэст нь хуулийн байгууллагад зөрчил хүлээлгэх хариуцлага, хууль хүчин төгөлдөр болох хугацаа, нэмэлт асуудал, харилцааны асуудлыг тусгасан болно.

Энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Г.Занданшатар: Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн, УИХ дахь АН-ын бүлгийн дэд дарга Наянтайн Ганибал танилцуулна.

Н.Ганибал: УИХ-ын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр Монгол УИХ хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022

оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын иргэнд гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар нэг удаа үнэ төлбөргүйгээр газар өмчлүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах, газрын нэгдсэн төлөвлөлт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийг бий болгосны дараа газрыг өмчлүүлэх, өмчлүүлсний дараа газрын эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг зохицуулахаар уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд тариалангийн болон аж ахуйн зориулалтаар газар өмчлүүлэхгүй, харин газрын нэгдмэл сангийн хот, тосгоны бусад суурины ангилалд хамаарах газарт өмчлүүлэх, уг шийдвэрийг Засаг дарга бус аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага өөрийн хамаарах нутаг дэвсгэрт газар олголтыг зохион байгуулснаар шат дамжлагаа багасаж, газрын улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн байгууллага хоорондын уялдаа холбоо хангагдаж, иргэдэд түргэн шуурхай үйлчлэх нөхцөл бүрдэнэ гэж хууль санаачлагч үзсэн бөгөөд хуулийн төслийг Ди парламент.мн цахим сайтад байршуулж иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 63,6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Үл хөдлөх хөрөнгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье. Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданишатар: Ажлын хэсгийн гишүүд өмнөх газрын ерөнхий хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн багц хуулиудын ажлын хэсэг нэр, овог, ажил, албан тушаал нэг адил байгаа учраас протоколд өмнөх ажлын хэсгийн нэрсээр оруулж байна. Ажлын хэсгийн гишүүд энд ирсэн байгаа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух УИХ-ын гишүүд байна уу.

Наянтайн Ганибал гишүүнээр тасаллаа. Хавдисламын Баделхан гишүүн асуулт асууя.

Х.Баделхан: Баярлалаа. Энэ газрын багц хуулиуд энэ өргөн бариад нэлээн удаж байгаа. Энэ газрын хуулиудад бол өөрчлөлт оруулах цаг нь болсон. Гишүүд бас олон төрлийн санал хэлж байна. Ер нь эхлээд бүх хуулиудыг хэлэлцэх эсэхийг нь шийдээд бас нэг том ажлын хэсэг байгуулаад нэлээн олон Байнгын хороогоор хэлэлцэж байгаад энэ

хуулийг бас нэлээн чанартай сайн хууль гаргах нь зүйтэй гэсэн нэг бол санал нэг байна. Энэ нэг ганц асуулт байна.

Тэр нь иргэдэд үнэ төлбөргүй газар өмчлүүлэх тухай хууль мөрдөгдөөд олон жил болж байгаа, хэд хэдэн удаа хугацааг нь хойшлуулсан, яг өнөөдрийн байдлаар хэр их хэмжээний иргэн газар авахаасаа хэр хэмжээний улсууд газар авсан юм бэ? Ер нь цаашидаа энэ яаж үргэлжлэх вэ. Энэ шинэ гарсан, хуулиараа юуг нь өөрчилж байгаа, ямар шинэчлэл хийгдэх вэ? Ер нь газар авч чадаагүй хүмүүс бол маш их байгаа л даа. Энэ талаар нэг асуулт байна. Баярлалаа.

Г.Занданишатар: хэн хариулах вэ. Бэгзжавын Мөнхбаатар сайд 81.

Б.Мөнхбаатар: Баделхан гишүүний асуултад хариулъя. Энэ хууль хэрэгжсэнээс хойш өнөөдрийн байдлаар Монгол Улсын иргэний 19,8 хувь нь бол иргэд газрыг бол үнэ төлбөргүй өмчилсөн байгаа. Тэгээд бас хуулийн хэрэгжилт бас хангалтгүй байна, иргэд бас газраа авч чадахгүй байна гээд асуудлууд байдаг. Ийм учраас иргэний өмчлөлийн газрыг бид нар энэ шинэчилсэн хуулиараа хэд хэдэн боломжуудыг илүү олгож өгч байгаа.

Өмчлөөд авчихсан газраа нөгөө иргэд, хотод, жишээ нь хотын төвийн байрлал байдаг, ердөө энэ хойд талынхаа ногоон нуур гэхэд өмчилсөн газар дээрээ байшин барилга барья гэхэд бол зайлшгүй өмчийнхөө эрхийг нь эзэмших болгож шилжүүлж байж хийдэг байдаг байсан. Энэ удаа энэ хууль батлагдсанаар иргэн, хуулийн

этгээдэд бусад зориулалтаар газрыг шилжүүлж эс үгүй бол өөрөө худалдаа үйлчилгээ нь бусад зориулалтаар ашиглах боломжууд нь бол нээгдэж өгч байгаа. Бид нар бас энэ хуулиараа тодорхой хугацаа тавиад хойшлуулаад байдаг байсан бол энэ хуулийн төсөлд бол өмчлүүлэх эрхийг бол хугацаагүй болгож өгч байгаа.

Мөн хамгийн гол нь зөвхөн дэд бүтэцтэй хот суурин газар, дэд бүтэцтэй газар газрыг өмчлүүлэх асуудлыг бид нар бол тавьж байгаа. Тэгэхгүй бол уулын орой мухарт хаа хамаагүй олгочхоод иргэн тэнд төвлөрөл үүсээгүй, тог байхгүй, худаг байхгүй, тээвэр гээд л олон асуудлын хүндрэлүүд байдаг. Тэгэхээр энэ удаа бол дэд бүтэцтэй газрыг бол төлөвлөж өгч байгаа.

Нөгөө талаар Монгол Улсын иргэн бүр гээд хүүхэд бас газар өмчлөөд авчихдаг, тэгээд холбогдох эцэг эх нь захиран зарцуулах эрхийг нь хэрэгжүүлээд байдаг бол 18 нас хүрээд хүссэн газар өөрөө сонгож газар өмчлөх боломжийг бид нар бол нээж өгсөн.

Бас нэг асуудал бол хугацааны асуудал байгаад байдаг байсан. Олон хоног байгаад тэр хоорондоо хүсэлтээ өгчхөөд тэгээд мартагдаад орхигдоод дарагдаад янз бүрийн асуудлаас байдаг байсан бол 30 хоногт багтааж цахимаар шийдвэрлэж өгнө. Энэ асуудлыг бол цахим биржээр шийднэ гэж бас энэ хуулийн төсөл бол шинэчилж бид нар бол оруулж өгсөн байгаа.

Г.Занданшатар: 82, нэмж хариулъя.

Ц.Баярбат: Баделхан гишүүний асуултад нэмж тодруулж хариулт өгье. Улсын хэмжээнд газар өмчлөлийн хувь бол 19,8 хувь энд 663116 иргэн газраа өмчилж авсан ийм мэдээтэй байгаа.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Баярлалаа. Бид нар зах зээлийн нийгэмд шилжээд бас юм болгоныг өмчилбөл сайхан гэсэн, Тоогий дарга аа, би ярьж байна. Зах зээлийн нийгэмд шилжээд бол юм болгоныг өмчилж авбал сайхан мэт ойлгосон. Үнэхээр газар өмчлөлийн хууль их буруу гэдэг нь энэ амьдралаар харагдсан. Монгол Улс нэг хүн амд ноогдох газрын хэмжээгээр дэлхийд номер нэг байдаг, их. Тэгээд эзэмшлээрээ уг нь ашиглаад 30 жилээр, 60 жилээр гээд ашиглаад байж болох л байсан байхгүй юу. Одоо өмчлөлийн хууль гэж гарсан, тэр нь явахгүй, 10 гаран жил боллоо шүү дээ, тэгээд дөнгөж 19 хувьтай байна шүү дээ, энэ чинь цаашаа явахгүй гэсэн үг байхгүй юу. Гэхдээ тэр өмчлөлийн хуульд орсон тэр зарим завхралуудыг засаж байгаа, хасаж оруулж ирэхээр нь харагдаж байна, саяын сайдын хэлдэг, тэр нь бол зөв.

Аймгийн төв, хот тойроод ингээд дугуйнуудыг газар булчихсан байгааг та бүхэн харж байгаа. Газар өмчлөлөөр авсан гээд нийтийн эрх ашгийн төлөө дэд бүтэц зам барих гэхэд миний өмчилсөн газар гээд тэгээд дээр нь юм барьчихсан, тэгээд хөдөлж өгөхгүй. Энэ нь бол эргээд хотыг цэгцтэй төлөвлөлтөд бол хүртэл энэ шууд нөлөөлчхөж байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ газар өмчлөлийн хуулийг бол ер нь явахгүй

юмыг нөгөө, явахгүй морийг ташиурдчихтай адилхан заавал бүр хугацаагүй сунгах юм ямар хэрэг байна. Эзэмилээрээ л аваад байхад ер нь болно гэж бодож байна. Тэгээд ер нь тэгээд эрх мэдэлтэй хүмүүс хотын төвд ойрхон ч юм уу, боломжит газрууд яадаг. Зүгээр жирийн иргэд болохоор тэр уулын оройгоор дэд бүтэцгүй газар өгнө гэдэг зүгээр нэр хэмнэсэн л асуудал байхгүй юу. Тэгэхээр харин дэд бүтэцтэй газар газрыг өмчлөх, эзэмших байдлаар оруулж ирж байгаа нь бас зөв зүйтэй. Гэхдээ би энэ нэг Баделхан сайдын үед сонгочихсон юм. Тэр хэдэн онд дуусах билээ дээ. Яг түүн дээр нь газар өмчлөлийг бол зогсоочихмоор санагдаж байна. Заавал өмчлүүлнэ гээд явахгүй юмыг ингээд заавал зүтгүүлээд байх шаардлага байхгүй гэж болов уу гэж бодож байна.

2-т нь, тэр газар өмчлөөд дээр нь ингээд нэг байшин барилга барьчихсан ингээд ерөнхий дэд бүтэц, зам тээвэр үгүй ээ, зам бүтээн байгуулалтын ажилд яг төлөвлөлтөө хийхэд саад болж байгаа газрыг ер нь зохицуулах заалт яаж орсон юм бэ? Эс үгүй бол тэр чигээрээ тээг болоод байж байх юм уу? Манай улс чинь яг хот төлөвлөлт энэ байдал бол үнэхээр алдагдаж энэ харамсмаар байна. Энэ тал дээр хариулаач.

Г.Занданшатар: Сандагийн Магнайсүрэн 83.

Болорчулуун гишүүний асуултад хариулъя, Барилга хот байгуулалтын яам Магнайсүрэн.

Газар өмчлөлийн хууль дээр 2 үндсэн зарчим бид нар концепт тохирч үүний дагуу боловсруулж орж ирсэн. 1 дүгээрт бол таны хэлсний

дагуу хугацаагүй болгосон, 2028 он хүртэл 10 жилээр сунгачихсан байсан. Тэгээд үүнийг бол ер нь энэ хугацаанд хугацаатай болохоор ингээд хугацаагаа тулаад ирэхээр нэг баахан бужигнадаг, мөн хугацаа заачихаар энэ юу яах вэ дуусах болоогүй учраас гээд бас хойшоо алгуурладаг ийм 2 талын бас ийм юу байдаг юм байна лээ, нөлөөлөл байдаг. Ингээд нэгэнт газар өмчлөлийн асуудал хэрэгжиж байгаа гэдэг утгаараа өмчлөлийг явуулъя, гэхдээ бид нар 18 насанд хүрсэн, Монгол Улсын иргэн насанд хүрсэн өдрөөсөө хойш энэ өмчлөлийн асуудлыг эдлэх эрхээ эдлэх ийм бололцоог тавьж өгсөн.

2 дугаарт нь болохоор зэрэг газар өмчлөл дээр аж ахуйн зориулалтаар газар өмчилдөг байсан. Тэгэхээр аж ахуйн зориулалтаар газар өмчлөх асуудлыг энэ хуулиар болиулж орж ирсэн байгаа. Өөрөөр хэлэх юм бол өнөөдрийн байдлаар маш цөөхөн 60 га газар, цөөхөн хүн юу тариалангийн зориулалтаар, бусад зориулалтаар 0,2 байсан байх аа, ийм га газрыг 3 билүү иргэн өмчилсөн ийм л дүн мэдээтэй байгаа юм. Тэгээд энэ 2 үндсэн концепцоор энэ хугацааны асуудлыг хугацаагүй болгож ингэж орж ирсэн байж байгаа.

2 дахь нь энэ өмчилсөн газар дээр төлөвлөлт хийхэд бас саад байсан уу гэвэл байсан, байдаг, энэ практикт их гардаг. Олонх газар өмчийн газраа чөлөөлөхгүйгээс болоод олон бүтээн байгуулалтын ажлууд саатдаг ийм тохиолдол байсан. Үүнийг даван туулахын тулд нэгдүгээрт бид нар төлөвлөлт ерөөсөө газар зохион байгуулалтынхаа төлөвлөлтөд суулгаж байж, тухайн жилийн улсын

газар зохион байгуулалтын жилийн төлөвлөгөөнд суулгаж байж энэ газраа тэр суулгасан газар л өмчилье гэж байгаа юм. Тэгэхээр энэ дотор бүх төлөвлөлтүүд суух учраас өмчлөх газар нь төлөвлөлттэйгөө уялдаж ингээж явах нэг ийм зарчмын асуудал суусан.

Хоёрдугаарт нь болохоор зэрэг бид нар энэ багц хуулийн төсөл дотор нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл бас давхар оруулж ирж байгаа. Энэ бол өмчлөлтэй холбоотой, мөн газрын эрхээ эзэмшиж, ашиглаж байгаа газруудыг бүтээн байгуулалтын ажил хийх ийм ийм тохиолдлуудад ийм ийм процессын дагуу газрыг чөлөөлнө гэдэг ийм хуулийн төслийг давхар, бас хамтад нь цогцоор нь оруулж ирж байгаа.

Ер нь энэ хуулийн төсөл батлагдсанаас хойш тийм, бүтээн байгуулалтад саад болох тийм тохиолдлууд бараг гарахгүй, маш бага гарна. Гарах тохиолдолд саяын ярьсан чөлөөлөх хууль үйлчилнэ. Анхнаасаа төлөвлөлтийн дагуу газар зохион байгуулалтынхаа төлөвлөгөөнд суулгаад баталж өгч байгаа учраас бид нар ерөнхий төлөвлөгөө болон хэсэгчилсэн тэр төлөвлөгөөнүүдэд саад болохооргүй гэхдээ өмчлөөд ашиглаж болох тэр дэд бүтэц, бусад зүйлийг нь дэд бүтэц бүхий газар, хот суурины эдэлбэр газар дотор өмчлүүлэхээр ингээж орсон. Өнөөдрийн хуулиар хот сууринаас гадна ч гэсэн зарим орон нутагт өгдөг ийм тохиолдлууд байсан. Энэ нь болохоор зэрэг эргээд асар их хүндрэлүүд бий болгож байгаа ийм зүйл байсан.

Г.Занданшатар: Хаянгаагийн Болорчулуун гишүүн тодруулж асууя.

Х.Болорчулуун: Цаашидаа бол дэд бүтэцтэй газар зөвхөн өмчлүүлнэ гээд тэр бол бодлогын хувьд бол зөв л дөө, одоо дэд бүтэцгүй газар ингээд тойруулаад хотын, аймгийн төвийг бүсэд нь оруулсан юм шиг газар өмчлөөд олгочихсон байгаа шүү дээ. Үүнийг бүтээн байгуулалт мэдээж энэ дээгүүр явж л таараа, нийтийн хэрэгцээний зам, дэд бүтэц явж л таараа, үүнийг яаж чөлөөлөх юм бэ л гэж асуусан шүү дээ. Тэгэхээр үүнийг хувийн өмч болчихсон, энэ жишиг үнэ гэж байх юм уу? Тэр хувийн өмч дээрээ байшин барилга барьчихсан байвал яах вэ? Үүнийг асууж байгаа юм.

2 дугаарт, 18 нас хүрсэн хүн өмчилнө гэдэг зөв өө. Настай болоод бие барвал нас барвал өмчилсөн газрыг яах, зохицуулалтыг хэрхэх зохицуулалтыг яаж тусгасан юм бэ? Тэрийг хариулаач.

Г.Занданшатар: Сандагийн Магнайсүрэн 83.

Болорчулуун гишүүний асуултад тодруулж хариулъя. Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн.

1 дүгээрт, энэ төлөвлөлт юу өмчилчихсөн газар дээр бүтээн байгуулалтын ажил буюу тодорхой төсөл арга хэмжээ, улс орон нутгийн төсөв болон гаднын зээл тусламжаар хийх тохиолдолд чөлөөлөх 2 ийм тохиолдол байна, 2 ийм арга зам.

1 дүгээрт нь, тухайн тэр хүний хувийн өмч болчихсон газрыг үнэлж,

төлбөрийг нь зохих төлбөр, өртгийг нь өгөөд чөлөөлж авах, нэг.

2 дугаарт нь, тэнд тэр газрыг өөр өөр зориулалтаар ашиглах тийм тохиолдол байх тохиолдолд тухайн нутаг дэвсгэрийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэсэгчилсэн төлөвлөгөөнд нь төлөвлөгөө болоод бүсчлэлийнх нь дүрэмд нийцүүлээд ашиглах тэр бололцоог нь бас нээж өгсөн байгаа. Чөлөөлж байгаа тохиолдолд нэг ... /минут дуусав/

С.Одонтуяа: Магнайсүрэн дарга гүйцээгээд хариулчих.

С.Магнайсүрэн: Чөлөөлж байгаа тохиолдолд энэ газрын үнэлгээний тойрог зэрэглэл, суурь үнэлгээ, газрын төлбөрийн хэмжээг тогтоох тухай ЗГ-ын тогтоол байдаг. 2018 оны 182 дугаар тогтоол байдаг. Энэ тогтоолоор бол бүх бүсийг бүсчлээд, жишээлбэл нийслэл дээр 16 зэрэглэлтэй, тэгээд хамгийн доод тал нь 18000000-ас авхуулаад 818000000 хүртэл ийм, ингээд төвийн болоод захын бүсийн ийм үнэлгээнүүд тусдаа. Энэ суурь үнийг бас харгалзаад, тэгээд зах зээлийн үнийг нь тогтоож байж тэгж байж яана.

Дээр нь нэмээд тэр газар дээр үл хөдлөх хөрөнгө байгаа юу, үгүй юу гээд энэ үнэлгээний системээр явж байж тухайн газрын үнэлгээ тогтоод, тэгээд ингээд харилцан тохиролцож нийгмийн зайлиггүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх хуулиар чөлөөлөх ийм зохицуулалтыг бол оруулж ирж байгаа юм.

Нас барсан тохиолдолд энэ бол өмч, тийм учраас Иргэний хуулийн зохицуулалтын дагуу өв залгамжлах

болоод бусад зохицуулалтууд үйлчлээд явчихна, хөрөнгөтэй адилхан.

С.Одонтуяа: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуулт асууна.

С.Ганбаатар: Миний асуултууд их тодорхой, бас тодорхой хариулт авбал зүгээр. Аймгийн төвийн, сумын төвийн, тосгоны, суурины хилийн цэс, хилийн зааг бүрэн тогтоогдож батлагдсан уу гээд би түрүүн урьд нь асуусан. Тэгээд би нэг их олигтой хариулт аваагүй л дээ, нэг болсон л гэсэн юм ярьсан. Энэ үзэл баримтлалын 4-ийн Е хуудас 3 дээр байгаа шүү. Үзэл баримтлалын хуудас 5. 3-т нь ингэж заасан байгаа, би нэгийг нь хэлчихье, 3 заалтын нэгийг нь хэлчихье.

Хууль батлагдсанаар хот, суурин газрын хяналтгүйгээр тэлэх асуудал буурна гэж биччихсэн байгаа байхгүй юу. Үгүй ээ, яагаад энэ хот суурин хяналтгүйгээр тэлэх асуудал ингээд арилахгүй байгаад байгаа юм бэ гэдгийг л би тодруулж асуух гэж түрүүний асуултууд байгаа юм. Энэ дээр хариулт өгөөч. Яагаад хот суурин хяналтгүйгээр тэлэх асуудал арилахгүй байгаа вэ. Нөгөө цэсийн асуудал энэ дээр хөндөгдөх үү л гэж би түрүүн уг нь асуусан юм байгаа юм. Эхний асуулт.

2 дугаар асуулт. 18 насанд хүрсэн иргэнд газар өмчлөхөөр хуулийн төсөлд тусгасан байна, гол онцлог нь орж ирж байгаа юм байна. Хэрэв энэ хууль батлагдвал хуучин хуулиар газар өмчилж авсан 18 насанд хүрээгүй иргэдийн газрын асуудлыг хэрхэн яаж зохицуулах бол. Би бол ний нуугүй хэлэхэд 18 нас хүрээгүй хүн газар өмчилдөг гэдгийг би энэ дээр анх удаа л эндээс уншиж

мэдэж авч байгаа юм. Ер нь хэдэн хүүхэд газар өмчилж авсан юм, хэдий хэмжээний газар авсан юм, тэр асуудал өмчилсөөр байх уу, буцааж авах юм уу гэдгийг надад тодорхой үүн дээр хэлж өгөөч.

3 дугаар асуулт. Цаашид иргэндээ газар өмчлүүлэх ажил үргэлжилсээр байх уу. Одоогийн хуулиар өмчилж болох хэчнээн хэмжээний газрын нөөц байгаа вэ? Энэ бол тооцоо заавал байх ёстой, тооцоо бодсон зүйлээ бидэнд нэг тодорхой хэлж өгөөч ээ. Ер нь бол газар өмчлөх энэ асуудал бол улс төрийн зорилгоор их явсан, та нар хүмүүс их идэвхгүй оролцсон л гээд л байн байн яриад байгаа. Хүмүүс идэвхтэй оролцож байгаа шүү дээ, газар өмчлөлийг авъя гээд очсон хүмүүсийн 85 хувь нь хүнд сурталтай, хаалга мөргөөд буцсан гэдэг тооцоо байгаа. 2-3 удаа очдог гэж байгаа шүү дээ. Энэ чинь иргэд газар өмчлөхдөө идэвх сул байна гэж та нар яриад байгаа чинь харин иргэд газар өмчлөх асуудлын эсрэг төрийн хууль нь өөрөө бараг иргэдийн эсрэг байна гэдэгтэй агаар нэг биш юм уу. 2003 оны 5 сарын 01-нээс эхэлсэн 2002 онд батлагдсан л даа, энэ хууль. 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. Тэгээд та нар ингээд сонирхоод харах юм бол дандаа сонгуулийн жил газрыг сунгах, газрын асуудал дээр нэмэлт сунгасан байгаа, сунгалтууд нь. Тэгэхээр миний асуусан зүйлүүдэд энэ ард иргэдэд газраа өмчилж авахад нь хялбаршуулсан тэр түрүүн хугацааны тухай ярьсан, хялбаршуулсан заалтуудаа бүгдийг нь нэг тодорхой надад бас хэлж өгөөч. Би 4 асуулт асуулаа.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Магнайсүрэн дарга хариулъя, 83.

Ганбаатар гишүүний асуултад хариулъя, Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн.

Би энэ газар өмчлөлийн идэвх, хүнд сурталтай холбоотой шуурхай болгохтой холбоотой заалт хуучин хуулиар өмчилсөн тохиолдол гэсэн ийм 2 дээр хариулт өгье. Үлдсэн 2 дээр нь манай Энхманлай дарга.

1 дүгээрт, энэ хуучин хуулиар бол Монгол Улсын иргэн гээд нас заагаагүй, бүгд өмчлөх ийм эрхтэй байсан. Энэ утгаараа насанд хүрээгүй иргэд газар өмчилсөн ийм бүртгэлүүд бий. Ялангуяа өмнөөс нь эцэг эх нь тухайн газрыг захиран зарцуулдаг ийм тохиолдлууд бол олон байсан. Энэ бол саяын ишидлийг гаргах нэг үндсэн шалтгаан нь болсон. Тэгээд өнөөдрийн байдлаар яг тоог манайхан нарийвчлаад гаргаад танд хэлье. 32000 гэсэн тоо байгаа юм байна, хүүхэд өмчилсөн байна гэсэн ийм тоо байгаа юм байна.

Бид нарын оруулж ирж байгаа хуулийн концепт өнөөдөр өмчилчихсөн байгаа хүүхдийн эрхтэй холбоотой асуудлыг бол хөндөөгүй. Шинэ хууль ингээд батлагдсан тохиолдолд 18 нас хүрснээс хойш өмчилнө. Энэ хүчин төгөлдөр болсноос хойш өмчилчихсөн байгаа хүүхдүүдийн асуудлыг бид нар бол хөндөөгүй орж ирсэн. Бид нар хэлэлцүүлгийн явцад шаардлагатай гэвэл шилжилтийн зохицуулалтыг бас хийж болох юм гээд. Яагаад гэвэл багц хууль өөрөө батлагдаад үйлчлэх, тэр дунд асар олон тийм шилжилтийн зохицуулалтууд шаардлагатай болно. Энэ хүрээнд бол авч үзье гэсэн ийм саналтай орж ирсэн.

Их Хурал дээр ажлын хэсэг дээр ярьж байж асуудал шийдэх нь зөв байх гэсэн ийм байдалтай юутай байгаа.

Газар өмчлөлтэй холбоотой асуудал, ер нь бол идэвхжил өмчлөх сонирхол сул гэдэг утгаараа бид нар бол хэлээгүй, зүгээр аж ахуйн зориулалтаар өмчлөхөд бол сул байна гэдэг дүгнэлт бол гарсан. Зүгээр иргэдийн хувьд бол ингээд тодорхой хугацаатай хийчихээр хугацаа дөхөхөөр яадаг бас хугацаа хараад тайвшираад одоо болоогүй юм байна гэдэг байдлаар ингэж асуудалд ханддаг гэсэн ийм хандлагууд их байдаг юм байна лээ. Харин таны хэлж байгаа тэр хүнд суртлыг даван туулахтай холбоотой зохицуулалтыг бид нар бол иж бүрнээр нь газрын ерөнхий хууль болоод хуулийн төсөл болоод энэ хуулийн төсөл цогцоор нь оруулж ирсэн.

1 дүгээрт, иргэд заавал биеэр явж хөөцөлдөх шаардлагагүй, цахимаар асуудалд хандаж болохоор аль ч газраас хаанаас ч цахимаар хандаж болохоор заасан.

2 дугаарт, бас цахимаар хандах бололцоогүй бол уламжлалт буюу цаасан материалаа бариад хандаж болохоор гээд тэгээд тэр ирүүлсэн материалыг манай дүүргийн болоод сумын газар зохион байгуулагч хуульд заасан шалгууруудыг хангаж байгаа эсэхийг хянаад аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад 15 хоногийн дотор шилжүүлээд, аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн байгууллага нь 15 хоногийн дотор зохих шалгууруудаа хянаад, тэгээд асуудлыг шийдээд буцаагаад цахим мэдээллийн сангаараа дамжуулаад

сум болон дүүрэг рүүгээ шилжүүлээд сум, дүүрэг дээрээсээ тухайн иргэн бол тэр эрхээ авчхаж болж байгаа ийм байдлаар бид нар нэг 30 хоногийн хязгаартайгаар л асуудлыг шийдэхээр ийм бололцоотой зохицуулалт оруулж ирсэн байгаа. Баярлалаа.

С.Одонтуяа: 85, Энхманлай нэмж хариулъя.

А.Энхманлай: Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Аймгийн төвийн, сумын газрын асуудал маш хүнд байдаг. Яагаад гэхээр аймгийн төвүүдийн сум маш бага хэмжээгээр, анхнаасаа Их Хурлаар хилийн хэмжээ батлагдсан. Гэтэл аймгийн төв дээр, хамгийн гол нь амьдарч байгаа газар эзэмших хүсэлтэй иргэдийн тоо хэмжээ байвал түүнээс хэд дахин их, тийм учраас сүүлийн үед бол аймгийн төвийн өөрийнх нь эдэлбэр газар, сумын төвийн заасан хил хязгаараас давж, түүний гадна байрлах сум руу орж газар эзэмших, газар өмчлөх ийм асуудлууд бол түгээмэл гарч байгаа. Тийм учраас үүнийг бол цаашид бид бүхэн бас хязгаарлах ийм зорилт тавьж байгаа. Яагаад гэвэл аймгийн төвийн эдэлбэр газрыг бол тодорхой заах хэрэгтэй. Үнэхээр өөр сумын нутаг руу газар өмчлөх эрэлт хэрэгцээ нэмэгдэж байгаа тохиолдолд тухайн сумтайгаа зөвшилцөөд, ингээд сумын төвийн хилийн цэст бас өөрчлөлт оруулах ийм шаардлагатай.

Газар өмчлөлийн тухай хууль дээр бол бид бүхэн зөвхөн хот, тосгоны эдэлбэр газар дээр зориулалттай газар дээр, энэ газар өмчлөлийн харилцааг явуулахаар газар өмчлөх ажлыг шийдэхээр ингэж зохицуулж өгсөн. Тэгж байж бид бүхэн энэ зөвхөн хот суурины эдэлбэр газарт нь л энэ харилцааг үйл

ажиллагааг явуулахгүй бол цаашид ингээд хөдөө аж ахуйн зориулалттай газар дээр бусад зам, шугам сүлжээ, бусад ангиллын газрууд дээр газар өмчлөх ажлыг ингээд орон нутгууд маань зохион байгуулж хэрэгжүүлээд байгаа. Тийм учраас энэ замбараагүй энэ төлөвлөлт, тэлэлт ийм юм бол газар авч байна. Тийм учраас энэ дээр бол заавал ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан, хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан, газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд туссан, мөн саяын ярьсан хот, суурины газрын дүрэм болон дэглэмд нийцсэн бүсчлэлд таарсан ийм зориулалтаар газрыг өмчлөх ажлыг зохион байгуулах шаардлагатай. Тэгж байж энэ хот суурины замбараагүй тэлэлтийг бид бүхэн хязгаарлаж зогсоох ийм бас боломж нөхцөл бүрдэх юм.

Тэр дараагийн асуулт болох дээр өмчилж байгаа, одоо ер нь нийтдээ бид бүхэн бас түүрүүн хэлсэн байгаа, бол нэг хүн амынхаа нэг 19,1 хувь дээр 68,1 мянган га газрыг бол өмчилсөн байгаад байгаа юм. Гэтэл бид бүхэн бол нийт нутаг дэвсгэрийн маань зүгээр 0,6 хувь нь хот, суурины ангиллын газар байгаа. Энд бол 956200 тийм ээ, мянган га газар энэ ангиллын хэсэгт хамаарч байгаа. Тийм учраас цаашид бол бас энэ бусад ангилал бусад зориулалтуудаар газрыг бас өмчлүүлэх, ер нь бол хуучин бол бас хуучин хууль дээр гэр бүлийн хэрэгцээ болон аж ахуйн зориулалтаар гэж хүртэл тусгасан байсан. Гэвч бол аж ахуйн зориулалтаар бид хүн бол газрыг төдийлөн сайн өмчлүүлээгүй. Харин иргэдэд гэр бүлийн хэрэгцээгээр өмчлүүлээд явж байгаа. Тийм учраас цаашидаа бол энэ хот, суурины ангиллын газар дээр газар өмчлүүлэх

ажлыг инженерийн шугам сүлжээ, дэд бүтцийг нь байгуулах замаар, бас нөөц бололцоонд тулгуурлаж иргэддээ өмчлүүлэх бол ийм боломжтой байгаа.

Газар өмчлөлийн ажил бол бас их урт хугацаанд шийдэгдэхээр ингээд хуульчилсан, хуульчилсан, хэрэгжээд явж байна. 90 хоногт бол газрыг өмчлүүлнэ ээ гээд заасан боловч одоо бол бид бүхэн энэ хугацааг богиносгож, 30 хоногийн дотор бол газар өмчлүүлэх ажлыг хийж зохион байгуулъя гэсэн ийм хуулийн төсөл оруулж ирсэн байгаа. Бүх ажлыг бол аль болох цахимаар хурдан шуурхай тэгш, ийм зарчмаар өмчлүүлэх ажлыг хийж хэрэгжүүлнэ ээ гэсэн ийм хуулийн төсөл оруулж ирсэн байгаа.

С.Одонтуяа: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулъя.

С.Ганбаатар: Миний тэр хамгийн сүүлийн асуултад би хариулт бол хангалтгүй л байна, тодруулъя л гэж бодож байна. Зүгээр хамаагүй ээ, газартай холбоотой юм бол нарийн бас нууцын зэрэглэлд байдаг бол тэрийгээ шууд хэлчээж болно. Цаашид иргэндээ газар өмчлүүлэх ажил үргэлжилсээр байх юм байна, байх уу гэж би асуусан, байна. Одоогийн хуулиар өмчилж болох хэчнээн хэмжээний газрын нөөц байгаа вэ л гэж би асуусан. Ер нь бол одоо өмчилчихсэн байгаа тэр би тэр хэмжээг бол бүгдийг нь ойлгож байна, яг боломжит нөөц нь хэд байгаа вэ? Түүний дэд бүтэцтэй ойрхон, ард иргэдэд яг нөөц гэр бүл иргэдэд өмчлүүлэхэд яг ашиглагдах тэр нөөцийг нь гэж хэлж байгаа шүү дээ. Ашиглагдахуйц.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? 85, Энхманлай Геодези, зураг зүйн газар.

А.Энхманлай: Ер нь бол угаасаа газар өмчлөлийн ажлыг бид бүхэн нарийвчилсан судалгаа шинжилгээ дээр тулгуурласан газар зохион байгуулалтын болон хот байгуулалтын төлөвлөгөөг үндэслэж бол шийдэх ёстой. Тэгээд энэ шийдвэр энэ ажлуудыг бол орон нутгийн иргэдийн хурал зохион байгуулаад шийдвэрээ гаргаад ингээд тухайн орон нутагтаа хэчнээн хэмжээний иргэдэд тухайн жилдээ газрыг өмчлүүлэх юм. Ер нь тухайн бүс нутгууд дээр хийгдэж байгаа ерөнхий төлөвлөгөөнд хот байгуулах, түүндээ зориулсан, иргэдэд газар үнэмшүүлэх хэмжээ, байриил, тоо хэмжээг бол тухайн орон нутаг өөрсдөө бол тогтоогоод явах бололцоотой. Газар нутгийн хэмжээг бол сая хэллээ, бид бүхэн бол нийт нутаг дэвсгэрийнхээ 1 хүрэхгүй хувийг л зөвхөн одоо, өнөөдөр бол хот суурины ангиллаар ашиглаж байгаа. Тэгэхээр бол цаашид бид хэдэн га газартай билээ, тийм ээ. 150 сая га нутаг дэвсгэртэй маш том, ийм газар нутагтай орон. Бид нар бол харьцангуй, 1 сая гаруй л иргэд маань 1155000 газар эзэмшигч өмчлөгч байгаа.

С.Одонтуяа: Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууя.

Н.Наранбаатар: Газар өмчлөлийн асуудал бол бидний, бас сүүлийн 30 жилд хийсэн хэдэн том реформын бол нэг яалт байхгүй газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хүмүүсийг өмчтэй болгох том зорилготой ийм хийсэн ажил байгаа юм. Гэхдээ хууль хэрэгжээд бас нэлээн хэдэн жил боллоо,

өнгөрсөн хугацаанд бас алдаа оноо олон зүйлүүд байх шиг байна. Тэгээд энэ шинэчилсэн хуулиар бас нэлээд олон зүйлүүдийг засаж залруулж байгаа байх гэж найдаж байгаа.

Аймгийн төвд, ялангуяа дэд бүтэцтэй газар аймгийн төвөөсөө гадагшаа байхгүй шүү дээ, одоо бол. Тэгээд энэ шинэ хуулиар дэд бүтэцтэй газар өмчлүүлнэ ээ гээд тэгж байна. Тэгэхээр аймгийн төвүүд бол байхгүй болчихсон, үүнийг яах вэ, дараагийн ирж байгаа, шинээр ирж байгаа өргөдлүүдийг яаж шийдвэрлэх вэ?

2 дугаарт, үнэндээ аймгийн төв ойрхон газар байхгүй, бүр хол 10, 10 хэдэн километр газар луу л өмчлөх хэмжээнд л оччихсон байгаа юм. Тэгээд өнөөдөр тэнд хориод километрийн цаана газар өмчлөөд авчихсан хүн тэр лүүгээ дэд бүтэц татуулах ийм зайлигүй шаардлага болно. Гэтэл олон жилийн өмнө ингээд аймагт ойрхон газар өмчлөөд авчихсан хүмүүс нь түүн дээрээ буудаггүй. Ингээд нэр дээрээ ингээд л авчихсан л олон жил ингээд л яваад байдаг, тэгэхээр үүнийг яаж зохицуулах юм. Одоо дэд бүтэц татахын тулд үр ашиггүй тийм, олон километр дэд бүтэц тэр цөөн тооны захад байгаа айлууд руу татаж, дэд бүтэц явуулах юм уу, аль эсвэл өмнө нь аваад ингээд буухгүй ингээд 10, 20 жил болчихсон айлуудын өмчлөх энэ эрхийг нь цуцлах юм уу, яах юм, энэ шинэ хуулийн энэ төсөл дээр эдгээрийг хэрхэн яаж зохицуулахаар оруулж ирсэн бэ гэсэн ийм асуулт байна.

С.Одонтуяа: Барилга, хот байгуулалтын сайд Мөнхбаатар хариулъя.

Б.Мөнхбаатар: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Яг үндсэндээ энэ дэд бүтэцтэй газар газар өмчлүүлнэ ээ гэдгийн цаана хот төлөвлөлтийн концепт явж байгаа юм. Бид нар зүгээр иргэн бүрд өгнө гээд л хүссэнээр нь өгөөд байсан. Одоо бид нар алдаа, оноогоо хараад мэдээж энэ бол сумын төвд хэчнээн дэд бүтэцтэй байгаа байлаа, сая Наранбаатар гишүүнийн хэлдгээр аймгийн төвүүд эхний ээлжид харлаа гэхэд аймгийн төвүүдэд тэр хол 20 километр авчихсан газрууд дэд бүтэц, гэр хороолол татна гэдэг чинь ч юу билээ. Тэгэхээр бидний хувьд бол аймгийн төвд ойрхон байгаа аймгийн төв дэд бүтэцэд холбогдох бололцоотой, ойрхон байгаа болон дэд бүтэц татагдсан гэр хорооллуудыг дахин төлөвлөлтийн асуудлыг хөндөж байгаа. Тухайн 3 айл байлаа гэхэд бол 3 айлын газар дээр нийлүүлээд 5 давхар орон сууцыг одоо бид нар, эрх нь гарч ирж байна шүү дээ, ойрхон болоод ирж байгаа учраас нөгөө нэг өмнө нь заавал эзэн хүн өмчилж байсан газраа эзэмшүүлж, өөрчлүүлдэг байсан бол 3-уулаа нэгдээд юм уу, эс үгүй бол өөрийнхөө газар дээр ч юм уу зориулалтаар орон сууц барих, энэ бүгдийн цаана хотыг төвлөрүүлэх, нягтруулах бодлого явж байгаа юм.

Тэгээд цаана нь дараа нь зарим жсоохон дунд хэмжээнд юм уу, гэр хороолол байгаа, эс үгүй бол шинэ газар дэд бүтэц тавьж байж шинээр өмчилж гарч ирнэ ээ гэдэг бол хаа хамаагүй замбараагүй гэр хорооллыг хүн бүгд авах ёстой гэсэн концепцыг хот төлөвлөлтийн концепт руу бол цаад агуулга руу бол оруулж ирж байгаа юм. Тэгэхээр ингээд ирэхээрээ дахиад аймгийн төвийн бидний хийдэг

ерөнхий төлөвлөгөө дахиж харах ёстой болж байгаа, бодитой болгож. Ингээд төлөвлөж болж байна уу, нөгөө инженерийн дэд бүтцийн эх үүсвэрүүд нь хүрч байна уу, шугам сүлжээ нь зардал нь хэд болох юм, яаж нягтруулах вэ, хаанаа заавал гэр хороолол байх ёстой юм уу, таун хаун шууд барих ёстой юу гээд энэ бүгдийн цаана нь газар өмчлөлийн цаана бид нар алдаж байсан хот байгуулалтын бодлогоо бас хуульд гаргаж ирж байгаа юм гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ бүгдийн цаана аймаг төв бүр дахиад төвийнхөө хөгжлийн төлөвлөлтүүдийг харж нягтаршуулж, зарим газарт нь шинээр дэд бүтэц тавилаа гэхэд айлууд гэр хороололд өмчлөөд ирэхээрээ тэр ашиглалтын зардлуудыг төлнө шүү дээ. Зүгээр хов хоосон, дэд бүтцийн мөнгө тавиад байхгүй. Ингээд ирэхээр бүгд цаанаа хотжих, соёл руу оруулах гээд олон асуудлын концепцыг хөндсөн энэ бодлогыг бид нар бол наанаа тавьж байгаа юм. Тэгээд цаанаа дэд бүтэц тавихын тулд зардал мөнгө гарна, ашиглалтын зардлууд гарна, эх үүсвэрүүд гарч ирнэ, шугам сүлжээнд зардал гарна гээд тэгээд энэ концепцын цаана энэ түрүүний хэлсэн, яагаад явж өгөхгүй байна гэдгийн цаана бид нар бас энэ асуудлыг тавих байдлаар аймгийн төвүүдийг нягтаршуулах, хот төлөвлөлтийн үед нь бас цэгцэлж өгнө өө гэсэн бол бодлого явж байгаа юм.

С.Одонтуяа: Жигжсидийн Батжаргал гишүүн асуулт асууя.

Ж.Батжаргал: Баярлалаа. Газар өмчлөлийн хуулийг нэлээдгүй харлаа. Бид бүхэн яах аргагүй энэ газар өмчлөлийн өмнөх хуулиар

хэрэгжиж байсан харилцаа бол улсын чанартай авто зам дагуу энэ тэр гээд ерөөсөө үндсэндээ хот суурин газрын төлөвлөлт хийгдээгүй газрууд дээр баахан өмчлөл өгсөн юм. Тэгээд энэ алдаагаа засаад бол яах аргагүй тэр газар зохион байгуулалтын төлөвлөгөө, хотын хөгжлийн төлөвлөгөө хийгээд хэсэгчилсэн төлөвлөгөөнд орсон газар байх тухай, тэгээд хүн ая тухтай амьдарч болох газар тийм орчин бүрдсэн байх тухай л орчхож л дээ. Тийм учраас яг дэд бүтэц гэж үг бол энэ дотор байхгүй байгаад байгаа юм. Тийм учраас харин хууль хэрэгжүүлэх явцдаа тэгэхээр хүн амьдрах ая тухтай орчин гэдгээ юу гэж ойлгоцгоох юм гэдэг асуудал байгаад байна. Үүнийг хэлэлцүүлгийн түвшинд нь яаж бас зохистой нэр томъёоллын хэлбэр рүү нь оруулах уу гэдэг зүйл байна гэж. Энэ дээр нэг тайлбар юм авъя.

2 дугаарт, хэмжээний асуудал ер нь ямархуу байх юм бэ?

3 дахь асуудал, өөрийн өмчлөлийн газраа бусдад ашиглуулж болох тухай дурдчихжээ. Ашиглалтын харилцаагаа зохицуулж байгаа заалтууд дотроо бас тийм их сүрхий юу алга, үнэхээрийн иргэдийн эрүүл мэнд гэдэг юм уу, тэр аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхээс бусад үйл явцыг бол ашиглалтын явцад бол зөвшөөрөөд байхаар, түүнтэй сөргөлдөж байгаа гэдэг юм уу, зөрчилдөж байгаа үйл явц байх юм бол зогсоохоор ингээд орчихсон байгаад байна л даа. Гэтэл бид яг нарийндаа энэ янз бүрийн хүндрэлтэй асуудал, хот суурин газруудад бий болж байгаа явдал бол анхнаасаа газрыг ямар зориулалтаар ашиглах вэ гэдгээс хамаараад, тэгээд түүний

багтаамж чадамжтай уялдаж үүсээд байдаг зүйл байхгүй юу.

Нэг хэсэг иргэд газар өмчлөлийн асуудлаар газар авчхаад, олон давхар орон сууцууд барьчих юм бол өнөө орон сууцны чинь иргэд машин тэргээ тавихаас авхуулаад үйлчилгээ юмнууд авахаас авхуулаад олон асуудлууд гарч ирнэ. Энэ харилцаагаа яаж зохицуулах юм бэ? Хэдүүлээ үүнийг бас нэлээн зөв талаас нь бодох ёстой байх гэж.

Тодорхой нөхцөл байдал үүсчихсэн тохиолдолд хүний өмчлөлийн газрыг дайчлан ашиглахаар Засаг дарга шийдвэр гаргахаар шийдвэр гаргасан этгээд хохирлыг нөхөн төлөхөөр энэ хуульд орж явчихжээ. Газар өмчлөлийн асуудлыг нь болохоор зэрэг газрын асуудал эрхэлсэн аймгийн төрийн байгууллага шийдвэрийг нь гаргаж байхаар, дайчлахыг нь сумын дарга гаргаад, тэгээд тэр амьтан төлбөр төлөхөөр ингэж энэ хуульд зааж орж ирсэн байна л даа. Тэгээд үүнийг ер нь юу гэж ойлгох юм, ямар юмны шийдвэрийг үндэслэж гамшиг элдэв бусын юм болсон гэж үзэж тэр хүн шийдвэр гаргах юм гэдэг харилцааг нэгдүгээрт тодотгомоор, хоёрдугаарт, тэр хохирол, нөхөн төлбөрийн асуудлыг буцаагаад олгохдоо шийдвэр гаргасан этгээд гэж хэлэх юм уу, эс үгүй бол тэр орон нутгийн төсөв гэдэг юм уу, ийм юмнаасаа гаргана гэж заах юм уу. Энэ чинь нэлээн эргэлзээтэй заалт болоод орчихсон байгаа ийм заалт байна шүү. Энэ дээрээ нэг тов тодорхой тайлбар өгөөч ээ? Нэг ийм хэдэн асуулт байна.

С.Одонтуяа: 83, Магнайсүрэн хариулна.

Батжаргал гишүүний асуултад хариулъя, Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн. Газар өмчлөх тухай хуульд хэмжээний тухайд газрын иргэний гэр бүлийн хэрэгцээнд өмчилж байгаа газрын хэмжээ нийслэлд 0,07, аймгийн төвд 0,35, сумын төв тосгонд 0,5 хүртэл гэсэн ийм 3 газрын ерөнхий хуульд заасан хэмжээгээр байгаа. Тэгээд тэр аймаг, суманд тэр дээд хязгаартаа багтаагаад газрынхаа хэмжээг иргэдийн хурал нь тогтоож бас болохоор, ингэж бол газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд суугаад ингэж зохицуулахаар бол тусгасан байж байгаа. Энэ бол өмнөх юунаас бол нэг их өөрчлөгдөөгүй, хуулийн ерөнхий концепт хадгалагдаж яваа.

Өмчийн газраа бусдад ашиглуулахтай холбоотой асуудлаар, ер нь өмчлөлийн газрыг эргэлтэд оруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах асуудал бол энэ хуулийг төслийг боловсруулах нэг үндсэн хөшүүрэг нь байсан. Тийм учраас бид нар хуучин бол өмчлөлийн газрыг ингээд бусдад шилжүүлэхэд заавал өмчлөлөөсөө татгалздаг, тэгээд татгалзсаныхаа дараа дахиж захирамж гаргаж эзэмшил болоод л тэгээд ингээд нэг их олон процесс дамжаад асар хүнд байсан. Тэгээд үүнийг бол бид нар өмчлөлийн газрыг өмчлөлөө хадгалж шилжүүлэх, ашиглах нэг ийм концепт байгаа. Мөн өмчлөл нь хүчингүй болоод дараагийн этгээдэд шилжээд явж байгаа ийм тохиолдол байгаа. Мөн өмчлөлийн газар дуудлага худалдаанд оруулаад өөрөө үнэ хүргүүлээд газрын биржээр дамжуулаад явах, тэгээд тэр олсон орлогоосоо татвар төлөөд явах ийм бололцоонуудыг нь бол энэ өмчлөлийн хууль газрын ерөнхий хуулийн концептын хүрээнд бол шийдэж өгсөн.

Ашиглуулах тохиолдолд мэдээж саяын ярьдаг, болгоомжлолууд бий. Гэхдээ газар өмчлөлийн хууль дээр өмчлөгч иргэн дараах үүргийг хүлээнэ гээд бид нар бол өмчлөгч иргэний үүрэг дээр арваад зүйл заалтаар ашиглуулахад яах вэ гэдэг, жишээлбэл, одоо сум, дүүргийн газрын албанд бол ашиглуулах тохиолдолд ашиглуулах, барьцаалах тохиолдолд заавал мэдэгдэнэ, бүртгүүлэхтэй холбоотой тэр зохицуулалтуудыг тодорхой хугацааг нь зааж ингэж процессыг хийж өгсөн байж байгаа.

Өмчлөлийн газрыг дайчлах, мөн нөхөх олговортойгоор улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор солих гэсэн ийм 2 зохицуулалтыг оруулж ирсэн. Дайчлан авах тохиолдолд мэдээж сум, дүүргийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгаагийнхаа хувьд Засаг дарга, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга шийдвэрлэнэ. Ингэхдээ ямар тохиолдолд шийдвэрлэх вэ гэдгийг бол хүний хүн амын эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан үрэгдэх, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд их хэмжээний хохирол учруулах гамшигт байдал энэ тэр гээд тодорхой, гепотиз нөхцөлүүдийг бол бид нар зааж өгсөн.

Тэгээд шийдвэр гаргасан этгээд гэдэг нь болохоор бид нар Засаг дарга, хувь этгээдээрээ биш Засаг дарга тухайн орон нутгийнхаа төсвийг захиран зарцуулж байгаа этгээдийн хувьд төвлөрүүлэн захирагчийн хувьд төсөвтөө суулгаж асуудлыг шийднэ ээ л гэсэн ийм агуулгаар орсон юм бас бүрхэг бас байж байж болох юм байна. Ингээд харсан. Бид нар

үүнийгээ бас тодотгож өгье өө гэж ингэж бодож байна.

Хот, суурины эдэлбэр газар дотор бид нар өмчлөлийн газрыг оруулна. Тэгээд хот суурины газар гэдэг нь ямар газар вэ гэдэг нь инженерийн дэд бүтэцтэй төлөвлөлттэй ийм газрыг хэлнэ ээ гээд хэлчихсэн. Тэгэхээр бид нар хот байгуулалтын хууль бол энэ нэгдүгээр хэлэлцүүлэг хийгдэх гээд хүлээгдэж байгаа, үүнтэйгээ уялдуулаад явчихна гэж ингэж тооцож байгаа юм. Ер нь хот, суурины газрын тэр төлөвлөлт бол нөгөө газар зохион байгуулалтынхаа төлөвлөлтөөр явах учраас бид нар өнөөдөр тавьчихсан газар өмчлүүлнэ гэж ярихаасаа илүүтэй төлөвлөлттэйгөө уялдуулж ингэж ... /минут дуусав/

С.Одонтуяа: Мөнхбаатар сайд нэмж хариулъя.

Б.Мөнхбаатар: Батжаргал гишүүний асуултад товчхон нэмэлт мэдээлэл өгье. Бид нар нэг иргэнд газар өмчлүүлэх тухай асуудлаа ярьж байна, өмчлөөд аваад ирэхээр гэр хороолол үүсэж байгаа л даа. Тэгэхээр бид нар яг Улаанбаатар хотод алдсан алдаа бол жишээ нь энэ хойд талын 32 Ногоон нуур, 13 дугаар хорооллын урд талд, 25 дугаар хороо, Сэлбэ гэж газруудыг бид нар нөгөө гэр хорооллыг хүмүүс нэг айлын газрыг аваад л нэг ямар ч зогсоол байхгүйгээр ингээд төлөвлөөд явчихсаныг, хэсэгчилсэн төлөвлөлтийг нь нийслэл юм уу, аймаг нь баталж өгөөд яг тэр төлөвлөлтийнх нь дагуу л хэрэгжүүлэхгүй бол дунд шатанд энэ нэг алдаа баталчихсан төлөвлөлтийг ямар нэгэн байдлаар ингээд гажуудуулж явсан алдаанууд

Улаанбаатарт гарсан. Тэгээд яваандаа ч гэсэн шинээр өмчлөөд авчихсан энэ гэр хорооллууд, одоогийн байгаа гэр хороолол, эс үгүй бол шинээр өмчилсөн газар дээр хэсэгчилсэн төлөвлөлтийг мөрдүүлэх нь бол хамгийн чухал юм байна лээ, хот байгуулалтад. Энэ ч гэсэн дараагийн шатанд аймаг Дархан, Эрдэнэтэд гарч ирэх учраас энэ тэрчилсэн төлөвлөлтийнх нь дагуу л 3 айлын газрыг авч нэг байшин барих ёстой юм уу, төлөвлөлтийн дагуу тийм байгаа гэдгийг л мөрдүүлэхгүй л бол бидний бас алдсан гашиун туршилага бол бас байгаа.

С.Одонтуяа: Жигжидийн Батжаргал гишүүн тодруулъя.

Ж.Батжаргал: Тийм, яг энэ яриад байгаа зүйлүүдээ хуулийн заалт дотроо үгээр яг бэхжүүлж оруулахгүй бол ойлголтоор явах боломжгүй. Тийм учраас өмчлөлийн газар чинь хаана хийгдэх вэ гэхээр зэрэг эзэмшил дээр байж байгаа иргэдийн хашааны газар дээр нэг эзэмшил өмчлөл рүү шилжих нэг үйл явц бий, нэг бол дэд бүтцийнхээ гаднах зоон дээр тодорхой байршилүүд дээр өмчлөлийн газрын асуудал л яригдана. Гэтэл тэнд нь газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд орчихсон, хот, хот хөгжлийн төлөвлөгөө хийгээд хэсэгчилсэн төлөвлөгөөнүүд хийгдчихсэн, дэд бүтэц нь хийгдээгүй байх юм. Тэгэхээр үүнийг хэдүүлээ үг найруулгынх нь хувьд их зөв авч хэрэглэх тухай асуудал байна гэж.

2 дугаарт, дайчлах тухай асуудлыг үнэхээрийн л тэр гамшиг осол элдэв бусын юмтай нь уяж дуугарч байгаа бол тухайн шатны онцгой комиссынхоо шийдвэр дээр үндэслэж засаг ... /минут дуусав/

С.Одонтуяа: 85, Энхманлай дарга хариулъя, дараа нь Магнайсүрэн төрийн нарийн.

А.Энхманлай: Батжаргал гишүүний асуултад тодруулж хариулъя. Иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн газар бол хот суурины ангиллын газар дээр явагдана. Энэ хуулийн төслийн 27.1.2 дээр яг тодорхой заагаад оруулчихсан байгаа. Энэ дээр юу гэсэн юм гэхээр тухайн орон нутгийн иргэдийн хурлын эрх, үүрэг байгаа. Энд бол иргэнд өмчлүүлэхээр төлөвлөсөн болон иргэнд өмчлүүлсэн газарт инженерийн болон нийгмийн дэд бүтэц бий болгох, иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ, түүний зардлыг орон нутгийн төсөв болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусган батлах гээд ингээд үүрэг болгоод заачихсан байгаа юм. Тэгэхээр бол манай орон нутаг бол иргэдийн хурал энэ өмчлүүлэх асуудалд бол заавал энэ инженерийн дэд бүтэц бий болгох, нийгмийн дэд бүтэц бий болгох ажлыг бол зохион байгуулах ийм үүрэгтэйгээр энэ газар өмчлөлийн тухай хууль дээр бол зааж өгсөн.

Иргэний газрыг дайчлах асуудал бол Засаг даргын хэмжээнд, өөрөөр хэлбэл сая хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал амьтан үрэгдэх, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулахгүй тохиолдолд гамшигт үзэгдэл болсон тохиолдолд тухайн иргэний газрыг өмчийн газрыг дайчлан авах шийдвэр гаргана. Энэ шийдвэр гаргасан тохиолдолд хэрвээ хохирол учирсан бол иргэнд хохирлыг бас нөхөн төлөх үүргийг хүлээнэ. Хэрвээ энэ хохирлыг төлөх

боломжгүй тохиолдолд өөр ижил тэнцүү газраар сольж олгоно. Ийм асуудлуудыг бол нарийн, зохицуулж өгсөн. Энэ нь бас Гамшигийн тухай хууль дээр ч гэсэн заасан, одоо мөрдөж байгаа бас газрын хууль дээр ч гэсэн энэ асуудал ингээд явагддаг, ийм одоо ер нь байж болзошгүй байж болдог, ийм харилцаа байгаад байгаа. Тийм учраас үүнийг бол шинэ энэ хууль дээр бас давхар ингэж тусгаж өгсөн байгаа.

С.Одонтуяа: Нэмээд Магнайсүрэн дарга, Барилга хот байгуулалтын яам болчихсон уу. Баярлалаа. Одоо Наянтайн Ганибал гэсэн асуултаа асууя.

Н.Ганибал: Газар өмчлөх ер нь тэгэхдээ өмчийн асуудал бол энэ нийгмийн хамгийн чухал асуудал л даа. Тэгээд газар өмчилнө өө гэдэг бол ардчилсан чөлөөт нийгэмд бол бас хүн өмчтэй болж, газар эдийн засгийн эргэлтэд орж, ер нь энэ нийгмийн хамгийн бас нэг зарчим байдаг. Эзэнтэй юм бол хамгаалалтад ордог, эзэнгүй юм бол нийтийн болон дундын эзэмшил бол дандаа шүүгдэж, устаж үгүй болдог. Тэгэхээр бол бид бүхэн газрыг өмчлөх асуудал дээр та бүхний оруулж ирсэн энэ концепцуудыг үзэж байна л даа. Энэ нэг ингээд сүүлийн үед орж ирж байгаа хууль болгон салбар болгоны хууль нэг ийм босоо удирдлагатай болох гэсэн ийм нэг тогтолцоо руу бүгд орж ирээд байгаа юм. Газрын асуудал ч тэр, боловсролын асуудал ч тэр, бүх салбарынх, энэ дээр ер нь манай гишүүд сайн бодохгүй бол болохгүй.

Өнөөдөр суманд ч юм уу, аймаг дээр энэ газрын асуудал хариуцсан байгууллагууд гэрчилгээ олгоно гэж байгаа юм, иргэдийн хурлын баталсан

төлөвлөгөөний дагуу. Та бүхэн бүр ингээд бүтэн ЗГ-аар оруулж ирээд Монгол Улсын нэгдсэн жилийн төлөвлөгөө гээд ийм юм оруулж ирж байгаа юм байна, энэ хууль дээр. Тэгээд тэрийгээ батлуулна гээд. 331 сум, 21 аймаг, 9 дүүрэг ингээд энэ болгоныг бүгдийг нь нийлүүлээд та бүхэн маань нэг ийм маш зузаан цаасыг ЗГ-аар оруулж ирээд, ЗГ-ын гишүүд тэр тоонуудаас нэгийг ч мэдэхгүй шүү дээ, зүгээр ийм харанхуй юм батлуулах гээд байгаа байхгүй юу. Тэгээд цаана нь олголтын асуудал болохоороо танай хариуцсан нэг мэргэжилтэн яах вэ, юуг нь гэрчилгээг нь бичиж өгөх л юм байна л даа. Ер нь зүгээр сумдын Засаг дарга нар, аймгийн Засаг дарга нар газар олголтын ажлыг хийж байгаа нь өнөөдөр яг энэ нийгмийн орон нутгийн өөрөө удирдах ёс, ингээд сонгуулийн тогтолцоо өөрөөр бусдыг хянадаг, алдаатай байвал сонгуулиар нөгөө хүмүүсээ өөрчилчихдөг гээд ийм улс төрийн болон төрийн захиргааны байгууллагын хяналт дор энэ үйл ажиллагаа явагдаад байгаа юм. Үүнийг та бүхэн маань татаад авчихаар эзэн биегүй болох гээд байгаа байхгүй юу. Та бүхэнд хэн хариуцлага хүлээлгэх юм, ер нь. Та нарын олгосон газрын зөв бурууг нь ер нь хэн шалгах юм, буцаагаад хариуцлага тооцох систем өөрөө байхгүй болчихож байгаа байхгүй юу.

Ер нь зүгээр аливаа юм ингээд төвлөрөөд ирэхээрээ асуудлыг ард иргэдийн хяналтаас холдуулах тусам нөгөө эрх мэдлийн албан тушаалын эрх мэдлээ ашиглах байдал, янз бүрийн бие биедээ давуу байдал олгох энэ асуудал л өөрөө газар авна. Тэгэхээр энэ дээрээ бид бүхэн бас харах ёстой юм уу даа л гэж бодоод байх юм. Мэдээж Үндсэн хуульдаа

захирагдаад газар олголт өмчлүүлэх энэ асуудлууд бүгдээрээ энэ хуулийн дагуу л явж л байна л даа. Тэгээд энэ нэг асуудал дээр та бүхэн ер нь бодол санаагаа дахиад нэг юугаараа давуу болоод байгаа юм ер нь, төвлөрүүлээд. Тэгээд энэ чинь ингээд яг Монгол Улсад бол энэ улс төрийн хувьд бол ингээд хүмүүсээ яг хуулиа хэрэгжүүлж ажиллуулдаггүй, Төрийн албаны тухай хууль өнөөдөр хүртэл хэрэгждэггүй, тэр мэрит зарчим нь өөрөө байхгүй, хэн дуртай нь хэн нэгнийг томилдог, аймгийн газрын албаны дарга нар, мэргэжлийн хяналтын дарга гээд босоо удирдлагатай бүх дарга нарыг магадгүй хэн нэгэн гишүүний хүмүүс очиж тэр ажлыг хийдэг. Энэ нөхцөл байдалд та бүхэн ингээд ингээд юмаа дэндүү гоёор хараад газар хөрсөн дээрээ очихоороо наад асуудал чинь уначих вий дээ гэсэн ийм болгоомжлол байна.

С.Одонтуяа: Барилга, хот байгуулалтын сайд Мөнхбаатар хариулъя.

Б.Мөнхбаатар: Ганибал гишүүний асуултад хариулъя. Та бас чухал асуудлыг хөндөж байна. Ер нь өнгөрсөн бүх хугацаанд газрын томилгоо хэвтээ байсан. Аймаг, нийслэл, дүүрэг, дарга нар бол газрын албан даргаа томилдог, яг л амьдрал дээр орон нутгийн сонгууль болоод л орон нутгийн сонгуулийн дараа Засаг даргатай ойрхон байсан субъектүүд л тавигдаад л явсан л даа. Тэгээд өнөөдрийн үүссэн нөхцөл байдлууд бас тийм л нөхцөл байдлууд үүссэн байгаа, тийм. Дүүрэг дээр ч бай, хаана ч бай тэгээд л хоорондоо ойлголцдог нь янз бүрийн байдлаар газруудыг төлөвлөлтийн дагуу бус ямар нэгэн байдлаар олгогдож явсаар

байгаад л өнөөдөр энэ хүндрэлүүд үүссэн.

Өнөөдрийн энэ нөгөө хуулийн төсөлд бол аймаг, нийслэлийн газрын албаны даргыг бол тухайн шатны Засаг дарга томилох нь байгаа, хэвтээ байгаа. Дараагийн шатны дарга нарыг дээрээс мэргэжиж байгаа мэргэжилтнүүдийг агентлагаас бид нар бас санал болгоё оо л гэж байгаа юм. Тэгэхдээ тэнд бол мэдээж тухайн шатны байгууллагаас нь ирсэн саналыг үндэслээд л бид нар томилгоонуудыг нь хийнэ, санал болгоно. Тэнд бол мэдээж суман дээр чинь хэр баргийн хүмүүс бол сүүлийн үед ч тогтохоо байлаа, бараг зарим Хэнтий аймагт гэхэд бол зарим сумд нь газар зохион байгуулагч байхгүй, зарим аймгууд дээр 2 сумын дундаж явж байгаа тохиолдлууд байгаа. Аль болох бид нар боловсон хүчнийг тогтвортой байлгах нь нэгд бол зорилго гэж үзсэн. Хоёрдугаарт, бас аль нэг юмны хөндлөнгийн нөлөөнд авталт байхгүйгээр газар зохион байгуулалтынх нь төлөвлөгөөний дагуу зарчмын дагуу ажиллахад нь дарамтаас үл хамааран ажлынх нь баталгааг нь хамгаалж өгье өө л гэсэн зарчмыг бол тавьсан байгаа юм.

С.Одонтуяа: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууя.

О.Цогтгэрэл: Газрын багц хууль явж байна. Үүн дээр үзэл баримтлалын түвшинд ярилцаж байгаа болохоор хэлэлцэх эсэх явж байгаа болохоор нь тэр түвшинд нэг асуулт байгаад байна л даа. Ер нь газар гэдэг ойлголт өөрөө бид нарын уламжлалт ойлголтоос, бас ингээд тодорхой түвшинд өөрчлөгдөж байгаа. Газрын ач холбогдол газартай л бол баян, газрын төлөө байлдан дагуулалт явдаг, газрын төлөө бүх юм

явдаг бол одоо газар гэдэг зүйлийн ач холбогдол бас өөрчлөгдөөд, заримдаа газаргүй ч баялаг бүтээгддэг, газар дээр биш энэ олон талын зүйл явж байгаа. Тэгэхээр үүний цаад утга санаа технологитой холбоотой байх, тэгэхээр үзэл баримтлалын түвшинд гээд байгаа нэг 2 зүйл асуух гээд байгаа нь ер нь бусад улс орнуудад энэ газрын харилцаа, энэ олон зүйл өмнөхөөсөө юугаар өөр болж байгаа юм. Тэр газрын мэдээллийн сан гэж байна. Энэ хуучны тэр нөгөө 2 ди мэдээллийн сангаас кадастр хийж байгаа тэр эргэлтийн цэгүүдтэй тэр мэдээллийн сангаас юм өөрчлөгдөх юм уу? Энэ технологийн дэвшил өөрчлөлт нь юу авчирч байгаа юм? Орон зайн түвшинд яг юу авчирч байгаа юм? Одоо энэ хуулиудад яг ер нь урьд өмнө нь тулгамдсан бэрхшээл, газрын маргаан, кадастр, төлбөр гээд энэ асуудлуудаасаа гадна яг энэ технологийн дэвшил өөрчлөлт бид нарт энэ хуулиудаар болоод ирэх жилүүдэд магадгүй 5, 10 жил, 20 жил, 30 жилийн алсыг харсан юу өөрчлөгдөж, ямар зүйл ийшээгээ орж байгаа юм.

2 дугаарт нь, бас дахиад газартай холбоотой ярихад виртуал ертөнц, тэнд газар, тэнд эд зүйлс, энэ эв ти гээд олон зүйлийг ярьдаг болчихсон. Энэ ирж байгаа энэ технологийн өөрчлөлтүүдэд энэ хуулиудад ямарваа нэгэн тийм угтаж хийж байгаа зүйлс байгаа юу?

Дахиад дээрээс нь эдгээр харилцаа нь бусад улс орнуудад энэ харилцаанууд дээр яаж явж байгаа юм, өөр болж байгаа юм байгаа юу гэдэг зүйлийг л тодруулах гэсэн юм.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ. Энхманлай Геодези, зураг зүйн газрын дарга.

А.Энхманлай: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Ер нь Монгол Улсын газрын харилцаа, бид бүхэн бол харин 2002 оноос эхлэн одоогийн мөрдөж байгаа хууль батлагдсантай холбоотой, газрын шинэтгэл бол хийгдсэн. Ямар ч байсан тухайн үедээ бол үүргээ гүйцэтгэсэн гэж үзэж байгаа. Өөрөөр хэлбэл бид бүхэн бас олон улсын байгууллагуудын мөн, хөгжингүй орнуудын дэмжлэгтэйгээр газрынхаа бүртгэлийг цахимжуулах, кадастрын зурагжуулах, бүртгэх ажлуудыг бол 2002 оноос хойш бол хийгээд, одоо бол ингээд тухайн бүртгэл мэдээллийн сангууд бол үүсээд, өнөөдөр бид бүхэн үйл ажиллагаандаа ашиглаад явж байна. Тэр ч утгаараа төрийн байгууллагуудыг цахимжуулж байгаа энэ ажлын хүрээнд бол газрын харилцааны салбар бол харьцангуй, сайн цахимжих үйл ажиллагааг бол нэлээн сайн, ашиглаж хийсэн. Энэ хүрээнд одоо бол ингээд газрыг бол цахимаар шийдвэрлэх, цахимаар өргөдөл хүлээж авах ингээд гэрчилгээ, гэрээ, кадастрын зургийг бүгд иргэд бол цахимаар авах ийм боломж нөхцөл бүрдсэн.

Ер нь цаашидаа бол бид нар бас олон улсын хөгжлийн чиг хандлагатай бол мэдээж нийцүүлж ажиллана. Энэ хүрээндээ бол бид бүхэн сая бас та хэллээ, ер нь энэ газрын бүртгэл, үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийг бол нэгтгэх зайлигүй шаардлагатай. Ингээд бид бүхэн бол нэгдсэн ойлголтод хүрч, газар болон үл хөдлөх хөрөнгийг нэг систем дээр дундын мэдээллийн сангаар дамжуулан бүртгэлжүүлж байгаа юм. Үүнийгээ

үндэслээд бид бүхэн 3 хэмжээст, 4 хэмжээст кадастрыг байгуулах ийм ажлыг эхлүүлэх гэж байна. Ингэснээр бол иргэд, төрийн байгууллага, татварын нэгдсэн том бааз суурь бий болно. Мөн хаягийн нэгдсэн шинэ систем бий болно. Цаашидаа бол ер нь тивийн дижитал тивийн гэдэг ийм эрин рүү шилжих шаардлагатай болж байгаа юм. Өөрөөр хэлбэл бид бүхэн дижитал ихэр ийм байгуулах ийм зайлигүй шаардлагатай. Ингэхийн тулд бол саяын газар, үл хөдлөх хөрөнгө, барилга байгууламжийг заавал бүртгэлийн шинэ системүүд рүү оруулах ёстой. Тэгж байж бид ухаалаг энэ хотуудыг ухаалаг газрын харилцаануудыг заавал үүсгэнэ. Ингэхийн тулд бол орон зайн өгөгдлийн дэд бүтцийн асуудал маш чухал байгаад байгаа юм.

Бид бүхэн саяхан Нэгдсэн үндэстний байгууллагаас бидэнд зөвлөмж, чиглэл өгсний дагуу орон зайн өгөгдлийн дэд бүтцийн хүрээгээ тодорхойлсон. Өнөөдөр Монгол Улсад орон зайн өгөгдлийн талаар бүх салбар байгууллагууд өөр өөрийн гэсэн мэдээллийг үүсгээд явдаг. Онцгой байдлын газар нэг орон зайн өгөгдлийн баазтай, газрын харилцааны байгууллага бас нэг, байгаль орчны газар бас нэг өөр, хүнс, хөдөө аж ахуйн байгууллага бас өөр ингээд хоорондоо ямар ч уялдаж өгдөггүй. Тэгвэл орон зайн өгөгдлийг 18 суурь өгөгдлийн хүрээг тодорхойлсон. Ингээд энэ өгөгдлийн хүрээгээ бид бүхэн стандартыг батлуулсан байгаа. Үндэсний стандартын газраар 18 өгөгдлийн стандартыг батлуулж, үндэсний орон зайн хөгжлийн геопортал гэсэн үндсэн сайт нэгдсэн системийг байгуулсан. Энэ дээр бол бүх салбарын орон зайн өгөгдлүүдийг бүртгэх ийм

зорилготой. Ингээд бол ЗГ-аас орон зайн өгөгдлийн дэд бүтцийн тухай хууль батлах ажлын хэсгүүдийг байгуулсан. Ажлын хэсэг ажиллаад хуулийн төслөө ямар ч байсан боловсруулчихсан байгаа. Удахгүй бас энэ ЗГ-т тус хуулийн төслийг хэлэлцүүлж шийдвэрлэвэл Их Хурал руу оруулж ирж хэлэлцүүлнэ.

Ер нь цаашидаа бол бид бүхэн бас блокчэйн технологийг ашиглах, хиймэл оюун ухаанд суурилсан газрын бүртгэл, газар зохион байгуулалтын ажлыг бол эрхлэх ийм шинэ дэвшилтэт, техник технологиудыг бол мөрдөж ажиллахаар ингэж зорьж ажиллаж байгаа.

Алсын хараа 2050 урт хугацааны болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүд дээр яг саяын ярьсан шийдэл технологийн дэвшилүүдийг бол тусгаж өгсөн байгаа. Тэр ажлынхаа хүрээнд ажлууд бол зохион байгуулагдаад явж байгаа.

С.Одонтуяа: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Тэр дэлхий хаашаа явж байгаа, дэлхийн стандарт, түүний хамаарах олон улсын байгууллагууд, олон улсын гэрээ конвенц, түүний дагуу дэлхийн нэгдсэн стандартад нийцэж, цаашидаа энэ харилцаа явах гэдэг өөрөө их том зүйл, цаана нь бодоод байх ч шаардлагагүй, зүг чиг маань өөрөө тодорхой байгаа байх. Түүнийгээ илүү сайн танилцуулж, түүн дээрээ илүү тийм мэдээлэл өгч ажиллах нь өөрөө зүйтэй байх.

2 дугаарт нь, ер нь газрын өмчлөлийн тухай ингээд ярьж байна.

Газар өөрөө яг өмч өмчилж байгаа энэ 0 цэг, нойль цэг ч гэх юм уу, энэ өндөржилтөөсөө дээшээ ямар зайнд, тухайн өмчлөгчийн өмч, доошоогоо ямар зайн дээр өмчлөгчийн өмч байдаг юм? Үүн дээр яг энэ хуульд тодорхой тийм заасан зүйл заалтууд байна уу?

С.Одонтуяа: Хэн хариулах вэ. Энхманлай, геодези, зураг зүйн газрын дарга.

А.Энхманлай: Энэ газрын харилцаа бол угаасаа газрын гадаргуу, гадаргуугаас дээших агаарын орон зай, мөн энэ газрын хэвлий рүү орж байгаа бүх харилцааг бол газрын харилцаанд бол зохицуулж явахаар ингэж заасан байгаа. Өөрөөр хэлбэл газар доор нэлээд олон байгууламжууд баригдаж байна, тэр бол бас саяын хэлсэн, газрын бүртгэлд заавал хамаарагдана. Дээшээ бас өндөр барилгууд баригдах агаарын орон зай тийм ээ, энэ бүх эзэмшигч, өмчлөгч нар бол газрын бүртгэлд бүртгэгдэж, газрын харилцаанд оролцох ийм нөхцөл байдал орсон. Энэ орон зайн давхаргыг бол газар гэж үзнэ ээ гэж бид нар заасан. Тэгэхээр бол бид нар бол Газрын тухай хууль, энэ бусад газрын харилцаанд тогтоож байгаа багц хуулиудаар саяын асуудлыг зохицуулна. 3 хэмжээст бүртгэлийг бүртгэнэ ээ гээд бас энэ кадастрын тухай хууль дээр тодорхой заагаад өгчихсөн. Хуучин бол хууль дээр энэ асуудал тусгагдаагүй байсан. Ингээд шинэ хууль хэрвээ батлагдвал бид бүхэн саяын 3 хэмжээст кадастрын ... /минут дуусав/

С.Одонтуяа: Гишүүний асуултад нэмээд хариулчих Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын дарга Энхманлай

А.Энхманлай: Тодорхой бол ямар нэгэн хэмжээ заагаагүй, дээшээ доошоо гэсэн. Ямар ч байсан үл хөдлөх хөрөнгө, байгууламж байгаа бүх газрыг бол бүртгэлжүүлнэ, тэнд бол газрын харилцаанд газар гэж ухагдахуун ойлгогдоно гэж ингэж заасан байгаа.

С.Одонтуяа: Хуулийн төсөлтэй холбоотой гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя. Үг хэлэх гишүүд алга.

Горимын санал. МАН-ын бүлгийн дарга Дуламдоржийн Тогтохсүрэн горимын санал гаргана.

Д.Тогтохсүрэн: Баярлалаа. Газар өмчлөлийн хууль бол бас чухал ач холбогдолтой хууль. Тийм учраас МАН-ын бүлэг энэ хуулиар завсарлага авч, саналаа нэгтгэх шаардлагатай гэж үзэж байгаа учраас дэгийн хуулийн дагуу 5 хоногийн завсарлага хүсэж байна. Баярлалаа.

С.Одонтуяа: УИХ-ын дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу МАН-ын бүлэгт ажлын 5 хоногийн завсарлага өглөө.

Дараагийн хуулийн хэлэлцүүлэгтээ орё.

16.50 цаг

Дараагийн хууль.

Дөрөв.Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.06.17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. 3Г 2022 оны 6 дугаар сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Барилга, хот байгуулалтын сайд Бэгзжавын Мөнхбаатар танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Мөнхбаатар: УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн тавдугаар зүйлийн 3 дахь хэсэгт өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно. Мөн хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт төр, газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөн олговор дээр газрыг солих буюу эргүүлэн авах, уг газар хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал хураан авч болно. 16 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмч, эд хөрөнгийг дайчлан авбал нөхөн олговор, үнийг төлнө гэж заасан. Төрөөс улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, дэмжлэг үзүүлэх зорилгоор үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон дэд бүтцийн болон бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлж байна. Энэхүү үйл явцтай уялдан улсын тусгай болон нийгмийн зайлшгүй хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэн хувийн өмчийн болон эзэмшил, ашиглалтад байгаа газрыг чөлөөлөх шаардлага гарч байна. Түүнчлэн олон нийтэд зайлшгүй шаардлагатай, тэдний эрх

ашиг, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, аюулгүй байдлыг хангахад зориулсан төрийн үйлчилгээ, дэд бүтэц, барилга байгууламжийг нийгмийн зайлшгүй хэрэгцээг тодорхойлох, энэ хэрэгцээг хангах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх шаардлагатай байгаа юм.

Газрын тухай Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн газрыг чөлөөлөх талаарх зохицуулалт нь зөвхөн гэрээний үндсэн дээр харилцан тохиролцох, хэрэв тохиролцож чадаагүй тохиолдолд хэрхэн зохицуулах, шийдвэрлэх хууль, эрх зүйн зохицуулалтгүй байна. Мөн олон нийтийн эрх ашгийг хангаж чиглэсэн бүтээн байгуулалт, төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад дийлэнх хэрэгтэй нөхөн олговор, бусад асуудлын талаар гэрээ, хэлэлцээрүүдийн замаар шийдвэрлэсэн боловч цөөн тооны иргэд хэт үндэслэлгүй шаардлага тавих замаар нийгмийн нийтлэг эрх ашиг төдийгүй бусад иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарлаж байгаа тохиолдолд тэдэнд төрийн албадлагыг хэрэглэх нөхцөл, журмыг тодорхойлох шаардлага зүй ёсоор урган гарч орж байгаа юм.

Иймд газар чөлөөлөх үндэслэлийг тодорхой болгож, гагцхүү хуульд заасан үндэслэлээр газар чөлөөлөх, газар өмчлөгч, газрын эрх бүхий иргэдэд шударга ёсны нөхөн олговрыг олгох, мөн төрийн байгууллага болон газар чөлөөлөлтөд өртөгч хүн, хуулийн этгээдийн эрх, үүргийг тодорхой болгох зэрэг гол гол тулгамдсан асуудлыг хуулийн төсөлд цогц байдлаар тусгасан, нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай анхдагч хуулийн

төслийг 5 бүлэг, 37 зүйлтэйгээр боловсрууллаа.

Хуулийн төслөөр ашигт малтмалын хайгуул, олборлолттой холбогдсон гарч буй газар чөлөөлөлтийн асуудлыг зохицуулахгүй бөгөөд хувийн өмчийн болон газрын эрх бүхий этгээдийн газар дээр дахин төлөвлөлт, хэрэгжилтийг хийхдээ зөвхөн тэдний зөвшөөрөл, санаачилга дээр тулгуурлах нь илүү оновчтой гэж тооцон тусгалаа.

Уг хуулийн төсөл батлагдсанаар газар чөлөөлөх үндэслэл, шаардлага тодорхой болж, газар чөлөөлөх харилцаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага тодорхойлогдох тул нийтийн эрх ашгийг хангахад чиглэсэн аливаа бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа саадгүй хэрэгжих эрх зүйн орчин бүрдэх юм.

Газрын багц хуулийн төслийг УИХ-д мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулснаар газрын харилцааны хууль, эрх зүйн орчны шинэтгэлийг бүрэн утгаар нь хийж, ил тод, нээлттэй, иргэн, хуулийн эрхийн дээд этгээд цаг хугацаа хэмнэсэн, чирэгдэлгүй авлигаас ангид үйл ажиллагааг хэрэгжүүлж чадна гэж үзэж байна.

Энэхүү хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

С.Одонтуяа: Баярлалаа.

Төслийн талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг УИХ-ын гишүүн Гочоогийн Ганболд танилцуулна. Таныг индэрт урьж байна.

Г.Ганболд: УИХ-ын дэд дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын ЗГ-аас 2022 оны 6 сарын 17-ны өдөр Монгол УИХ-д өргөн мэдүүлсэн Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн хэлэлцэх эсэх асуудлыг Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч Монгол Улсын эдийн засгийн өсөлттэй уялдуулан үндэсний болон бүс нутгийн хэмжээний томоохон дэд бүтэц, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлэх, улс, орон нутгийн тусгай хэрэгцээ, нийгмийн зайлшгүй хэрэгцээ, ашиг сонирхолд нийцүүлэн хувийн өмчийн болон эзэмшил, ашиглалтад байгаа газрыг чөлөөлөх шаардлагатай бөгөөд газар чөлөөлөх үндэслэлийг тодорхой зааж, гагцхүү хуульд заасан үндэслэлээр иргэд, тэдгээрийн газар өмчийн эрхийг хязгаарлах, иргэдэд зохих хэмжээний шударга ёсны нөхөн төлбөрийг олгох, мөн төрийн байгууллага, иргэдийн эрх, үүргийг тодорхой болгох зэрэг асуудлыг цогцоор нь шийдвэрлэхээр уг хуулийн төслийг боловсруулжээ.

Хуулийн төсөл батлагдсанаар газар чөлөөлөх үндэслэл, шаардлага, газар чөлөөлөх харилцаанд оролцогч талуудын эрх, үүрэг, хариуцлага тодорхой болж, нийтийн эрх ашгийг хангахад чиглэсэн аливаа бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа саадгүй хэрэгжих эрх зүйн орчин бүрдэнэ гэж хууль санаачилж үзсэн бөгөөд хуулийн төслийг Ди парламент.мн сайтад байршуулж

иргэд, олон нийтийн саналыг авч байгаа болно.

Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг тус Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 54,6 хувь нь үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

УИХ-ын эрхэм гишүүд ээ, Нийгмийн зайлшгүй хэрэгцээг үндэслэн газар чөлөөлөх тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн ХХОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцэх эсэх талаарх Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа.

Ажлын хэсгийг танилцуулъя. Бэгзжавын Мөнхбаатар Барилга, хот байгуулалтын сайд, Сандагийн Магнайсүрэн Барилга, хот байгуулалтын яамны ТНБД, Цэндгомбын Болорчулуун ХХААХҮЯ-ны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Цогтын Баярбат Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулах Газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга, Хаянгаагийн Болорчулуун Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн

сайд, Анандын Энхманлай Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын дарга, Раднаабазарын Ганхуяг Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын дарга, Цэвэлмаагийн Ихбаяр Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын Газар зохион байгуулалтын хэлтсийн дарга, Пүрэвдоржийн Баянтүмэн Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын Кадастрын хэлтсийн дарга, Энхбаатарын Цолмонжаргал Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Батдэлгэрийн Нямдорж Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга, Гомбодоржийн Болормаа Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, Базарпүрэвийн Гоёсайхан Барилга, хот байгуулалтын яамны Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын шинжээч, Дэндэвийн Энхтуяа Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын Захиргаа удирдлага хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн, Найдангийн Бямбадорж ХХААХҮЯ-ны МАА-н бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух УИХ-ын гишүүдийн нэрийг бүртгэе.

Одонгийн Цогтгэрэл гишүүнээр тасаллаа. Тогтохсүрэн дарга асуултаа асууя.

Д.Тогтохсүрэн: Энэ бол их чухал ач холбогдолтой хууль. Газрыг нийгмийн зайлиггүй хэрэгцээнд авах тухай асуудал байгаа. Би 2 зүйлийг асууя гэж бодож байна.

Хуулийн төсөлтэй холбогдуулаад харахаар нэгдүгээрт бол мэдээж улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, хөгжлийн ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөнд туссан дэд бүтцийн газрыг төлөвлөх нь чухал. Энэ бол чухал ач холбогдолтой байгаа юм. Гэхдээ энэ дээр 2 асуудал байгаа юм.

1 дүгээр асуудал нь, юу байна вэ гэхээр хэт нийгмийн хэрэгцээ шаардлага гэдэг үүдэн дээр хэт газрыг замбараагүй олгох, энэ юм руу явчих вий гэдэг ийм болгоомжлол байгаа юм, энэ хуулийн төслөөс харахаар. Нийгмийн хэрэгцээнд зориулаад өгч болно оо гэдэг агуулга байгаа байхгүй юу. Жишээ нь орон сууцны газрын төлөвлөлт байна. Манай одоо юу гэдэг юм, дүүрэгт, аймагт орон сууц хэрэгтэй байна гээд баахан газраа орон сууцны хороолол хэлбэрээр хувийн хэвшилд дуудлага худалдаа ч байхгүй шууд өгөх ийм хэлбэр байгаад байгаа юм. Энэ ер нь хэр оновчтой хэлбэр вэ гэдэг асуудал байгаа юм.

2 дугаарт, газрын үнийн тухай асуудал байгаа юм. Бид нар ингээд л ерөөсөө газрыг нийгмийн хэрэгцээнд буцаагаад авах гээд ерөөсөө газар авч чаддаггүй. Тэгэхээр энэ тодорхой үнэ байна уу? Ер нь энд жаахан захиргааны арга хэрэгтэй, бас. 5 айл байлаа гэхэд 4 айл нь газраа өгчхөөд авто замын газарт газар өгчхөөд нэг айл нь өгдөггүй, ингээд суугаад байдаг юм дүүрэн байхгүй юу. Тэгэхээр энд би үнэ байна уу? Тодорхой энэ хүнд л

авна, авахгүй л бол ингээд л шаардлага тавьдаг ийм хэлбэрийн эсвэл газрыг нь сольдог ийм хэлбэрүүд байна.

3 дахь асуудал юу байна вэ гэхээр нийслэлд байгаа. Баахан эрх мэдэлтэй, мэдээлэлд ойр байсан хүмүүс баахан газар авчихдаг, тэгээд л сургуулийн газар, цэцэрлэгийн газар нийгмийн хэрэгцээний газруудыг ингээд л нөгөө нийслэлийнхэн чинь юугаар авдаг билээ, нөхөн төлбөрөөр авч байна гэж нэрлээд л, ингээд. Ганцхан жишээ хэлье. Өнгөрсөн жил нийслэл Улаанбаатар хот энэ нөхөн төлбөр өгч буцааж авсан газар нь бараг 80, 90 тэрбум төгрөг байлаа шүү дээ. Энэ бол аймаар байхгүй юу. Тэгээд нэг хэсэг эрх мэдэлтэй хүмүүс газар авчхаад л, ингээд л буцаагаад төрд шахаад л ингээд сууж байдаг болчихоод байгаа байхгүй юу. Миний сонссоноор тэгж сонссон.

Нөгөө нэг бид нарын түгжрэлд өгөөрэй гээд шийдсэн 420-оос чинь тодорхой мөнгө нь бий, газар чөлөөлөлтөд явчихсан юм байна гэж бодож байгаа шүү. Үүнийг ер нь цаашидаа яаж шийдэх юм бэ гэдэг асуудал байгаа. Ийм асуудлыг би хууль санаачлагчаас асууя гэж бодож байна.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ, 80 дугаар микрофон.

Тогтохсүрэн гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Нямдорж.

Хуулийн төсөл маань бол ерөнхийдөө гишүүний асуусан 3 асуултыг яг онцолж үзэл баримтлал яг энэ асуудлыг зохицуулахаар бол

чиглэгдэж боловсруулагдсан байгаа. Тэгэхээр нийгмийн хэрэгцээ шаардлага өнөөдөр бол яг бодит байдал дээр бол Нийслэл дээр болон гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төслүүд дээр бол газар чөлөөлөлтийн ажлууд хийгдэж байгаа. Тухайлбал, тоон мэдээ аваад үзвэл 17-20 онд бол нийслэл дээр бол нөхөн олговорт 106 тэрбум төгрөг, 2617 нэгж талбар. Жишээлбэл, 1008 айлын орон сууцны хөтөлбөр дээр бол 29 нэгж салбар дээр 3,3 тэрбум төгрөг ингээд, ингээд хэрэгжээд явж байгаа. Ийм бодит байдал дээр.

Үндсэн хууль дээр бол өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно гээд, тэгээд энэ дээр яг нарийвчилсан зохицуулсан хуульгүй учраас нэг талдаа төсвийн хөрөнгөөр татвар төлөгчдийн мөнгөөр нийгмийн зайлиггүй хэрэгцээ гэдэг үндэслэлд ямар нэгэн зориулалтгүйгээр газар чөлөөлөлт хийгээд байна уу гэсэн асуудал. Энэ дээр бол хуулийн төслөөрөө бид нар үүнийг нийгмийн зайлиггүй хэрэгцээ шаардлага гэдгийг юуг юу гэж үзэх вэ гэдгийг хязгаарлаж, тодорхой зааж өгсөн. Ингэхээр нөгөө орон сууц барьдаг, оффисын барилга барьдаг энэ бүх асуудлууд бол энэ хууль батлагдсанаар нийгмийн зайлиггүй хэрэгцээнд хамаарахгүй гэдгээрээ хязгаарлагдана.

Дараагийн нэг асуудал, үнийн асуудал. Хуулийн төсөл маань мэдээж өнөөдөр бол газар чөлөөлөлтүүд бол хийгдэж байгаа. Тэгэхдээ ямар дүрэм журмаар явж байна вэ гэхээр Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон энэ дээр үндэслэсэн Барилга, хот байгуулалтын сайд, Сангийн сайдын баталсан Хөрөнгийн

үнэлгээний журам, газар, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний журмаар зохицуулагдаад явж байгаа. Хуулийн төсөл дээр бол бид нар гол зарчмын үнэлгээний зарчмыг хийхдээ бол өмчлөлийн газрыг бол зах зээлийн үнэлгээгээр нь, газрын хязгаарлагдмал эрхийн газрыг бол тухайн газрын суурь үнэлгээгээр, тэгээд дээр нь байгаа үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг бол зах зээлийн үнэлгээгээр тус тус тооцож үнэлэхээр тусгасан байгаа.

Дараагийн нэг асуудал, нийслэлд газар авчхаад эрх мэдэлтнүүд ингээд мэдээлэлтэй ойрхон байгаа хүмүүс нь завшаад байдаг гээд. Бид нар хуулийн төслийг боловсруулахдаа бол АХБ-ны нийгмийн бодлого Монгол Улсын өнөөгийн байдал, Хятад Ард улс, Солонгос улс, Канад, Герман, Казахстан, Сербид гээд л улсуудын туршилагыг судалсан. Яг энэ улсууд дээр бол яг энэ асуудлууд бол байнга гардаг, энэ дээр бол анхааруулж хэлдэг юм байна лээ л дээ. Яагаад гэвэл мэдээлэлд ойр байгаа хэсгүүд нь бол газрын тухай мэдээллийг авчхаад, иргэдээс газрыг авчхаад цаашидаа төрд дамлаж зардаг. Тэгэхээр хуулийн төслөөрөө бид нар үүний асуудлыг бол дотоод мэдээлэл эзэмшигч гэдэг зохицуулалтыг оруулж ирээд энэ зохион байгуулалтын баримт бичиг, газар төлөвлөлтийг баримт бичгийг боловсруулсан, түүнд оролцсон этгээдүүд бол энэ дотоод мэдээллийг задруулахгүй байх үүрэг хүлээлгэж байгаа. Ийм байдлаар зохицуулалтыг хийсэн байгаа.

Ингэхээр бол тухайн газар зохион байгуулалт, хот байгуулалтын баримт бичгийг боловсруулсан ААН-үүд тухайн барилга байгууламжийг төлөвлөж байгаа ААН-үүд

байгууллага, захиалагч нар бол энэ мэдээллээ аль болох дотоод мэдээлэл гэж үзээд задруулахгүй байх ийм зохицуулалттай байгаа, тусгасан байгаа. Баярлалаа.

С.Одонтуяа: Баярлалаа. Гочоогийн Ганболд гишүүн асуулт асууя.

Г.Ганболд: Энэ бол маш чухал хууль. Дэлхий нийт дээр энэ газраа чөлөөлөөгүйгээс болоод алдартай алдартай нөгөө том гүүр, хурдны замуудын дунд ганц нэг айлууд үлдчихсэн, том жишээнүүд бий л дээ. Үүнийг бид нар үнэхээр хэлэлцэх нь зүйтэй. Гэхдээ би бол зүгээр, одоо бодоход арай болоогүй байсан. Эхлээд бид нар энэ үл хөдлөхийн татварынхаа асуудлыг, бүртгэлийн асуудлыг, үнэлгээний асуудлыг нь эхэлж цэгцэлж байж газар олголтоо нэг, 2 жил жаахан гацааж байж энэ рүү орсон бол уг нь боломжтой байсан юм л даа. Одоо бид нар жишээлэх юм бол энэ түгжрэлийн асуудал гээд гүүрэн байгууламжууд, энэ Эл ар ти, Би ар ти гээд маш том том төслүүд хэрэгжүүлнэ. Энэ хүрээнд бол бид нар энэ газар олголтоо ер нь дийлэхгүй болох юм байна, яваандаа. Тэгээд ер нь бол нийслэл Улаанбаатар хот дээр ингээд өмнөх жишгүүд зураг төсөв хийж байгаа нөхдүүд нь мэдээллийн давуу байдлаа ашиглаад урьдчилаад яг трансаа үүгээр явна гээд тэр газруудыг нь худалдаж аваад, эргээд төрд шахдаг ийм л сүлжээ явж байгаа шүү дээ. Тэгэхээр зэрэг үүнийг бид нар яаж төлөвлөх вэ гэдэг маш чухал байгаа юм.

Одоо би эндээс нэг зүйл асуух гээд байгаа. Энэ хууль батлагдсанаар бол, одоо бүр нөгөө газар чөлөөлөх

гэж байгаа хүмүүс нь бүр өөрсдөө эрхтэй болчихсон, тэр эрхийнхээ дагуу юу гэдэг юм, өөрийнхөө үл хөдлөх хөрөнгийг өөрөө үнэлэх үнэлгээний компаниар үнэлүүлнэ гэж байна шүү дээ. Одоо та нар энэ харж байгаа биз дээ. Газар чөлөөлөлтөд өртөгч нь ийм ийм эрх эдэлнэ ээ гээд, 10 хэдэн эрх байна. Энэ эрхээр бол тэр нөхөр ер нь газраа хэзээ ч чөлөөлөхөөргүй нөхөр болох юм байна шүү. Одоо төр та нар үнэлчихсэн л гээд энэ газрыг нь, үл хөдлөхийг нь үнэлнэ гээд байна, үгүй юм байна шүү дээ, наадах чинь. Өө, танай үнэлгээний компанийг бид нар сонгохгүй ээ, би өөрөө хувийн компаниар үнэлүүлнэ ээ гэж хэлээд тэгээд өөрийнхөө үл хөдлөхийг хэдэн тэрбумаар үнэлүүлээд ирвэл бид нар тэгээд яах вэ? Ийм юмыг нээж өгөх гэж байгаа байхгүй юу. Одоо энэ бол яваандаа нөгөө хүмүүсийн үл хөдлөх хөрөнгийг банкны нүдээр харахаар нэг амбаар, татварын байцаагчийн нүдээр харахаар зэрэг том хауснууд гэдэг шиг яг тийм юм болох байхгүй юу.

Тэгэхээр зэрэг энэ эрх, үүргүүд дээр ер нь нэг жаахан хэдүүлээ анхаарч зарим нэг хэдүүлээ энэ нийгмийн зайлиггүй хэрэгцээ шаардлага гэдгийг би 2 хуваамаар байгаа байхгүй юу. Жишээлэх юм бол асар том, энэ дэд бүтцийн Би ар ти, эл ар ти түгжрэлтэй холбоотой энэ уулзваруудыг чөлөөлөх хүрээнд бол төр зарим нэг юман дээр яг төрийн хатуу шаардлагаар үнэлгээ дээр нь өөрчлөлт оруулахгүйгээр нөхөн олговор болгож чөлөөлдөг байх хэрэгтэй.

Зарим нэг зүйл, тэгэхгүй бид нар зүгээр нийгмийн хэрэгцээ шаардлагатай гэж юу вэ гээд л

унишаар зүгээр нэг энгийн үгээр бүгд орохоор ийм зүйл байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг үүнийг хэдүүлээ бараг нийгмийн бүр нэн зайлиггүй шаардлагатайг нь бол төр ер нь нэлээн хатуу оролцох хэрэгтэй. Тэгэхгүй бол нөгөө хүмүүсээ эрхийг нь эдлүүлж байна гэх юм бид нар цаашидаа эндээс бараг нэг ч газар чөлөөлж чадахгүй юм болно.

Энэ жил Улаанбаатар хот дээр түгжрэл, тэгээд тэр нэг хэдэн сургууль, цэцэрлэгийн газар чөлөөлөх гэж бараг ихэнх мөнгөө зарчихлаа шүү дээ. Батлагдсан мөнгөнөөс их зарагдаж байна. Тэгэхээр цаашидаа бол энэ бүр үүнээс их болно, дийлэхээргүй болно. Тэгэхээр үнэлгээгээ эхэлж бид нар ингээд зайлиггүй хийж байж үүнийг ингээж явуулахгүй би арай эрт орж ирж байгаа юм биш биз дээ. Эхлээд би ингэх гээд байна шүү дээ, ойлгож байна уу. Үл хөдлөхүүдийг нь эхлээд үнэлүүлээд татварын хууль үнэлгээнүүдээ тогтоочоод, тэр үнэлгээ дээр нь бид нар ярихгүй бол татвар төлөхөөрөө ерөөсөө нэг аравхан саяар ч юм уу үнэлж ингээд татвараа төлдөг, төр худалдаад авъя гэх юм бол арван тэрбум л гэх гэж байгаа байхгүй юу. Тэгэхээр зэрэг эхлээд бид нар бол үүнийг жаахан явуулах ёстой байсан. Би бол жаахан арай түрүүлж яарч орж ирсэн байна. Энэ татварын хууль, үл хөдлөхийн үнэлгээний юмнуудаа жаахан явуулж байгаад нийслэл Улаанбаатар дүүргүүдийг 2 жил газар олголтыг нь хориглож байж тэгж байж нэг 2 жилийн дараа үүнийг том том ... /минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ. Нямдорж Барилга, хот байгуулалтын

яамны Хуулийн хэлтсийн дарга 80 дугаар микрофон.

Ганболд гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн хэлтсийн дарга Нямдорж.

Тэр гишүүний ярьж байгаа үнэн л дээ. Өгөх болохоороо бага үнэлгээтэй, авах болохоороо хямд үнэлгээтэй ингээд байдаг. Энэ хоорондын уялдааг бас хангах шаардлага байгаа юу гэдгийг бол байгаа гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Намрын чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлын жагсаалтад бол Хөрөнгийн үнэлгээний тухай хууль бас орчихсон явж байгаа. Тэгээд энэ хүрээндээ бас үүнийг шийдэх боломжтой гэж харж байгаа. Яагаад гэвэл хуулийн төслөөрөө бол газар чөлөөлөх ажиллагааг зохион байгуулагч, төрийн байгууллага маань өөрөө үнэлэхэд томилогдсон үнэлгээчнээс үнэлгээ хийгээд түүнийг нөлөөлөлд өртөгч маань өөрөө зөвшөөрөхгүй бол өөрийнхөө зардлаар өөрийнхөө томилсон тусгай зөвшөөрөл бүхий хөрөнгийн үнэлгээний компаниар үнэлүүлээд энэ 2 үнэлгээний хооронд зөрүү гарвал гуравдагч үнэлгээчин үнэлгээ хийхээр ийм зохицуулалт орж ирсэн. Тэгээд гуравдагч үнэлгээчний үнэлгээ бол эцсийн шийдвэр байхаар ингээд тогтоож өгсөн, тусгасан.

Тэгээд хөрөнгийн үнэлгээ бол Сангийн яамнаас олгодог, тусгай зөвшөөрлийн үндсэн дээр олгодог тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа олгодог ААН-үүд байгаа, тэгээд энэ дээр үнэлгээчний ёс зүй, тусгай зөвшөөрөлтэй байгууллагуудын шаардлага, ёс зүй гээд эд бүгд ингээд байгаа давхар хяналтад ингээд явдаг байгаа. Тэгэхээр энэ дээр бол

үнэлгээний дүн бол хоорондоо нэг их зөрөхгүй яваад байгаа. Одоо энэ нийслэл дээр хийгдэж байгаа үнэлгээний дүнгүүд ингээд харахаар ерөнхийдөө бол огцом хоорондоо зөрүүтэй байгаа зүйл харагдахгүй байгаа юм.

Тэр энэ нэг хуулийнхаа зорилт юугаа хангаад 2 хуваагаад гол гол нь тэр эл ар ти ч гэдэг юм уу, тийм том төслүүд дээрээ бол нөхөн олговор дайчлан авах гэдэг асуудал яригдаж байгаа. Манайд мөрдөгдөж байгаа хууль, эрх зүйн орчноор бол захиргааны байгууллагын үйл ажиллагаа бол бүхэлдээ Захиргааны ерөнхий хуульд захирагдаж байгаа. Аливаа шийдвэр, шийдвэр гаргах үйл ажиллагаа бол бүгд захиргааны шүүхийн хяналтад явж байгаа. Тэгэхээр энэ бүх процесс дээр бол маш олон процессууд явагдах учраас энэ процесс болгон дээр эрх ашиг нь зөрчигдөж байгаа нөлөөлөлд өртөгчид маань юу яах боломжтой байгаа, шүүхэд гомдол гаргах, энэ хэмжээгээрээ дараа дараагийн үйл ажиллагаанд түдгэлзэгдэж энэ юунууд, газар чөлөөлөлтийн ажлууд маань зогсох ийм эрсдэлтэй. Одоо байгаа ингээд судалгаагаар аваад үзэхээр шүүх дээр бол яг ингэж дайчлан, ингэж шүүхийн шийдвэрээр газар чөлөөлүүлсэн шийдвэр бол байхгүй. Дандаа тохиролцооны журмаар яваад байгаа юм, иргэдтэйгээ тохиролцож ингэж яваад байгаа юм. Тэгээд хууль, эрх зүйн орчин тодорхойгүй ч бас иргэд маань өөрөө ч чөлөөлөх хүсэл зоригтой иргэд маань өөрөө хууль, эрх зүйн орчин нь тодорхойгүй байна. Би яг ямар ямар юман дээр нөхөн олговор авах юм бэ гэдэг нь тодорхойгүй учраас бас хардлагатай, нөгөөдүүл нь өөрөө аваад өндөр аваад байгаа юм уу, би ямар аваад байгаа юм бэ гэдэг

байдлаар ингэж их хандаж байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл маань бас энэ асуудлыг давхар зохицуулахаар ингэж орж ирсэн байгаа.

С.Одонтуяа: Гочоогийн Ганболд гишүүн тодруулъя.

Г.Ганболд: Энд нэг зүгээр ийм зүйл байгаа юу. Би бүрэн бас харж чадаагүй учраас. Одоо жишээлэх юм бол зам барилгууд замууд бол ингээд трастай, Улаанбаатар хот чинь нэг сургууль, цэцэрлэг ингээд дүүргүүдэд барихын тулд заавал энд барина гээд хүний юмыг сонгож аваад түүн дээр нь асар их мөнгө төлөө явж байгаа байхгүй юу. Энэ дээр ингээд сонгон шалгаруулалтын яг тэр орчин бүсэд нь иргэдээс ингээд санал авдаг, газар чөлөөлөлтийн үнийн санал авдаг, тэгээд хамгийн бага үнэ л үнэ, тэгээд дэд бүтэцтэй газраас авдаг тийм хувилбаруудыг оруулж өгөхгүй заавал энд барина гээд л. Тэгээд л нөгөө нөхөртэйгөө шууд үнийн хэлэлцээр ороод явчхаж байгаа байхгүй юу. Хажууд нь яг хажуу талын хашаанд нь хүн хямдхан өгөх айлууд байж байхад ийм юмнуудыг нэг жаахан тодорхой болгож оруулж явахгүй бол сургууль цэцэрлэг, эд нар бол харьцангуй гайгүй шүү дээ, нэг объект чөлөөлөөд явчихад асуудалгүй байхгүй юу. Тэгэхээр энэ дээр нэг заавал ийм зайлшгүй юмнуудыг оруулж өгөх шаардлага байгаа юм. Тэгэхээр зэрэг энэ дээр бас сайд ямар бололтой байгаа вэ? Энэ дээр нэг заавал нэг тийм оруулах хэрэгтэй байгаа юм шүү. 10-аас доошгүй, эсвэл санал тэр бүр ... /минут дуусав/

С.Одонтуяа: Мөнхбаатар сайд хариулъя.

Б.Мөнхбаатар: Ганболд гишүүнтэй санал нэг байна л даа. Уул нь сургууль, цэцэрлэгийн хамрах хүрээ тоотой байгаа шүү дээ, тэдэн хүн амтай газар, тийм сургууль, цэцэрлэг бүр эхнээсээ төлөвлөлт хийж явах ёстой. Ер нь үүний цаана түрүүн газар өмчлүүлэх болон энэ газар чөлөөлөх эд нарын цаана дандаа төлөвлөлтийн асуудлыг шаардаад байгаа юм. Төлөвлөлтөө хийхгүй бол 2 эгнээ зам барьчхаад арай өргөтгөх учир дахиад хажуу талын давхар замынхаа газрын трасыг төр нь авч үлдэж байхгүй бол тэгж боддоггүй, тэгээд солигдож л байдаг, хоноцын юм шиг хандаж байдаг. Тэгэхээр энэ бүгдийн цаана төлөвлөлтийг шаардаж ирж байгаа юм. Тэгээд сая Ганболд даргын хэлж байгаа, тэр бол гишүүний хэлж байгаа, санал нэг байна.

Том том төслүүд дээр ингээд трас нь гараад тодорхой байдаг бол сургууль, цэцэрлэг, гэнэт хэрэгтэй гээд л нэг тохиолдлын юм шиг гэнэт санахгүй байж байгаад санаж орж ирж байгаа юм шиг асуудлууд бол байгаад байгаа. Тийм учраас эхнээс нь төлөвлөлтүүдийг нь гаргаж ирж, байрилуудыг нь харж дундын бүсийг нь тогтоож ингэж хийх юман дээр зайлшгүй явах ёстой. Одоо энэ хуулийн төсөл хэлэлцэх нь дэмжигдээд хэлэлцэгдээд ирэхэд бас үүнийг оруулаад ингээд явах нь зүйтэй байгаад байгаа юм. Ер нь энэ ... /минут дуусав/

С.Одонтуяа: Нямдорж, Хуулийн хэлтсийн дарга, Барилга, хот байгуулалтын яам 80 дугаар микрофон.

Б.Нямдорж: Ганболд гишүүний асуултад тодруулж хариулъя.

Хуулийн төслийн 6.2 дээр бас бид яг энэ нэг гишүүний ярьсан, таны ярьсан асуудлыг бол бүгдийг нь хуулийн төсөлдөө бас авч үзсэн. 6.2 дээр газар чөлөөлөх байршил, талбай нь хот байгуулалтын норм, стандарт, хот байгуулалтын болон газар зохион байгуулалтын төлөвлөгөөтэй уялдсан байна гэсэн ийм заалт оруулж өгсөн.

8.3.1 дэх заалт дээр бол газар чөлөөлөлтөд өртөгчдийн хувьд нөлөөлөл нь хамгийн бага болохыг нотолсон, 2-оос доошгүй хувилбарын тооцоо судалгаа, танилцуулга гээд энэ зүйлийг бас бүрдүүлсэн байхыг байгаа. Өөрөөр хэлбэл чөлөөлөх газар дээрээ бол 2-оос доошгүй хувилбарын хамгийн бага нөлөөлөлтэй байх ийм судалгааг нийт 7 баримт бичиг шаардаж байгаа. Эндээсээ бол зөвхөн нэг нь ийм баримт бичиг байхаар шаардаж байгаа, бусад нь бол байршил, хил зааг, нэгж талбар, эд хөрөнгийн тоо бүртгэл, тэдгээрийн төсөөлөл гээд ингээд 7 төрлийн баримтууд шаардахаар байгаа, судалгаа хийхэд, тийм.

С.Одонтуяа: Гочоогийн Ганболд гишүүн тодруулъя.

Г.Ганболд: Яг саяынх дээр манайхан бол хуулийн цоорхойг бол олно л доо. 2 материалыг бол хаанаас ч бариад ирнэ, хажуу талынх нь айлаас 2 дахин дабльдсан үнийн санал бариад л хүрээд ирнэ шүү дээ. Тийм учраас энэ дээр заавал нээлттэй зарлах, нээлттэй зарлах ёстой, нээлттэй зарлаж байж хугацаатай нээлттэй үнийн санал авдаг, заавал 2-оос гэхгүй доод хязгаарыг нь бас тавьж өгөөд нээлттэй зарлаж байж л авна шүү. Түүнээс нэг материал бүрдүүл гэвэл 2 материал, битгий хэл 20-ыг ч олоод ирнэ, наадуул чинь. Тэр

бол сонин биш. Тэгэхээр зэрэг үүнийг ерөөсөө нээлттэй, олон нийтэд нээлттэйгээр тэр саналуудыг авдаг ийм зүйлийг заавал энэ хуулийн төсөлд оруулна шүү. Та хэд энэ дээр бас анхаарч яамныхаа энэ иргэд ажлын хэсэг дээр энэ дээр боломж байгаа биз дээ. Ер нь тодруулаад асуучихад.

С.Одонтуяа: Тодруулгад хэн хариулах вэ. Мөнхбаатар сайд 81 дүгээр микрофон.

Б.Мөнхбаатар: Тэр асуудлууд нээлттэй, ингээд хэлэлцэгдээд явахад бол санал оруулаад өөрчлөөд яриад явахад бүх юм нь нээлттэй, болно.

С.Одонтуяа: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн асуултаа асууна.

С.Ганбаатар: Энэ ер нь бол байгаа нөхцөл байдал аймшигтай учраас энэ хууль явахаас өөр аргагүй. Дээр нь нэмээд Барилга, хот байгуулалтын яам харин үүнийг бас ингээд зоригтой бариад орж ирж байна гэдэг бол бас сайн зүйл ээ. Тэгээд үүнийг харин улам сайжруулахын тулд би тодруулж асууж байгаа юм шүү.

Энэ хуулийн үзэл баримтлал дээр хуулийн төслийн танилцуулга дээр байна л даа. Хуулийн төслийг боловсруулахдаа ашигт малтмалын хайгуул, олборлолттой холбогдон гарч буй газар чөлөөлөлтийн асуудлыг зохицуулахгүй бөгөөд иргэдийн эзэмшил, өмчлөлийн газар дээр дахин төлөвлөлт хийдэг, зөвхөн тэдний зөвшөөрөл санаачилгад тулгуурлана гээд тэгсэн байгаа. Үндсэндээ шүдээ хүртэл зэвсэглэсэн уул уурхайн асар их мөнгөтэй, өөрсдийн гэсэн рекет бригадтай асар их хэвлэл мэдээллийн багтай, юу ч хийхэд бэлэн, асар их

баян бүлэглэлд тэр хувь иргэнийг газартай нь юутай хээтэй нь хаяж өгч байна л гэж орчуулагдаж байгаа шүү дээ, энэ чинь.

Би Канадад явж байхад уул уурхайн яг энэ газар чөлөөлөлтийн асуудал дээр тэр ард иргэдтэй ярихдаа ямар дүрмээр, ямар зарчмаар, ямар горимоор ярих вэ гэдэг дээд, доод хязгаарыг нь хүртэл ядаж өгсөн байдаг шүү. Норвегийн нэг одоо нэг арваад 10 гаран жилийн өмнө манай дээр ирсэн нэг бас нэг зөвлөх, бас яг үүнийг ингээд УУЯ дээр ярьж байсан, би одоо үүгээр нь зөндөө олон жил хөөцөлдөж байсан учраас. Тэгэхээр миний ярьсан энэ асуудал дээр ашигт малтмалын холбогдох тэр газар чөлөөлөлтийн асуудал дээр ард иргэдийг төрийн нэг хууль байгаа шүү дээ. Мөнгөтэй, мэдлэгтэй, эрдэмтэй баян хүнийг түр хамгаалахаасаа илүү өөрийгөө хамгаалах чадваргүй байгаа иргэдийг хамгаалах нь төрийн үндсэн үүрэг байдаг. Миний энэ ярьсан зүйл дээр та нар юм бодогдож байна уу? Энэ дээр хуулийн хэлэлцүүлгийн явцад дахин ярилцах боломж байгаа юу, эсвэл үүнийг тэр чигт нь хаяж өгөх хэвээрээ байгаа юу, 1 дүгээр асуулт.

2 дугаар асуулт, 13.2-т тэр газрын хязгаарлагдмал эрхийн газрыг тухайн газрын суурь үнэлгээгээр тооцож үнэлнэ ээ гэж байгаа юм. Тэгээд тэр 7 дугаар зүйл дээр тэр үндэслэл дээр газрын суурь үнийг зохицуулалтыг баримталж байгаагаас шалтгаалж иргэд ерөөсөө тохиролцож хүрэхгүй байгаа нь түгээмэл байна гээд ийм заалт байгаа. Энэ суурь үнэлгээ гэдэг юм чинь иргэдийн сэтгэл санаанд хүрэхгүй байна. Амьдралаас гадуур байна. Дэндүү доогуур байна гэсэн

ийм асуулт байна. Үүнийг иргэдийн тэр хүлээлт, иргэдийн тэр хүсэлтээ ойртуулах тал дээр ямар алхмууд хийсэн бэ? Түрүүн би хариултуудыг сонссон, тэгэхдээ энэ чигээр нь ингээд иргэд санаандаа дургүйцсэн хүнээрээ хүчиндүүлж, албадан маягаар өгсөн хэвээрээ байх уу? Миний асуулт 2 дугаар асуулт.

3 дугаар асуулт 14.3. Төслийн 14.3. Эдийн засгийн хувьд нүүн шилжих гэж газар чөлөөлөлтийн улмаас газар эд хөрөнгө, орлого амьжиргааны эх үүсвэрээ алдах болон газар эд хөрөнгөө ашиглах боломж нь хязгаарлах гээд хэлнэ ээ гэхсэн байгаа. Манай орны энэ нүүдэлчин малчид нүүх болоход тэр чинь амьжиргаагаа алдаад байгаа байхгүй юу, амьжиргаа гэдэг үг байгаа шүү, энэ чинь алдаж байгаа. Тэгэхээр энэ дээр энэ 2 дугаар асуудал дээр яг малчдын асуудал яаж шийдэгдэж байгаа юм, ихэвчлэн ер нь малчид, тэгээд л тэр уурхай юм чинь ямар хамаатай юм гэж малчдыг хаях гээд байгаа юм биш биз дээ. Тэгэхээр үүний үнэлгээг хэрхэн тогтоох, малчдад нутаг, газар ус, бэлчээрийг нь хэрхэн шийдвэрлэх тухайд хуульд ямар нэгэн зохицуулалт байгаа юу, нарийвчилсан зохицуулалтууд байгаа юу.

19.1-д газар чөлөөлөлтөд өртөгчид гэдэг дотор малчид гэдэг үг оруулж болох уу, тэр газар чөлөөлөлтийн өртөгчид гэж нэг нэр яваад байна шүү дээ. Энэ дээр бол ихэнх нь газар чөлөөлөлтөд өртөгчид бол манай мал ... /минут дуусав/

С.Одонтуяа: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн яг тодорхой 4 асуулт асуулаа. Нямдорж Барилга, хот байгуулалтын яамны Хуулийн

хэлтсийн дарга 80 дугаар микрофон хариулъя.

Ганбаатар гишүүний асуултад хариулъя, Барилга, хот байгуулалтын яам Нямдорж. Тэр 2, 3 дугаар асуултаас эхлээд хариулчихъя.

Тэр хуулийн төслийн 14.3-т малчдыг хамруулж болох уу гээд. Тэгэхээр малчид маань өөрөө өнөөдрийн байдлаар бол малчид маань бэлчээрийг нийтээрээ үнэ төлбөргүй чөлөөтэй ашиглаж байгаа. Өвөлжөө, хаваржаа юм уу, тийм өвөлжөө хаваржааны барилга байгууламж барьсан газраа өмчлөх, эрх эзэмших, ашиглах, гэрчилгээ авах тэр эрх нь бол нээлттэй байгаа. Тэгэхдээ яг бол бодит байдал дээр бол энэ бол яг гэрчилгээжсэн юм байхгүй байгаа. Тэгээд малчид энд хамрагдах уу гэхээр газар чөлөөлөлтийн энэ зориулалтаар газар нь чөлөөлөх шаардлагатай малчид бол өөрсдөө бол тэр энэ хуулийн төсөлд зааснаар тэр зах зээлийн үнэлгээ газарт хязгаарлагдмал эрхээр өөрөө бүртгүүлсэн бол тэр нөгөө дээр нь байршиж байгаа үл хөдлөх хөрөнгө, тэр бүгдийнхээ үнэлэх зах зээлийн үнэлгээгээр тооцож үнэлгээгээр нөхөн олговроо авна.

Мөн газрынхаа үнэлгээг бол газар тухайн газрынхаа суурь үнэлгээгээр, өөрөөр хэлбэл ЗГ-аас 3 жил тутамд энэ суурь үнэлгээг Монгол Улсын тойрог бүсчлэл, тэгээд дотор нь аж ахуйн үйл ажиллагаа, зориулалтаар нь ингээд бүсчлээд тооцсон. Энэ бол татвар ногдуулах зорилгоор, тэгээд бас энэ хөрөнгийн үнэлгээ тогтоох зорилгоор ингээд үүнийг ашиглахаар хуулийн төсөлдөө тусгасан байгаа учраас тэр суурь үнэлгээгээрээ бол явчихна. Тэгэхдээ

суурь үнэлгээ бага байгаа нөхцөлд бол тэр зах зээлийнхээ бодит үнэлгээтэй зөрүү байж байгаа бол тэр нь 3 жил тутамдаа тодотгоод өсөөд өсөөд зах зээлийнхээ үнэлгээтэйгээ нийцээд ингээд явах ийм боломжтой байгаа.

С.Одонтуяа:

Нэмж

Энхманлай, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын дарга хариулъя.

А.Энхманлай:

Ганбаатар

гишүүний асуултад тодруулж хариулъя. Газрын хязгаарлагдмал эрхээр ашиглаж байгаа газар эзэмшигч дээр газар чөлөөлөх асуудал үүсгэхэд суурь үнэлгээг баримтална гэж байгаа. Тэгэхээр бол энэ газрын суурь үнэлгээг бол ЗГ-аас тогтоодог. Тогтоохдоо бол мэдээж газрын ерөнхий үнэлгээ хийгээд энэ тухайн газрыг зах зээлийн үнэ нь яг ямар түвшинд байгаа юм түүнтэй ижил түвшинд байхаар энэ суурь үнэлгээг баталдаг. Энэ суурь үнэлгээнээс үндэслэж бид нар газрын төлбөр, татвар хураамж, мөн саяын ярьж байгаа энэ газрыг үнэлж чөлөөлөх ажил дээр бол ингэж ашигладаг байгаа. Одоо бол энэ суурь үнэлгээг л хамгийн гол нь зах зээлийн үнэтэй аль болох нийцүүлж батлагдвал саяын асуудал бол шийдэгдэх иргэд бодит үнээр газраа төрд буцаан өгөх ийм боломж бүрдэх юм.

Энэ 19.1-д заасан бас өртөгчид гэдэг байгаа. Энэ өртөгчид дотор бол малчин гэж, яг тийм, бүлгээр нь заасан юм байхгүй, ер нь бол малчид маань өөрөө бол угаасаа газрын хязгаарлал эрхтэй ийм субъект болох юм. Өөрөөр хэлбэл өвөлжөө, хаваржааны зориулалтаар газар эзэмшиж байгаа, энэ нь бол газрын барилга байгууламж барих

хязгаарлагдмал эрх авах юм. Тэгэхээр энэ бол 19.1-д, малчид өөрөө бас орж байна гэж ойлгож болно шүү. Энд бол ингэж тусгайлан бол малчид гэж бичих бол угаасаа шаардлага байхгүй, хязгаарлалууд эрхтэй этгээд гээд угаасаа энд заачихсан байгаа учраас бол энэ хуульд бол хамрагдана гэж ойлгож болно.

С.Одонтуяа: Сайнхүүгийн Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Би их тодорхой асууж байгаа л даа. Яах вэ, малчид гэж оруулж болно оо л гэж ойлгочихлоо л доо.

Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станцын тэр эрх ашиг нь зөрчигдөөд байгаа яг малчдын газрыг хэдээр үнэлсэн юм, ямар үндэслэлээр үнэлсэн юм надад нэг тодорхой ард иргэд ч гэсэн үүнийг сонсож байгаа байх, хэлээд өгөөч.

Хуулийн төслийн 6.1-д заасан, энэ дээр цахилгаан эрчим хүч гээд заачихсан байгаа. Тэгэхээр малчид гэдэг чинь зүгээр нэг хашааны айл бол бас асуудал л даа, нүүчихэд өөр газар амьдарч байна. Малчид бол тэндээс нүүхэд амьжиргаагаа тэр тэр нарийн ширхэгт өвс чинь тэдний амьжиргаа байхгүй юу даа. Ирээдүй үр садынх нь амьдрал, түүнийг яаж үнэлж байгаа вэ? Та нарын энэ суурь үнэлгээ чинь амьдралаас дэндүү хол байна, тэгээд хүмүүсийг зүгээр эрх ашгийг нь зөрчиж байна гэсэн үг.

Энэ дээр тодруулаад миний асуух гээд байгаа зүйл гэвэл төслийн 24.2 ЗГ нэгдсэн тайлан ХЭҮК-т жил бүрийн 5 сард ирүүлнэ ээ гэсэн байгаа. Төслийн 26 ... /минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ. Нямдорж 80 дугаар микрофон.

Ганбаатар гишүүний асуултад тодруулж хариулъя. Барилга, хот байгуулалтын яам Нямдорж.

Малчид Эрдэнэбүрэнгийн цахилгаан станц баригдахтай холбоотой малчид бас нөлөөлд өртөж байгаа, энэ асуудлаар бас гишүүдээс бас хуулийн төслүүд санаачилсан байсан. Тэгэхээр түүн дээр өртөж байгаа малчид болгон өөр, өөрсдийнхөө, жишээлбэл малын тоо толгой, тэгээд түүнээсээ хүртэж байгаа үржил шим ашиг гээд янз янзын хэмжээтэй байгаа. Өвөлжөө, хаваржааны байр нь ямархуу байдалтай байх вэ, тоосгон, чулуун, модон гээд л тэр нөхцөл байдлаасаа. Тэгэхээр энэ хөрөнгийн үнэлгээний энэ аргачлалаар энэ бүх материал бүх тэр олж байгаа орлого, ашиг шим тоо толгойтой нь уялдуулаад хөрөнгийн үнэлгээний тэр журмаар бол энэ аргачлалаар бол Сангийн сайд, Барилга, хот байгуулалтын сайдын баталсан аргачлалаар бол тогтоогдоод гараад ирэх боломжтой гэж үзэж байна. Тэгээд малчдыг яг энэ дээр тодорхой оруулах боломжтой юу гэдгээр бол ... /минут дуусав/

С.Одонтуяа: Нямдорж дарга дуусгаад хариулчих, 80 дугаар микрофон.

Б.Нямдорж: Одоогийн нөхцөлд бол энэ хууль маань өргөн мэдүүлсэн Газрын тухай Газрын ерөнхий хууль батлагдсантай холбогдуулаад хамт хэрэгжих учраас энэ шинэчилсэн төсөлтэйгөө уялдаад явж байх юм. Нөгөө газрын хязгаарлагдмал эрхээр газар ашиглагч гээд. Түүнтэйгээ

уялдаад явж байгаа учраас яг өнөөдрийн нөхцөл дээр бол өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар бол мал бүхий иргэд, малчид маань бол өөрсдөө бол мэдээж нөгөө газар дээр байгаа өвөлжөө, хаваржааныхаа газрыг ашиглах, эзэмших гэрчилгээгүй, тэгээд үл хөдлөхүүд бүртгэгдээгүй байгаа л даа. Тэгэхээр энэ дээр бол шилжилтийн үеийн зохицуулалтаар эд нарыг хамруулаад үнэлгээ хийгээд тэгээд явах боломж байгаа. Малчдыг бас яг энэ заалт дээрээ ярилцаад бас тодорхой яг малчин гэдгээр бол оруулах ч боломж байгаа, хэлэлцүүлгийн шатанд.

С.Одонтуяа: Ганбаатар гишүүн тодруулж асууя.

С.Ганбаатар: Эрдэнэбүрэнгийн УЦС-ын тэр нөлөөлөгдөж байгаа газарт яг малчид хэдээр амьжиргаагаа үнэлсэн юм бэ гэдгийг нь би нэг тодруулж асуусан байгаа, нэг тодорхой ойлголт авмаар байна.

2 дугаарт, энэ ЗГ энэ шийдвэрээ гаргахаасаа өмнө гаргасныхаа дараа тэр хүний эрхийг зөрчсөнийхөө дараа ХЭҮК-т явуулна, 1 жилийн дотор ч гэнэ үү явуулна гээд заасан байна. Үүний оронд ер нь энэ хүмүүсийг газраас нь чөлөөлөх гэж байна гэдэг асуудлаа ХЭҮК руу явуулаад төлөвлөгөөгөө явуулаад саналаа аваад нөгөөдүүл нь сэрэмжлүүлгээ хэлээд үүнээс чинь болж наад хүмүүсийн чинь эрх нь зөрчигдөх гээд байна, зовж зүдрэх гээд байна гэдэг сэрэмжлүүлгийн, сануулгын мэдэгдлийг нь аваад шийдвэртээ тусгадаг байж болохгүй юм уу? Тэгэхгүй зүгээр хөөж явуулчхаад, алгадаж гаргачхаад дараа нь хүний эрхийг комисс руу

явуулахад энэ хэрэг ч байхгүй. Ийм дүр эсгэсэн ардчилал шиг үүнийгээ нэг эргэж харах боломж ... /минут дуусав/

С.Одонтуяа: Нямдорж 80 дугаар микрофон.

Б.Нямдорж: Эрдэнэбүрэнгийн цахилгаан станцтай холбоотой бас яг ямархуу байдалтай байна вэ гэхээр яг энэ хуулийн төсөлтэй холбогдуулаад түүнтэй холбоотой мэдээлэл, яагаад гэвэл энэ хөрөнгийн үнэлгээ гэдэг маань илүү нөгөө тусгай зөвшөөрөлтэй, нарийн мэргэшсэн хүмүүсийн мэргэжлийн үйл ажиллагаа учраас түүн дээр бол яг ямар үнэлгээ хийгдээд яасан мэдээлэл бол байхгүй байна.

Зүгээр өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулиар бол эрх ашиг, нөлөөлөлд өртөж байгаа малчид өнөөдрийн хууль тогтоомжоор, Захиргааны хэргийн шүүхэд юм уу, дээд шатны байгууллагад нь ингээд гомдол гаргаад шийдвэрлүүлээд явах боломж бол нээлттэй байгаа. Тэр Хүний эрхийн комисст ч хандах эрх нь нээлттэй байгаа.

С.Одонтуяа: Одонгийн Цогтгэрэл гишүүн асуулт асууя.

О.Цогтгэрэл: Энэ орж ирж байгаа хуулийг товчхоноор харахаар нийгмийн хэрэгцээ шаардлагад, нийгмийн зайлиггүй хэрэгцээ шаардлагад улсаас нөхөн олговор олгоод газрыг үндсэндээ булааж авч болно. Яг товчхоноор уншвал ийм л хууль орж ирж байх шиг байна л даа. Үнэхээр бас яг утга агуулгыг нь харвал бас их аймшигтай нийтийн эрх ашиг, нийтийн төлөө гээд юу ч хийж

болдог нэг ийм л зүйл үүний цаана харагдаад байна. Ер нь энэ бид нар энэ байгуулах гээд байгаа гэдэг юм уу, амьдрах гээд байгаа энэ нийгэм чинь өөрөө хувийн өмчийг хуулиар хамгаална гэдэг үзэл санаа дээр явж байгаа хууль, энэ үзэл санаа дээр баригдсан Үндсэн хууль, түүн дээр дагуулж гаргаж байгаа бусад хууль гэж ойлгож байгаа. Тэгсэн чинь энэ дээр нийгмийн хэрэгцээ шаардлага гэдгийг нэг тодорхойлолтууд гарах юм байна, тэр нь магадгүй янз бүр болоод өөрчлөгдөөд явах байх, тэгээд тэнд нь таарсан нөхөн олговрыг тооцож гаргаад, тэгээд газрыг нь чөлөөлчихнө. Сургууль, цэцэрлэг юу ч байсан тэгээд л газар гэдэг чинь зөвхөн газар биш, үүн дээр чинь өмч, барилга байшин, хүний хөрөнгө байгаа шүү дээ. Түүнийг шууд булааж аваад, буулгаад, гоё нэрийн дор ингээд л явчихна, ерөөсөө л ингэж л уншигдаж байна. Энэ бол үнэхээр бас нэг аймшигтай л зүйл сонсогдож байна л даа.

Тэгэхээр яг энэ хууль ингээд явлаа, тэгээд эцэст нь иргэн энэ бүгдийг зөвшөөрөхгүй бол яах юм. Иргэн хүнд би энэ үнэлгээг зөвшөөрөхгүй байна, би газраа өгмөөргүй байна, би эндээ амьдармаар байна, би энд ажил үйлчилгээгээ явуулмаар байна, энэ өмчөө би ашигламаар байна гэвэл яг энэ хууль бол үүнийгээ яах юм, албадан чөлөөлөх юм уу. Төрөөс хүч хэрэглэх юм уу. Үүн дээр яг юу болох юм.

С.Одонтуяа: Барилга, хот байгуулалтын Хуулийн хэлтсийн дарга Нямдорж хариулъя, 80 дугаар микрофон.

Б.Нямдорж: Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийн гол өнөөдөр хэрэгжиж байгаагаар бол энэ эрх зүйн зохицуулалтгүй ч гэсэн газар чөлөөлөлтүүд бол хийгдээд явж байгаа. Үүний цаана хүний эрх ашиг, өмчийн өмчлөгчийн эрх ашиг хөндөгдөөд явж байгаа. Тэгэхээр үүнийг хязгаарлах, нэг талаасаа өмчлөгчийн эрх ашиг хөндөгдөж байгаа, нөгөө талаасаа төсвийн хөрөнгө үр ашиггүй зүйлд зарцуулагдаж байгаа. Ингэхээр энэ асуудлуудыг шийдэх зорилгоор орж ирсэн.

Булааж авч байгаа юм уу гэдэг дээр гол нь энэ хуулийн концепц маань ерөөсөө иргэдтэйгээ зөвшилцөх, тохиролцож байж газрыг нөхөн олговортойгоор буцааж авах гэж байгаа юм. Зөвшөөрөхгүй байгаа хэсэг дээр яаж шийдвэрлэгдэх вэ гэхээр хуулийн төслөөр бол тодотгоод тусгачихсан байгаа. Зөвшөөрөхгүй байгаа хэсэг дээр гадаадын улсуудын туршлагыг судлаад үзэхээр иргэд төрийн өмчтэй компаниуд гол нь энэ нөгөө цахилгаан хангамж, дулаан, шугам сүлжээний компаниуддаа чөлөөлөх эрхийг нь өгчихдөг. Тэгээд тэд нар нь иргэддээ албадан чөлөөлөхөөр мэдэгдэл өгөөд, иргэд нь өөрсдийнхөө эрх ашгийг хууль шүүхийн өмнө нь хамгаалаад явдаг ийм зохицуулалтууд бас байна.

Өөр нэг нөгөө 2 дахь зохицуулалт бол чөлөөлөх гэж байгаа бол чөлөөлөх гэж байгаа үндэслэл шаардлагаа шүүхийн өмнө аваачиж тавиад, ийм үндэслэлээр нийтийн эрх ашгийн үүднээс чөлөөлөх гэж байгаа юм гэдгээ шүүхэд тайлбарлаж байж шүүхийн шийдвэрээ чөлөөлөх. Тэгээд манай хуулийн төсөл бол ажлын хэсэг

дээр ярьж байгаад иргэдийнхээ аль болох иргэдийн эрх ашгийг хөндөгдөөгүй байгаа учраас иргэд өөрсдөө нэг шүүхэд гомдол гаргах шаардлагагүй юм. Нөхөн олговортойгоор авах гэж байгаа байгууллага маань өөрсдөө шүүхэд үүнийгээ нотолж байж шүүхийн шийдвэртэйгээр ингэж авах ёстой гэсэн ийм концепцоор боловсруулагдсан байгаа.

С.Одонтуяа: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулж асууя.

О.Цогтгэрэл: Одоо яг бид нар энэ ажиллаж амьдрах гэж байгаа энэ нийгмийн тогтолцоо чинь ардчилсан тогтолцоо, зах зээлийн эдийн засаг гэж байгаа юм. Үүний чинь яг үндсэн тулгуур баганууд нь хүний эрх, хувийн өмч, тэгээд шударга шүүх орох байх. Тэгэхээр тэр хүний эрх гэдэг зүйлийг хуулийн дор зөрчиж болох хувийн өмч гэдэг зүйлийг хуулиар далайлгаж зөрчиж болох энэ аймшигтай л тийм үзэл санаа үүний цаана л явж байна л даа. Магадгүй үүний цаана тэр гадаадын хөрөнгө оруулалт, үүнд итгэх итгэл олон зүйл чинь үүний цаана явж байгаа байх.

Тэгэхээр УИХ-ын дэд дарга аа, яг энэ энэ хууль дээр энэ газар албадан чөлөөлөх тухай энэ хууль дээр АН-ын бүлгээс ажлын 5 хоногийн завсарлага авъя, энэ хууль дээр. Үүнийг бас үнэхээр нарийвчилж ярих, үзэл санаа, үзэл баримтлалын хувьд ч ярих олон зүйл үнэхээр энэ асуудал дээр байгаа юм байна.

С.Одонтуяа: Тэгэхээр УИХ-ын дэгийн тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу нам, эвслийн бүлгүүд завсарлага авна. Тэгэхдээ Цогтгэрэл дарга аа, ажлын 5 хоног бол нөгөө

ерөнхий хууль дээр өгсөн юм. Одоо бусад 4 хуулийг нь бүгдийг нь ажлын 4 хоногт өгье.

Түрүүний нөгөө Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл бас түрүүнийхээ 5 байснаа бас 4 болгож өгөх нь зүйтэй. Яагаад гэхээр энэ хуулиуд ингээд бүгд уялдаж хэлэлцүүлэгдэх учраас Ерөнхий хуулиас бусад бүх 4 хууль дээр ижил завсарлага өгье.

Ингээд 4 хоногийн завсарлага өгч байна, АН-ын бүлэгт.

Өмнөх Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мөн Ардын намын бүлэгт 5 хоног байсныг ажлын 4 хоногт өгч байна.

Ажлын хэсэгт баярлалаа.

Ажлын хэсэгт баярлалаа, ажлын хэсэг явж болно, тийм.

Үгүй ээ, хурлын дарга, даргын зөвлөл дээр бас энэ хуулийг өнөөдөртөө хэлэлцэж амжихгүй юм байна гэсэн.

Тэгээд ер нь ийм ирц муу байгаа үед ингэж олон хуулийг бас хэлэлцэх нь буруу. МАН-ын бүлгийн дарга ирцээ сайн бүрдүүлчхээд хуулиа хэлэлцье.

Монгол УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19.1-д УИХ-ын дарга, хууль санаачлагчаас УИХ-д өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хороог хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол холбогдох болон

бусад Байнгын хороог зөвлөлтэй зөвшилцөн тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ гэж заасан.

УИХ-д өргөн мэдүүлсэн төслийг танилцуулъя.

1. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд. ЗГ 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан.

2. Зөвшөөрлийн тухай хууль, шинэчилсэн найруулгад нийцүүлэх, хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор боловсруулсан Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хэмжил зүйн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд. ЗГ 2022 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр өргөн мэдүүлсэн. Эдийн засгийн байнгын хороонд хуваарилсан байна.

Өнөөдрийн баасан гаригийн чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлууд дууслаа.

17.38 цаг

Хуралдаан хаасныг мэдэгдье.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ П.ОЮУНГЭРЭЛ